



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

[15 дахь жилдээ]

2016/02

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

(15 дахь жилдээ)

2016/02

ДАА 070
ННА 094
Х-828

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл
2016/02(48)
Улсын бүртгэлийн дугаар 244
15 дахь жилдээ

П.Оюунчимэг *Ерөнхий редактор (Монгол Улсын Хүний эрхийн
Үндэсний Комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор)*

Ц.Адъяахишиг *Хариуцлагатай нарийн бичгийн дарга (Монгол Улсын
Хүний эрхийн Үндэсний Комиссын ахлах референт)*

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн
Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй,
зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.

ISBN: 978-99978-4-143-8

АГУУЛГА

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

Б.Алтангэрэл

Хорих ял эдлүүлэх хууль тогтоомжид ялтны эрхийг тусгаж ирсэн нь 5

*Ц.Мөнхбат*Гадаадын иргэнийг саатуулах ба хилийн хориг тавих
хэм хэмжээг шинэчлэх зарим асуудал 11*Д.Ганцэцэг*Ажилтан, албан хаагчийг өөр ажилд шилжүүлэх тухай
эрх зүйн зохицуулалтыг зөв хэрэглэх нь 16*Л.Хаш*

Нээлттэй ба хаалттай хорих 21

Б.Болорсайхан

Ялгаварлан гадуурхахгүй байх хүний эрхийн зарчим ба соёлын нөлөө 33

*У.Эрдэнэтуяа*Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа
үзүүлэх ажиллагаа ба хүний эрх 47*Г.Золжаргал*

Хохирогчийн эрхийг хангахад тулгарч буй асуудлууд 54

*З.Өнөржаргал*Хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн эрх бүхий иргэний
сонгох эрхийн зарим асуудал 62

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

Боловсрол 2030: Инчоно тунхаглал 69
Орчуулсан Ч.Алтангэрэл

ЗОЧНЫ ЯРИА

Уул уурхайгаас хүний эрхэд үзүүлэх нөлөөлөл: Талуудын байр суурь 83

А.Мөнхзолбоо: Бид нар маш жаргалтай ажилладаг*Д.Дорждэрэм*: Малын дотор эрхтнүүдийг хүнсэнд хэрэглэхийн аргагүй болсон

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИД
ЯЛТНЫ ЭРХИЙГ ТУСГАЖ ИРСЭН НЬ

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн тэнхимийн эрхлэгч, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), хурандаа

Б.АЛТАНГЭРЭЛ

Түлхүүр үг: Нэгдсэн Үндэстний Байгууллага, хүний эрх, хорих анги, ялтан, хоригдол, төрөл, дэглэм, нөхцөл, журам

Товч агуулга: Эрүүгийн болон Эрүүгийн ял эдлүүлэхтэй холбоотой хууль тогтоомж шинэчлэгдэн боловсрогдож буй өнөө үед хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийг хангаж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлалыг нарийвчлан судлах шаардлага зүй ёсоор тавигдаж буй талаар өөрийн санал, бодлоо илэрхийлсэн болно.

Оршил

Хүний эрх гэдэг ойлголт нь товчхондоо хүн болж төрсний хувьд заяагдсан, ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран эдэлвэл зохих эрх, эрх чөлөөг хэлдэг. Хүний эрх нь хүний нэр төртэй, үнэ цэнэтэй амьдрах наад захын хэрэгцээ шаардлага оршихуйн үндэс юм.¹

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын нэгдүгээр зүйлд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил

тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд ахан дүүсийн ёсоор харилцах ёстой” гэж тунхаглажээ.

Хүний эрх нь жам ёсны шинжтэй бөгөөд хүний эдлэх эрхийг төрөөс, эсвэл хэн нэгэн хүнээс өгдөггүй, харин хууль зүйн хэм хэмжээгээ баталгаажуулж өгдөг. Хүний эрхийг үндэсний аюулгүй байдал, нийгмийн ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор хязгаарлах ба энэ нь зөвхөн хуулиар зохицуулагдсан байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энэ хуульд заасан хугацаагаар эрх чөлөөг хязгаарлаж нийгмээс тусгаарлан хорих анги, гянданд байлгахыг хорих ял гэнэ” гэж заасан байна.

Хорих ял эдэлж буй ялтны эрхийн тухай ойлголтыг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид дараах байдлаар тодорхойлон авч үзжээ, тухайлбал, доктор, профессор В.А.Туманов “Хорих ял нь гэмт хэрэг үйлдсэнийх нь төлөөх ялтны эрхийг онцгой байдлаар хязгаарлаж буй явдал юм. Энэ нь эрх чөлөөг хязгаарлах тодорхой дэглэмийн

¹ Хүний эрхийн дээд комиссарын газар. Хүний эрх ба хорих байгууллага. (орчуулсан Б.Эрдэнэбаяр). УБ.,2004.7 дахь тал

нөхцөлийг тодорхойлох, засан хүмүүжүүлэх алба болон албадлага, эрх зүйн үндсийг тогтоох, чөлөөтэй амьдрах эрхийг хязгаарлах зэрэг олон асуудлыг өөртөө багтаадаг” доктор, профессор Н.А.Стручков “Ялтны эрхийн байдал гэдэг нь тухайн этгээдийн ял эдлэх явцдаа эдлэх эрх, хүлээх үүргийн цогцолбор юм” гэсэн тодорхойлолт өгсөн байна.²

Монгол Улсын Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн салбарын судлаачид ялтны эрхийн байдлын талаар өөрсдийн бүтээлдээ дараах байдлаар тусгажээ.Тухайлбал, (Sc.D) академич С.Нарангэрэл ялтны эрхийн байдлыг профессор Н.А.Стручковтой ойролцоо утгаар авч үзсэн бол, (Ph.D), профессор А.Лхагва “Хорих ял эдлүүлэх дэглэмийн онцлогт тохирсон эрх эдэлж, үүрэг хүлээхийг хоригдлын эрхийн байдал гэнэ, энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, түүний агуулгад нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн заалтаар баталгаажин хэрэгжинэ” хэмээн тодорхойлсон байдаг.

Хорих ял эдэлж буй ялтны эрхийг хангах, хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалтыг хууль зүйн хүчин чадал, үйлчлэх хүрээгээр нь авч үзвэл:

1. Нэгдсэн Үндэсний Байгууллагаас хорих ял эдлүүлэх талаар гаргасан зарчим, хэм хэмжээ;

Хүний эрх, түүн дотроо хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаатуулах (“Хүний эрхийн түгээмэл тунхаглал”³, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт”⁴, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүний нэр төрийг доромжлон

харьцаж шийтгэхийн эсрэг конвенц»⁵ зэрэг түгээмэл баримт бичиг болон “Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм”⁶, “Хоригдолтой харьцах үндсэн зарчим”⁷, “Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүстэй холбогдуулан НҮБ-аас гаргасан журам”⁸) зэрэг олон улсын эрх зүйн эх сурвалжийг дурдаж болно. Түүнчлэн Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц⁹, Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц¹⁰, Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчим¹¹, Бүх этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай тунхаглал¹², Хоригдсон буюу саатуулагдсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон харгис хэрцгийгээр хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах ба шийтгэхээс хамгаалахад эрүүлийг хамгаалахын ажилтнууд, тухайлбал, эмч нарын гүйцэтгэх үүргийн ёс зүйн зарчмууд¹³, Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль¹⁴, Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн

⁵ 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Нью-Йорк хотноо баталж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

⁶ Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсэд хандах асуудлаар 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын нэгдүгээр их хурлаар баталж, эдийн засгийн болон нийгмийн зөвлөлийн 1957 оны 7 дугаар сарын 31-ний 663 C/XXIY, 1977 оны 5 дугаар сарын 13-ны 2076 /LXII// тогтоолоор сайшаасан.

⁷ НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/111 тогтоолоор баталсан.

⁸ НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 68 дугаар хуралдаанаар баталсан.

⁹ 1930 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталж, 1932 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

¹⁰ Ерөнхий Ассемблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан.

¹¹ Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгсэдтэй харьцах асуудлаарх 1990 оны 8 дугаар сарын 27-ны өдөр НҮБ-ын наймдугаар хурлаар баталсан.

¹² Ерөнхий Ассемблейн 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 3452 /XXX/ дугаар тогтоолоор баталсан.

¹³ Ерөнхий Ассемблейн 1982 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 37/194 дугаар тогтоолоор баталсан.

¹⁴ Ерөнхий Ассемблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 34/169 дугаар тогтоолоор баталсан.

² Х.Пүрэвсүрэн.Хүний эрх:хорих ял эдлэгсдийн эрхийн байдал. УБ,.2010.26 дахь тал

³ НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

⁴ НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200 A/XXI/ тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

зарчмууд¹⁵, Дэлхийн анагаах ухааны холбооны өлсгөлөн зарлагчдын талаарх Мальтийн тунхаглал¹⁶ зэргийг дурдахгүй өнгөрөөж болохгүй юм.

2. Монгол Улсын Үндсэн хууль;

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар;

4. Монгол Улсын бусад хууль тогтоомж (иргэний, эрүүгийн, хөдөлмөрийн, тэтгэвэр, тэтгэмжийн зэрэг) болно.

Монгол Улсад хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрхийг хангаж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал

Ялтны эрхийн талаар Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн тусгасан тухай түүхэн хөгжлийг судлах нь нэг талаар онолын болон практикын ач холбогдолтой юм. Монгол оронд Ардын хувьсгал ялсан 1921 оноос хойш 95 гаруй жилийн хугацаанд тухайлбал: 1931, 1966, 1981, 1993, 1996, 2002 онуудад хорих ял эдлүүлэх чиглэлээр батлан гаргасан хуулиуд, мөн хугацаанд төрийн дээд байгууллага, Яам, Улсын хороо зэрэг газруудаас гаргасан олон арван зарлиг, тогтоол хэдэн зуугаар тоологдох тушаал заавар бий. Эдгээрийн нилээдэд нь хорих ял эдлэгсдийн эрх, үүргийг заан тодорхойлсон байдаг.

1921-1931 он хүртэлх хугацаанд Монгол Улсын Засгийн газар, Улсын Бага Хурлаас 10 гаруй эрхийн акт батлан гарсны заримаас дурдвал: Засгийн газраас 1925 оны 5 дугаар сарын 09-ны өдөр “Шинэ гянданг байгуулахын наана хуучин гяндангийн

дотоод байдлыг арга эрэн засан сайжруулах дүрэм”-ийг батлан гаргажээ. Энэ дүрэмд ялтны орон байр, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах, элдэв халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, европ аргаар эмчлэх, хоол хүнс, хувцасны хангамжийг нэмэгдүүлэх, багш оюутан, эрдэмтдийн оролцоотойгоор ялтанд лекц уншуулах, ард иргэдээс хандив цуглуулж суллагдасдад тусламж үзүүлэх, ялтны ураг төрлийн хүмүүстэй нь тогтоосон хугацаанд уулзуулж эргэлт оруулж байх зэргийг заажээ.

БНМАУ-ын Анхдугаар Их Хурлын тогтоолын Шүүх Яамны тухай хэсэгт «Шүүх явдлын яамны Их гяндан ба улсын доторхи “олон албан газруудын байдлыг цөм европын байдалд нийцүүлэх бөгөөд аливаа ялтан, хэрэгтний бие махбодид харшгүй зохих гяндангуудыг шинэчлэн байгуулж, ялтан, хэрэгтний хоол унд зэргийг цөм нэгэн адил болгох талаар хэмжээ заавар гаргах ба уг ялтнуудыг үйлдвэрт зүтгүүлэх, сурган гэгээрүүлэх зэрэг ажлыг харъяат Шүүх Яамнаас эрхлэн даруй дүрэм хэмжээ тогтоож зохих газар батлуулан нийтээр зарлаж дагаж явуулбал зохино¹⁷ гэж онцлон тэмдэглэж байжээ.

Засгийн газрын 1929 оны 6 дугаар сарын 14-ний өдөр "Аливаа хэрэгтэн, ялтнаар ажил үйлдвэрлэл хийлгэх тухай дүрэм"-ийг батлан гаргасан ба энэ дүрэмд ялтанд хүнлэг энэрэнгүй хандсан олон заалт байдаг. Жишээ нь: дүрмийн 9 дүгээр зүйлд: "Өдөр бүр гүйцэтгэх ажлын тооцоог 08 цагаар тооцохоос гадна 18 нас хүртлэх ба газар дор онц хүнд хүчир биед хортой ажил үйлдэгсдийн ажиллах хугацааг 06 цагаас хэтрүүлж үл болно. Түүнчлэн жирэмсэн эмэгтэйгээр ажил үйлдвэр хийлгэж үл болохоос гадна эмэгтэйчүүдээр хүнд ажил хийлгэж үл болно" гэж заажээ.

¹⁵ Кубын Гавана хотод хуралдсан НҮБ-ын Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгсэдтэй харьцах асуудлаарх наймдугаар хурлаар 1990 оны 8 дугаар сарын 27-ны өдөр баталсан.

¹⁶ 1991 оны 11-р сард Мальтийн Сен Жуленсд болсон дэлхийн анагаах ухааны 43-р хурлаар баталж, 1992 оны 9-р сард Испаний Марбеллед болсон 44-р их хурлаар хянан тохиолдуулж, 2006 оны 10-р сард Өмнөд Африкийн Пиланесбергт болсон 57-р их хурлаар нэмэлт өөрчлөлт оруулсан.

¹⁷ БНМАУ-ын Анхдугаар Их Хурал. УБ., 1984, 188-189 дэх тал

Ялтны эрхийн байдал, түүний эрх зүйн зохицуулалт нь холбогдох хууль тогтоомжуудад хэрхэн тусгагдаж ирсэн байдлыг нь авч үзье.

1. 1931 оны Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн, ялтанг засан сайжруулах ажлын тухай хуулийн 6-р бүлэгт (47-55) “Өдөр шөнийн цагт үүрд цоожтой байх тасалгаанд хоригдсон хүмүүсийг өдөр тутам нэг цагаас доош бус хэмжээгээр нар салхинд гаргах, хоригдогсдод хоол ундны зүйлийг сар тутам хоёр удаа оруулах, нэг удаа уулзуулах эрх олгох, эмчлүүлж байгаа хоригдогсдын харъяаг эмчийн зааврыг баримтлан хоол ундны зүйлийг сайнаар бэлтгэн олгож байх тухай”¹⁸ зэрэг заалтууд тусгагдсан байдаг. Мөн хэрэгтэн ялтныг аливаа хэлбэрээр гутаан доромжилж болохгүй тухай заалт уг хуулийн зорилгод тусгагдсан байдгийг онцлон дурдах нь зүйтэй.

Уг хуульд аливаа хэрэгтэн ялтныг хорих ял эдлүүлэх газар байлгах дотоод журмыг нарийвчлан заасанд дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

-Хоригдогсдын хоолыг өөрсдөөр нь хийлгэхдээ эмчийн зааврыг баримтлах, түр хоригдогсдод тусгай зөвшөөрлөөр 7 хоногт нэг удаа бусад хоригдогсдод 2 удаа хоол гаднаас оруулах, ял эдлэгсдийн хувийн хувцасыг хэрэглүүлэх, байхгүй тохиолдолд сангаас хувцас олгож зөвхөн өөрт нь хэрэглүүлэх, ор дэвсгэрийг юуны өмнө урьд хоосон ядуу хоригдогсдод олгох зэрэг заалтууд байжээ.

2. БНМАУ-ын 1966 оны 03 дугаар сарын 24-ны өдөр батлагдсан Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулинд шүүхээс оногдуулсан ялыг хууль ёсоор эдлүүлж, хууль ёсыг хүндэтгэн сахиж, ял шийтгэлийг эдлүүлэхдээ хүний бие

махбодыг зовоох буюу хүн гэсэн нэрийг гутааж болохгүй гэж хуульчлан баталсан нь ялтны эрхийн байдалд анхаарч шинээр тусгасан явдал юм. Дээрх хуулийн 2 дугаар бүлгийн 19 дүгээр зүйлд ялтны эрхийн байдлыг тусгахдаа:

1.Хоол, хувцас болон материалын хангамжийг тогтоосон нормоор хэрэглэх;

2.Хийсэн хөдөлмөрийн тоо чанарт тохирсон шимтгэлийг тогтоосон журмаар авах;

3.Гэр бүл, ойрын төрөл садантайгаа биечлэн уулзах, захидлаар харилцах, эргэлтийн зүйлийг хүлээн авах;

4.Колонийн тэг гортиг доторхи дэлгүүр, мухлагаас зөвшөөрөгдсөн хэрэгцээт зүйлээ тогтоосон хэмжээнд багтаан тооцоогоор авах;

5.Тогтоосон журмаар ном, хэвлэл захиалж ашиглах;

6.Өргөдөл, гомдлыг аль ч байгууллага, албан тушаалтанд колонийн захиргаагаар дамжуулан гаргах тухай хуульчлан тусгаж, хууль ёсыг хүндэтгэн сахиж явдал ял эдлэгсдийн хувьд зөвхөн ач холбогдолтой төдийгүй зайлшгүй шаардлагатайг хуульчлан зааж өгсөн байна.

Хорих ял эдлэгсдэд социалист хуулийн энэрэнгүй үзлээр хандах тухай олон тодорхой заалт орсон нь урьдах хуулиас ялгагдах онцлогтой байв. Тухайлбал:

- Хорих ял эдэлж байхдаа үйлдвэрийн буруугаас хөдөлмөрийн чадвараа алдвал ял эдэлж дууссаны дараа зохих хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авах;

- Ялтны хөдөлмөрийг БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулиар тогтоосон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникийн дүрмийн дагуу зохион байгуулах, түүнчлэн ялтан хортой нөхцөлд

¹⁸ А.Лхагва, Х.Пүрэвсүрэн. "Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж". УБ., 2013. 18 дах тал

ажиллаж байгаа бол тэдэнд бусад чөлөөт иргэдийн адил нэмэгдэл хоол хүнс, хувцас, хамгаалах хэрэгсэл олгох мөн ажлын 8 цагтай байх, хортой нөхцөлд хорогдуулсан цагаар ажиллуулах;

- Насанд хүрээгүй хүмүүсийг ерөнхий боловсролын сургалтанд хамруулах, сургалтыг аль болох үйлдвэрлэлд чиглүүлэх;
- Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй ялтныг гяндангийн хатуу дэглэмд байлгахгүй байх;
- Хэдийгээр ялтан ч Үндсэн хуульд заасан эрх эдлэх, үүрэг хүлээх асуудлыг ял эдлүүлэх дэглэмийн онцлогт тохирсон хязгаарлалттайгаар шийдвэрлэж байх;
- Ялтны байх орон сууцны дулааныг ”+16+18” хэмээс доошгүй байлгах;
- Ялтан сайн хөдөлмөрлөж хүмүүжсэнийхээ төлөө зохих урамшил хүлээх зэргийг хуульчилж байсан байна.

3. 1981 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр батлагдан гарсан БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийн 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлд ялтны эрх, үүргийн талаар тусган, ял эдэлж байгаа гадаадын иргэд, харъяалалгүй этгээдийн эдлэх эрх, үүргийн талаар тусгаж оруулсан байдаг. Энэ талаар товч дурдвал:

- Хорих, нутаг зааж суулгах, уг нутгаас зайлуулах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдэлж байгаа этгээд нь БНМАУ-ын иргэний эрх эдэлж, үүрэг гүйцэтгэх боловч ялтны хувьд хууль тогтоомжид заасан, түүнчлэн шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол болон тухайн төрлийн ял эдлүүлэхээр хуульд заасан дэглэмийн хязгаарлалттай байна.

- Ял эдэлж байгаа гадаадын харъяат болон харъяалалгүй этгээд нь БНМАУ-ын нутагт гадаадын иргэд оршин суух тухай хууль тогтоомжийн дагуу эрх эдэлж, үүрэг гүйцэтгэх боловч ялтны хувьд хууль тогтоомжид заасан дэглэмийн хязгаарлалттай байна гэх зэргээр тусгасан байна.

4. Улсын Их Хурлаас 1993 оны 12 дугаар сарын 06-ны өдөр баталсан Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хуулийн 5,9, 20, 31-р зүйлүүдэд ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зарчим, хорих анги түүний эрх хэмжээ, ялтны эрх, ахуй нөхцөл, ялтан бусадтай уулзах, харилцах зэрэг асуудлууд хамаарагдаж байсан байна. Тухайлбал:

- Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хууль дээдлэх, хүнлэг ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хоригдлын эрхийг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, хорих ялыг ялгамжтай нөхцөлд эдлүүлэх;
- Хоригдлын эрүүл мэнд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;
- Хоригдол тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол, хувцас, байраар хангагдах, эмнэлгийн тусламж авах;
- Хоригдол ойрын садан, бусад хүнтэй түр болон удаан хугацаагаар уулзах, захидлаар харилцах, илгээмж авах, өөрийн нэр дээр мөнгөн гуйвуулга авах, явуулах;
- Сонин, сэтгүүл захиалах, хорих байгууллага дахь номын санг ашиглах;
- Өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах;
- Өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах;

- Холбогдох зардлаа өөрөө хариуцаж шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих;
- Хоригдлыг эрүүл ахуй, ариун цэврийн тусгайлан тогтоосон шаардлага хангасан байр, ахуй нөхцөлөөр хангах зэрэг ялтны эрхийн байдлыг хангах заалтуудыг дээрх хуулинд тус тус заан тодорхойлжээ.

5. Улсын Их Хурлаас 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль батлан гаргасан нь Шүүхийн шийдвэр биелүүлэх тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход чиглэгдсэн төдийгүй ялтны эрх, үүргийг урьдны (1993) хуультай нэгэн адил тусгасан байна.

6. Улсын Их Хурлаас 2002 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг батлан гаргасан. Энэхүү хуулийн 115 дугаар зүйлд ялтны эрхийг:

1.шүүхээс оногдуулсан ял эдлэх нөхцөл, журам болон өөрийнхөө эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах;

2.өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах;

3.өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах;

4.холбогдох зардлаа өөрөө хариуцаж шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих;

5.тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол, түүнчлэн хувцас, байраар хангагдах, эмнэлгийн тусламж авах;

6.энэ хуульд заасны дагуу төрөл, садантайгаа удаан, бусад хүнтэй түр хугацаагаар уулзах, утас, захидлаар харилцах, илгээмж авах, өөрийн нэр дээр мөнгөн гуйвуулга авах, явуулах;

7.сонин, сэтгүүл захиалах, хорих

байгууллага дахь номын санг ашиглах;

8.урьд тогтоолгосон өндөр насны болон бусад тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах зэрэг эрхийг хуульчилсан ба 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр ял эдлүүлэх байгууллагын ажилтны зүгээс хүнлэг харьцахыг шаардах, хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах зэрэг эрхийг шинээр тусгасан нь хорих байгууллагад ялтантай харьцах, ял эдлүүлэх нөхцөл, журмыг шинэчлэхтэй холбоотой чухал заалт болсон юм.

Дүгнэлт

1931-2002 онд батлагдан гарсан ял эдлүүлэхтэй холбоотой хууль, тогтоомжид ялтны эрхийг тодорхой хэмжээгээр тусган, боловсронгуй болж хөгжиж өнөөг хүрчээ.

Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж ирсэн хууль тогтоомжийг судлан авч үзвэл ялтны өргөдөл, гомдол гаргах, тодорхой хэмжээний хоол хүнсээр хангагдах, эргэлт уулзалт авах, эмнэлэгийн тусламж авах зэрэг эрхүүд өнөөг хүртэл хуульчлагдан ирсэн байна.

Харин хорих ял эдлэгсдийн эрхийг нэмэгдүүлэх, эрхээ эдлэх боломжийг нэмэгдүүлэх тухай заалтууд 1993-2002 онд батлагдсан хуулиудад тодорхой тусгагдан, эрх зүйн байдал сайжран, олон улсын хэм хэмжээний түвшинд ойртож очсон гэж үзэж болохоор байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсрогдож буй өнөө үед ялтны эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд хорих ял эдлүүлэх дэглэм, харуул хамгаалалтын зэрэглэл тус бүрийн нөхцөл, журмыг тодорхойлон, нийгэмшүүлэх ажлын төрөл, хэлбэрийг хуульчлах зайлшгүй шаардлагатайг судлаачийн зүгээс үзэж байна.

ГАДААДЫН ИРГЭНИЙГ СААТУУЛАХ БА ХИЛИЙН ХОРИГ ТАВИХ ХЭМ ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ



Улсын Ерөнхий Прокурорын туслах,
Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих
хэлтсийн дарга, Монголын хуульчдын холбооны
Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын
хөгжлийг дэмжих хорооны дарга

Ц.МӨНХБАТ

Оршил

1992 оны Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлнэ”¹ гэж заасан.

Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “Хүний эрхийн билл” хэмээн нэршсэн Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт зэрэг 40 орчим олон улсын гэрээ конвенцод нэгдэн орж дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө тодорхой үүрэг хүлээсэн байна.

Дээрх үүргээ биелүүлэх нэг хөшүүрэг болсон үндэсний хууль тогтоомжийн хүрээнд тухайлбал, гадаадын иргэнийг саатуулах болон тэдгээрт хилийн хориг тавих хэм хэмжээний зохицуулалтыг судалж цаашид эрх зүйн механизмыг төгөлдөржүүлж, зохистой орчинг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн судлаачийн байр сууриа илэрхийлсэн болно.

¹ Төрийн мэдээлэл УБ. 1992 №1

Нэг. Гадаадын иргэнийг саатуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт

Улсын Их хурлаас 2010 онд баталсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд саатуулах үндэслэлийг тодорхой заасан байна. Тухайлбал: 1) Хуульд заасан үндэслэлээр оршин суух зөвшөөрөл олгоогүй, эсхүл урьд олгосон зөвшөөрлийг хүчингүй болгосон буюу зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан бол иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус улсаас сайн дураараа гарахыг гадаадын иргэнд сануулах ба уг этгээд 10 хоногийн дотор Монгол Улсаас гарах үүргээ биелүүлээгүй; 2) Албадан гаргах ажиллагаанд саад учруулж, эсхүл гэмт хэрэг үйлдэж, зөрчил гаргаж болзошгүй; 3) Паспорт буюу паспортыг орлох баримт бичиггүй, эсхүл хэн болох нь тогтоогдоогүй бол иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр зургаан цагаас илүүгүй хугацаагаар түр саатуулах, түүнчлэн шүүхийн шийдвэрээр 14 хүртэл

хоногийн хугацаагаар саатуулж болох ба шаардлагатай тохиолдолд иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн уг хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно². Хуульд заасныг үндэслэн Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн сайдын 2011 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 122 дугаар тушаалаар “Гадаадын иргэнийг саатуулах байрны дотоод журам”³-ыг баталж мөрдүүлснээс хойш даруй 5 жилийн хугацаа өнгөрсөн байна.

“Саатуулагдсан этгээд” гэдэг үг нь эрх зүйн зөрчил үйлдэж шийтгүүлснээс бусад хувийн эрх чөлөөгөө хасуулсан аливаа этгээдийг хэлнэ⁴ гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан баримт бичигт дурджээ.

Хэдийгээр дээрх хууль, журамд зөвхөн “саатуулах” гэж нэрлэсэн нь үнэн хэрэгтээ захиргааны журмаар албадан саатуулж буй хэрэг юм. Гадаадын иргэнийг саатуулах байрны дотоод журмыг тусгайлан судлахад боловсруулалтын дутмаг байдал, бусад эрх зүйн актуудтай нийцээгүй, шинэчлэх шаардлагатай зэрэг асуудал зүй ёсоор урган гарч байна. Үүнд:

1. Саатуулагдсан этгээдийг байрны эмч хүлээн авч жижүүр нь энэ тухай бүртгэл хөтөлж, уг этгээдийг хүргэж ирсэн хяналтын улсын байцаагчаар уг бүртгэлд гарын үсэг зуруулж баталгаажуулснаар саатуулах ажиллагаа эхлэхээр журамд заасан нь үндэслэл муутай байна. Эрх зүйн хувьд уг этгээдийг саатуулах үндэслэл нь хяналтын улсын байцаагчийн 6 цагаас

илүүгүй хугацаагаар түр саатуулах шийдвэр, 14-30 хоног саатуулах шүүхийн шийдвэр нь болохыг зааж өгөх ёстой байсан.

2. Саатуулах шийдвэрийг биелүүлэхдээ хуулийг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, үндэс угсаа, хэл арьсны өнгө, нас, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг тусгаагүй.

3. Журамд “...холбогдох хууль тогтоомжийг англи, орос, хятад хэлээр бичиж байрлуулсан байх” гэсэн нь хэрэв саатуулагдсан этгээд эдгээр хэлийг мэдэхгүй бол яах вэ гэсэн асуулт гарч байна. Саатуулах ажиллагааг хариуцсан байгууллага, албан тушаалтны хэлээр сайн ярьдаггүй буюу ойлгодоггүй этгээд саатуулагдсан шалтгаанаа мэдэх, өөрөө өөрийгөө хамгаалах буюу өмгөөлөгчийн туслалцаа авах, эрх үүргээ тайлбарлуулах мэдээллийг өөрийн нь мэдэх хэл дээр аль болох түргэн авах, тэрчлэн орчуулагчийн туслалцааг шаардлагатай бол үнэ төлбөргүйгээр авах эрхтэй юм⁵.

4. Хүний эрх, эрх чөлөөгөө тодорхой хугацаагаар хасуулсан хэнд ч байрлах өрөө нь нэг хүнд 2.5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ногдох, мөн тухайн этгээдэд байрны захиргаанаас хучлага дэвсгэр, аяга халбага, тавьж олгох, хоолны илчлэгийн хэмжээг өдөрт 3400 ккалаас дээш хэмжээний илчлэгтэй хоолоор үнэ төлбөргүй хангах⁶ стандарт Монгол Улсад бий. Гэтэл Гадаадын иргэнийг саатуулах журмын 3.1.4 дэх хэсэгт “нэг хүнд 2 ам метрээс доошгүй талбай ногдохоор тооцсон” ба 4.2.4.2 дахь хэсэгт “халбагыг” орхигдуулжээ.

² Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийг үзнэ үү

³ Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл УБ, 2014, 708 дахь тал

⁴ Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц. НҮБ-ын 1988 оны 43/173 дугаар тогтоолоор баталсан. Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл УБ 2014. 100 дахь тал

⁵ Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц. НҮБ-ын баримт бичиг. Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж тогтоол, шийдвэрийн эмхэтгэл УБ. 2014. 101 дэх тал.

⁶ Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 23, 24 дүгээр зүйлийг үзнэ үү

5. Саатуулагдсан этгээдийн хувийн хэрэгцээний зүйлтэй байхыг зөвшөөрсөн тохиолдолд биедээ авч явах буюу хадгалахыг хориглох зүйлийг дурьдах шаардлагагүй юм.

6. Саатуулах байрны өрөө нь гадна талаасаа цоожтой, цонх нь төмөр сараалжин хамгаалалттай⁷ гэснээс үзэхэд саатуулах өрөө нь хаалгагүй байхаар зохицуулагдсан атал практик дээр өөр буюу төмөр сараалжин хаалгатай байгаа нь баривчлах, цагдан хорих байрны нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7. Саатуулах байр нь захиргааны журмаар түр саатуулах өрөөтэй байх⁸ ба түүний нөхцөл журмыг тодорхойлоогүй байхад ашиглаж байна.

8. Саатуулагдсан этгээдийн биеийн эрүүл мэндийн байдлын улмаас хугацааны өмнө суллах талаар байрны захиргаа хяналтын улсын байцаагчид болон прокурорт санал тавих⁹ гэсэн нь зохимжгүй бөгөөд хэрэв саатуулагдсан этгээдэд холбогдох зөрчлийн асуудлыг байрны захиргаа бүрэн хариуцаж буй тохиолдолд тухайн саналыг гаргаж болох талтай. Харин саатуулагдсан этгээдийн эрүүл мэндийн талаар дурьдсан албан тушаалтанд бичгээр мэдэгдэж байх нь процессын хувьд боломжтой юм.

9. Журамд заасан Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлэх, саатуулагдсан этгээд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.5 дахь хэсэгт заасны дагуу барьцаа гаргасан болон саатуулах үндэслэл арилсан¹⁰ бол Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Хяналтын хэлтсийн даргын бичгээр өгсөн

⁷ Гадаадын иргэнийг саатуулах байрны дотоод журмын 3.1.1 дэх хэсгийг үзнэ үү

⁸ Мөн журмын 3.3 дахь хэсгийг үзнэ үү

⁹ Мөн журмын 4.1.2 дахь хэсгийг үзнэ үү

¹⁰ Мөн журмын 8.1 дэх хэсгийг үзнэ үү

зөвшөөрлийн дагуу “суллах” гэсэн нь байж болохгүй асуудал бөгөөд холбогдох этгээдийг саатуулах шийдвэрийг шүүх гаргаж буй тохиолдолд хугацаанаас өмнө суллах асуудлыг мөн шүүх шийдвэрлэх нь зүйтэй юм.

10. Саатуулагдсан этгээд уулзалт эргэлт авах өдрүүд, цагийн хуваарь, утсан холбоогоор харилцах, захидал, цахилгааныг дамжуулах зэргийг байрны дотоод дэгээр зохицуулсан заалттай боловч илгээмжийг “мартжээ”.

11. Саатуулах байранд прокурор, өмгөөлөгч, улсын байцаагч болон дуудлагын эмчээс бусад гадны хүнийг зөвшөөрөлгүй нэвтрүүлэхийг хориглосон¹¹ атал Монгол Улсад суугаа гадаад улсын элчин сайд, консул, олон улсын болон хүний эрхийн байгууллагын төлөөлөгч бусад албан тушаалтныг байрны даргад мэдэгдсэний (зөвшөөрөлгүй) үндсэн дээр байранд нэвтрүүлж болно¹² гэсэн нь утга найруулгын хувьд зөрчилдөж байна. Зөвшөөрөл авах болон мэдэгдэх нь зарчмын өөр ойлголт юм.

Иймд саатуулах байранд прокурор, өмгөөлөгч, дуудлагын эмчээс бусад албан тушаалтан хувь хүмүүсийг зөвхөн тухайн саатуулагдсан этгээдэд холбогдох асуудлыг шалгаж байгаа улсын байцаагч бичгээр зөвшөөрөл олгосны дагуу нэвтрүүлэхээр журамлах ёстой юм.

12. Саатуулагдсан этгээдэд холбогдох журмын дагуу тусгай хэрэгсэл хэрэглэж болох мэт боловч энэ талаарх “журам” одоогоор гараагүй байна.

Хоёр. Гадаадын иргэнд тавих хилийн хоригийн зарим асуудал

Шүүхээр ял шийтгүүлсэн бол ялаа эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх, эсхүл

¹¹ Журмын 7.6 дахь хэсгийг үзнэ үү

¹² Журмын 7.7 дахь хэсгийг үзнэ үү

тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэх¹³ хүртэл хугацаанд тухайн этгээдийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх буюу хилийн хориг тавьж байна. Хорих ял шийтгүүлсэн гадаадын иргэн хуульд заасан үндэслэлээр ялаас чөлөөлөгдөх, ялаа эдэлж дууссан тохиолдолд хилийн хоригийг цуцалж Монгол Улсаас албадан гаргах ажиллагаа явуулах нь тодорхой байна.

Харин хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн тухайлбал: Шүүхээс оногдуулсан хорих ялыг тэнссэн, хойшлуулсан үед гадаадын иргэн ялтан Монгол Улсад байх боломжгүй нөхцөл (амьдрах байргүй, мөнгөгүй, ажилгүй гэх мэт) үүссэн тохиолдолд хэрхэх вэ? Хуулийн заалтыг баримтлан тэнсэх, ял хойшлуулсан хугацааг дуустал Монгол Улсад байлгаж “амьтан” болгох уу, үгүй юу. Элчин сайдын яамд, консулын газраас ирүүлсэн нот бичиг, хүсэлтийг судлахад эх оронд нь буцаахыг хүссэн нь олонтаа байна. Тэгэхээр эрх зүйн зохицуулалт зайлшгүй хийх шаардлагатайг харуулж байна. Өнөөгийн байдлаар манай улс Хятад, Солонгос, Канад, Орос, Энэтхэг, Польш зэрэг 9 оронтой ялтан шилжүүлэх талаар гэрээ хэлэлцээрийг үзэглэсэн нь хорих ял эдэлж байгаа иргэдтэй хамааралтай байна.

2016 онд Говь-Алтай аймгийн сум дундын шүүхийн Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэнд гэм буруутайд тооцож 1 жилийн хугацаагаар хорих ялыг оногдуулан, мөн хугацаагаар тэнсэж хянан харгалзсан Хятад улсын иргэн Г-д холбогдох асуудлыг шийдвэрлэхэд үүссэн төвөгтэй байдал үүний жишээ юм.

¹³ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийг үзнэ үү

Монгол Улсад суугаа тус улсын Элчин сайдын яамнаас тухайн ялтныг эх оронд нь буцаах асуудал тавьж байгаа ч нэг талаар хоёр улсын хоорондын гэрээнд энэ талаар тусгаагүй, нөгөө талаар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтаас шалтгаалан шийдэл гаргах боломжгүй байдалд хүрсэн. Иймд холбогдох хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулах санал гаргаж эрх бүхий яам, газар, албан тушаалтанд уламжлах шаардлагатай болж байна.

Энэхүү мухардмал байдлаас гарах одоогийн арга бол Үндсэн хуульд заасны дагуу ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхийн хүрээнд Улсын Ерөнхий прокурор шийдвэр гаргаж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн (тэнсэх, ял хойшлуулах г.м) гадаад улсын иргэний хилийн хоригийг цуцлуулан эх нутагт нь албадан гаргахаас өөр гарц харагдахгүй байна.

Гурав. Дүгнэлт

Гадаадын иргэнийг саатуулах ба хилийн хориг тавих зарим асуудал нь дотоодод нийтлэг хэрэглэж буй стандартаас хоцрогдсон, хүний эрх, эрх чөлөөг бүдүүлгээр зөрчсөн байх тул цаашид шинэчлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтэнд хүрч байна. 2016 оны эхний 11 сарын байдлаар гадаадын иргэнийг саатуулах байранд Филиппин, Хойд солонгос, Өмнөд солонгос, Хятад, Вьетнам, Унгар, Иран, Гамба, Бангладеш, Япон, Украин, Йемен, Турк, Афганистан, Сири, Австри, Нигери зэрэг гадаадын 17 орны 83 хүн саатуулагдсан байна. Дээр дурдсан эрх зүйн зохицуулалтын дутмаг байдал нь эдгээр саатуулагдсан хүн, этгээдийн хууль ёсны эрхийг зөрчихөд нөлөөлсөн байна. Статистик тоо баримтаар 2016 онд Орос,

Хятад, Малайз, Сингапур, Украин, Румын, Бангладеш улсын 22 иргэн хорих ял эдэлж, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд Америк, Солонгос, Хятад, Орос улсын 8 иргэн цагдан хоригдон шалгагдаж байна.

Цаашид гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа болон ял шийтгүүлсэн гадаад улсын иргэний эрхийг хэрхэн хангаж буй бодит байдлыг тусгайлан судлах шаардлага үүсч байна.

Дөрөв. Санал

Судалгааны хүрээнд дараах асуудлыг шийдвэрлэх санал дэвшүүлж байна.

А) “Гадаадын иргэнийг саатуулах байрны дотоод журам”-ыг шинэчилж дараах зүйлийг нэмж оруулах. Үүнд:

1. Саатуулагдсан этгээдийг хүлээж авах цаг хугацааг тогтоож шаардлагатай үед саатуулах байрны дарга сунгах;

2. Хувцас, цагаан хэрэглэлийг ариутгах, түүний хугацааг заах;

3. Хэрэгцээтэй үед нь уух ундны усаар хангах;

4. Саатуулагдсан этгээдэд байрны эмч тусламж үзүүлэх боломжгүй тохиолдолд яаралтай тусламжийн төв (103)-д хандах, шаардлагатай эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлэх боломжоор хангах;

5. Саатуулагдсан этгээд өлсгөлөн зарлавал хэрхэх зохицуулалтыг бий болгох;

6. Саатуулагсадын бие, эд зүйлд, өрөөнд үзлэг хийх давтамжийг тогтоох;

7. Хувийн хэргийг саатуулагдсан хүн бүр дээр нээж холбогдох мэдээллийг бүрэн хийх;

8. Шашны зан үйл хийх, биеийн тамирын дасгал хийх нөхцөлөөр хангах.

Б) Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн гадаадын иргэнийг Монгол Улсаас албадаж гаргах эрх зүйн баримт бичгийг эрх бүхий байгууллагууд хамтран боловсруулж батлах.

В) Гэмт хэрэг, зөрчилд холбогдож саатуулагдсан, цагдан хоригдсон, хорих ял эдэлж байгаа гадаад улсын иргэний асуудлыг цогцоор нь судалж, үр дүнг тооцон, ажил хэрэг болгох.

Ном зүй:

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл УБ. 1992 №1.

2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. 2010.

3. Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл УБ, 2014.

4. Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц. НҮБ-ын 1988 оны 43/173 дугаар тогтоолоор баталсан.

5. Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл УБ. 2014.

6. Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль. 1999.

7. Гадаадын иргэнийг саатуулах байрны дотоод журам. 2011.

8. Прокурорын байгууллагын хяналтын ажлын тоо баримт. 2016.

АЖИЛТАН, АЛБАН ХААГЧИЙГ ӨӨР АЖИЛД ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ЗӨВ ХЭРЭГЛЭХ НЬ



Удирдлагын академийн
Эрх зүйн тэнхимийн багш

С.ГАНЦЭЦЭГ

НУБ-аас 1946 онд баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй” гэж тунхаглан үүнийг гишүүн улс бүр дагаж мөрдөхийг уриалсан билээ. Хүн бүр төрийн алба хаших эрх нь тэгш байх бөгөөд гэхдээ төрийн албанаас нийтэд үзүүлэх үйлчилгээ нь өвөрмөц нарийн харилцаа шаарддаг тул төрийн алба хаших иргэнд тусгайлсан шаардлага хуулиар тавихын зэрэгцээ түүнийг алба хаших явцад хуулийн хийдэл, хуулийн зохицуулалтыг буруу хэрэглэснээс эрх нь зөрчигдөх нь цөөнгүй байна.

Монгол Улсын төрийн албаны шинэчлэлийн үйл явцын нэгэн чухал хэсэг бол төрөөс нийтэд хүргэх үйлчилгээг чанартай, үр нөлөөтэй болгохын тулд төрийн албанд дадлага туршлагатай, мэдлэг, чадвартай иргэнийг албан тушаалд зөв байршуулан ажиллуулж, ажлын гүйцэтгэлийг нь оновчтой үнэлэх тогтолцоог бий болгох явдал билээ.

Төрийн албанд мэргэшлийн өндөр үр чадвартай иргэнийг томилох нь төрийн

албаны гүйцэтгэлийг нэмэгдүүлж, үр нөлөөг сайжруулах үндэс болно.

1992 онд шинэ Үндсэн хууль батлагдаж төрийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх чадварлаг, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэх эрх зүйн үндсийг тунхагласан нь төрийн албатай холбоо бүхий харилцааг зохицуулах төрөлжсөн хууль болох Төрийн албаны тухай хууль батлах суурь нөхцөл болсон. Ингээд 1994 онд Төрийн албаны тухай анхны бие даасан хуулийг батлан гаргаснаар төрийн албаны нэгдмэл тогтолцоо бүрдсэн. Улмаар уг хуулийг 2005 онд шинэчлэн найруулж, Улсын Их хурлаас батлан өдгөө мөрдөж байна. Энэ хуулийн 17-26 дугаар зүйлд бүхэлдээ төрийн албан хаагчийн тэр дундаа төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг зохицуулж, улмаар уг хуулиар зохицуулагдаагүй харилцааг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулах боломжийг Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгээр олгосон.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт төрийн албан

тушаалыг улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний гэж ангилан, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт төрийн захиргааны, тусгай албан тушаалыг хаших албан хаагчийг төрийн жинхэнэ албан хаагч гэж заасан.

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд өргөн хэрэглэгддэг бөгөөд заримдаа маргаан дагуулдаг нэг зохицуулалт нь төрийн албан хаагчийг өөр ажилд шилжүүлэх зохицуулалт билээ.

Аль ч улсад төрийн албаны тогтолцоо мерит буюу тогтвортой, спойл буюу эвдрэх зарчмыг баримталдаг. Спойл зарчимд тулгуурлан төрийн албыг бүрдүүлэхэд улс төрийн сонгуулийн үр дүнгээс хамааран дээрх тогтолцоог шууд өөрчлөгддөг буюу шинээр бүрдүүлэхэд чиглэгддэг бол төрийн алба мэргэшсэн байх, улс төрийн сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн албан хаагчдын тогтвортой ажиллах нөхцөл, мэргэшсэн төрийн албан хаагчтай төрийн албаны чадварлаг тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн зарчмыг мерит гэнэ. Харамсалтай нь, улс төрийн сонгуулиар төрийн удирдлагад гарсан зарим хүчин төрийн жинхэнэ албаны мэргэшсэн албан хаагчийн багийг “удирдлага солигдсон” нэрээр өөр өөрийн хүнээ дэвшүүлснээр “спойл” тогтолцооны гажуудал давтагдаж сөрөг нөлөө нь үргэлжилсээр байна.¹ гэж судлаачид бүтээлдээ дурдсан.

Хөдөлмөрийн эрх зүйн онолын үүднээс үзвэл, *ажилтныг өөр ажилд шилжүүлэх* гэдэг нь түүний байгуулсан хөдөлмөрийн гэрээний гол нөхцөлүүд өөрчлөгдөх үр дагаврыг бий болгодог зохицуулалт юм. Тухайлбал, эрхлэх ажлын байр, хийх ажил үүрэг, улмаар авах цалин хөлс (гэрээний гол нөхцөл)-үүд нь өөрчлөгдөнө. Гэхдээ энэ өөрчлөлт нь түр зуурын шинжтэй

¹ Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн явц, үр дүн, хандлага судалгааны тайлан. УБ., 2014, 55 дахь тал

байдгаараа гэрээ дуусгавар болохоос ялгаатай. Өөр ажилд шилжсэн ажилтан хуучин ажил, албан тушаалдаа эргэн ирж өмнөх ажил үүргээ гүйцэтгэдэг.² Харин төрийн жинхэнэ албан хаагчийг өөр ажилд шилжүүлэхэд албан тушаалын чиг үүрэг өөрчлөгдөх үр дагавар бий болно.

Төрийн албан хаагчийг өөр ажилд шилжүүлэх зохицуулалтыг:

- ◆ Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр ажилд шилжүүлэх онцлог
- ◆ Төрийн үйлчилгээний албан хаагчийг өөр ажилд шилжүүлэх онцлог гэсэн хоёр хүрээнд үзэх нь оновчтой. Учир нь эрх зүйн зохицуулалтын хувьд ялгаатай тул ийнхүү ангилах шаардлагатай.

Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр ажилд шилжүүлэх талаар Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт зааснаар төрийн жинхэнэ албан хаагчийг өөр ажилд шилжүүлэх үндэслэл нь *“ажлын зайлшгүй шаардлага”* үүссэн байх явдал болно. Ажлын зайлшгүй шаардлага гэдгийг тайлбарласан Улсын дээд шүүхийн тайлбар байхгүй байх бөгөөд доктор, профессор Б.Уранцэцэг *“Ажлын зайлшгүй шаардлага нь ажил олгогчийн үйл ажиллагааг тасалдуулах, зогсоох сөрөг үр дагаварт хүргэж болохоор байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол гарах бодит нөхцөл байдал бий болсныг арилгаж, түүний хор уршгаас сэргийлэх, мөн уг бодит нөхцөл байдал бий болсноор нэгэнт гарсан сөрөг үр дагаврыг нь даруй арилгаж хэвийн байдал тогтоох, түүнчлэн улс орон буюу бүс нутагт бий болох нь тодорхой болсон байгалийн гамшиг буюу үйлдвэрлэлийн ослын нөхцөлийг арилгах буюу эдгээр гарсны эцэст үр дагаврыг багасгах, арилгахад*

² Уранцэцэг.Б. “Хөдөлмөрийн эрх зүй хичээлийн сургалтын гарын авлага”. УБ., 2012, 57 дахь тал.

чиглэгдсэн үйл ажиллагааг хийхээс өөр аргагүй байдлыг ойлгож болно”³ гэжээ. Ажлын зайлшгүй шаардлага нь зөвхөн ажил олгогчийн зүгээс бий болох бөгөөд тухайн нөхцөлд албан хаагч “төрийн алба тогтвортой” байх зарчмыг хангах үүднээс өөр ажилд шилжинэ. Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт зааснаар ажлын зайлшгүй шаардлага бий болсон нөхцөлд төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэхээр байна. Өөрөөр хэлбэл, шилжих гэдэг нь хоёр төрийн байгууллага хооронд үүсэх харилцаа болно. Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд 2013 онд нэмэлт орж “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалах арга хэмжээнд хамрагдсан албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно” гэсэн зохицуулалт гарсан. Үүнээс үзвэл шилжүүлэх өөр нэг үндэслэл нь хамгаалалтын арга хэмжээ авагдсан байх явдал гарч байна. Үүнээс үзвэл, төрийн жинхэнэ албан хаагч өөр ажилд шилжих үед хөдөлмөрийн харилцаа нь дуусгавар болно.

Практикт өөр ажилд шилжүүлэх шийдвэр гаргахдаа шилжин очих албан тушаалыг тодорхой заадаггүй, түүнчлэн ажлын зайлшгүй шаардлага гэдэг нь зөвхөн ажил олгогч талын хүсэл зоригийн дагуу бий болох боломжтой. Гэтэл өөр ажилд шилжүүлэх үндэслэлийг ажлын зайлшгүй шаардлага хэмээн тодорхойлж, ийм нөхцөлд албан хаагчтай тохиролцох талаар заасан нь логикийн уялдаагүй зохицуулалт болсон.

Ардын багш Б.Чимид “Африкийн тэмээн хяруулд антриктидын оцон шувууны далавчийг угсарсантай утга чанар нэгэн

³ Уранцэцэг.Б. “Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль /Онол, арга зүйн тайлбар/. УБ., 2001, 73 дахь тал.

болох буй заа” гэсэн нь сонсоход гашуун ч өдгөө үйлчилж байгаа Төрийн албаны тухай хуулийн мөн чанарыг илтгэсэн мэт байна. Учир нь, Төрийн албаны тухай хуулийг шинэчлэн батлахдаа бусад хуультай түүнийг агуулгын хувьд уялдуулж шүтэлцүүлээгүй, хууль зүйн нэр томъёог оновчтой хэрэглээгүй зэрэг олон дутагдал ажиглагдаж байна.

Үүний нэг жишээ нь 2013 онд Төрийн албаны тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд өөрчлөлт орж, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ авагдсан бол төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны үндсэн дээр өөр ажилд шилжүүлнэ гэсэн атлаа мөн хуулийн 23 дугаар зүйлд заасан түр чөлөөлөх үндэслэлд дээрх үндэслэлийг давхар оруулсан нь нэг үндэслэлийг хоёр өөр хэлбэрээр ашиглах боломжийг ажил олгогчид олгосон хийдэл үүсгэж байна.

Жишээ: Гаалийн ерөнхий газрын харъяа Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын орлогч дарга Д.Б-г албан тушаалыг нь бууруулж Дорнод аймаг дахь Гаалийн газарт гаалийн улсын байцаагчаар сэлэнгэ ажиллуулахаар шийдвэрлэхдээ Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т “Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно. Мөн хуулийн 22.2-т “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага хооронд тэдгээрийн удирдлагын харилцан тохиролцсоны дагуу ажлын тодорхой чиглэлээр 2 жил хүртэл хугацаагаар сэлэнгэ ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлэнгэ ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлэнгэ ажиллуулах хугацааг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна гэж шүүх үзсэн тохиолдол байна.

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан өөр ажилд шилжүүлэх зохицуулалтыг оновчтой болгох шаардлагатай байна. Учир нь хэрэглэх үндэслэл болон механизм нь хоорондоо зөрчилддөгөөс маргаан үүсч үүнийг шүүх эсрэг тэсрэг шийдвэрлэж байна. Ажлын зайлшгүй шаардлагаар шилжүүлэн гэсэн атлаа энэ нь зөвхөн ажил олгогчид үүсэх нөхцөл, харин ийм тохиолдолд тухайн албан хаагчаас зөвшөөрөл авахаар заасан нь хоорондоо нийцэхгүй байна.

Харин төрийн үйлчилгээний албан хаагчийг өөр ажилд шилжүүлэх үндэслэл нь Хөдөлмөрийн тухай хуулийн 32-34 дүгээр зүйлд зааснаар *ажлын зайлшгүй шаардлага, сул зогсолт, эрүүл мэндэд нь хариллахгүй өөр ажилд шилжүүлэх* зэрэг болно.⁴

Хөдөлмөрийн тухай хуулийн 32-34 дүгээр зүйлд тусгагдсан өөр ажилд шилжүүлэх зохицуулалт нь түр хугацаагаар хэрэглэгддэг, тодорхой хугацаа өнгөрмөгц ажил олгогч ажилтнаар үндсэн ажил, албан тушаалын ажил үүргийг гүйцэтгүүлэх ёстой. Гэтэл өөр ажилд шилжүүлэх үндэслэл нь хуульд тусгагдсан хэдий ч ажилтныг тэр чигт нь өөрөөр хэлбэл, бүрмөсөн шилжүүлсэн ажил, албан тушаалд үлдэх явдал гарсаар байдаг. Энэ тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын агуулга зөрчигдөж ажилтны эрх хөндөгдөж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 32-34 дүгээр зүйлд заасан ажилтныг өөр ажилд шилжүүлэх гурван үндэслэлээс хамгийн түгээмэл, буруу хэрэглэгддэг зохицуулалт нь ажлын зайлшгүй шаардлагаар өөр ажилд шилжүүлэх зохицуулалт юм. Ажлын зайлшгүй шаардлага гэдгийг тайлбарласан

⁴ Доктор, профессор Уранцэцэг.Б “Өөр ажилд шилжүүлэх гэж албан хаагч буюу ажилтны хөдөлмөрийн харилцаа хуульд заасан үндэслэлээр түр өөрчлөгдөөд эргэж хуучин байдалдаа орох” гэж тайлбарласан.

Улсын дээд шүүхийн тайлбар байхгүй. Харин доктор, профессор Б.Уранцэцэг “*Ажлын зайлшгүй шаардлага нь ажил олгогчийн үйл ажиллагааг тасалдуулах, зогсоох сөрөг үр дагаварт хүргэж болохоор байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол гарах бодит нөхцөл байдал бий болсныг арилгаж, түүний хор уршгаас сэргийлэх, мөн уг бодит нөхцөл байдал бий болсноор нэгэнт гарсан сөрөг үр дагаврыг нь даруй арилгаж хэвийн байдал тогтоох, түүнчлэн улс орон буюу бүс нутагт бий болох нь тодорхой болсон байгалийн гамшиг буюу үйлдвэрлэлийн ослын нөхцлийг арилгах буюу эдгээр гарсны эцэст үр дагаврыг багасгах, арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг хийхээс өөр аргагүй байдлыг ойлгож болно*”⁵ гэжээ.

Төрийн үйлчилгээний албан хаагчийг өөр ажилд шилжүүлэхээр хуульд тусгагдсан үндэслэлүүдээс сул зогсолт, ажлын зайлшгүй шаардлага гэсэн хоёр үндэслэлээр шилжүүлэхэд тодорхой хугацаа үйлчилдэг.

Өөр ажилд шилжүүлэх үндэслэл

Ажлын зайлшгүй шаардлага: Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах зэрэг зайлшгүй шаардлага гарсан болон байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулахад хүргэсэн урьдчилан мэдэх боломжгүй бодит нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажил олгогч нь ажилтныг хөдөлмөрийн гэрээнд заагаагүй өөр ажилд 45 хүртэл хоногийн хугацаагаар шилжүүлж болно.

Сул зогсолт: Сул зогсолтын үед ажилтныг байгууллага дотроо хөдөлмөрийн гэрээнд заагаагүй ажилд, эсхүл өөр байгууллагад түр хугацаагаар өөртэй нь

⁵ Уранцэцэг.Б. “Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль /Онол, арга зүйн тайлбар/. УБ., 2001, 73 дахь тал.

тохиролцсоны үндсэн дээр шилжүүлэн ажиллуулж болно.

Ажил олгогч санаачлан төрийн үйлчилгээний албан хаагчийг өөр ажилд шилжүүлэн ажиллуулж байх үед ажилтантай үндсэн ажил, албан тушаал дээр нь байгуулсан хөдөлмөрийн харилцаа **хэвээр хүчинтэй** үргэлжилнэ. Өөрөөр хэлбэл, уг харилцааг ажил олгогч санаачлан цуцлах эрхгүй. Гэтэл байгууллагад чиг үүрэг өөрчлөгдөх, өөр байгууллага нэгдэх зэрэг тохиолдол бүрт төрийн үйлчилгээний албан хаагчийг нэгээс нөгөө байгууллагад шилжүүлэн ажиллуулах, төрийн үйлчилгээний албан хаагчийн үндсэн ажил, албан тушаал дээр тогтоосон хөдөлмөрийн харилцааг ажил олгогч санаачлан дуусгавар болгож эрхийг зөрчиж байна.

Жишээ нь: Сүүлийн үед ажилтныг ажилд томилох гэсэн нэр томъёо гаргаж, бүтцийн өөрчлөлтөөр ажлын байр хасагдсан, орон тоо цөөрсөн, ажлын байр өөрчлөгдсөн зэрэг тохиолдолд ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцлахгүйгээр ажилтныг ажилд томилох тухай гэсэн тушаал гаргаж байна. (Эрдэнэс Таван толгой компанийн захирлын 2016.03 сарын тушаалаас)

Ажилтныг ажилд томилох гэдэг нь ямар утгатай нь ойлгомжгүй бөгөөд иргэн ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан бол ажилтан байхаар Хөдөлмөрийн тухай хуулийн 3 зүйлд заасан. Гэтэл тушаалын агуулгыг харвал, бүтцийн өөрчлөлт хийгдэж байгаатай уялдуулан нэр бүхий ажилтнуудыг өөр ажилд шилжүүлж, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн батлахыг үүрэг болгожээ.

Энд гарсан өөр нэг алдаа нь ажилтныг өөр ажилд шилжүүлэх үндэслэлд бүтцийн өөрчлөлт хамаарахгүй. Хэрэв өөр ажилд ажилтныг шилжүүлэх бол хөдөлмөрийн гэрээг шинэчлэхгүй, харин өөр ажилд шилжүүлэх тухай шийдвэр гаргана.

Мөн өөр ажилд шилжүүлэн томилох гэсэн цоо шинэ зүйлийг гаргаж энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 32-34 дүгээр зүйлийг зөрчих бөгөөд улмаар шийдвэр гаргахдаа шилжин очих албан тушаалыг тодорхой заадаггүй, хугацаа тогтоодоггүй, хуульд заасан шалтгаан үүсээгүй байхад өөр ажилд төрийн албан хаагчийг шилжүүлэх зэрэг нийтлэг зөрчил байна. Тухайлбал, Татварын ерөнхий газрын даргын 2016 оны б/76 тоот тушаалаар Гааль, татварын ерөнхий газар татан буугдсан учраас Өмнөговь аймгийн Татварын газрын даргыг албан тушаалаас нь чөлөөлсөн атлаа уг тушаалд Татварын ерөнхий газрын мэдэлд шилжүүлсэн алдаа байна. Өөрөөр хэлбэл, уг тушаалд Өмнөговь аймгийн Татварын газрын дарга гомдол гаргасан бөгөөд өргөдөлд Татварын ерөнхий газрын 2016 оны 03/473 тоот албан бичгээр хариу өгөхдөө дээрх тушаалаар таныг ажлаас халаагүй, харин шилжүүлэх буюу сэлгэн ажиллуулахаар Татварын ерөнхий газрын мэдэлд шилжүүлсэн гэжээ. Гэтэл төрийн байгууллага, салбар нэгж татан буугдах тохиолдол нь төрийн жинхэнэ албан хаагч өөр ажилд шилжүүлэх хийгээд сэлгэх үндэслэл болох боломжгүй. Энэ мэтээр төрийн албан хаагчийг өөр ажилд шилжүүлэх зохицуулалтыг буруу хэрэглэх, энэ нь хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын хооронд маргаан үүсгэх үндэс болсоор байна.

УИАН
СУДАЛГААНЫ САН

НЭЭЛТГЭЙ БА ХААЛТТАЙ ХОРИХ OPEN AND CLOSE PRISON



Санхүү эдийн засгийн
их сургуулийн эрх зүйн багш,
Өвөр Монголын их сургуулийн докторант
Л.ХАШ

KHASHI L
Legal Teacher
Institute of Finance and economics
Doctoring of Inner Mongolian University

Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн хөгжил нь харьцангуй бага түүхтэй бөгөөд Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гарах үед үйлчилж байсан Хууль зүйлийн бичиг, Жинхэнэ дагаж явах дүрмийн дараагаар 1926 онд батлагдсан Эрүүгийн хуульд хорих ялын эрх зүйн үндсийг анх удаа тусгаж өгсөнөөс хойш 90 гаран жил өнгөрч байна. Ардчилсан нийгмийн хөгжлийн чиг баримжаатай холбоотойгоор эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурал 2002 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн баталсан билээ. Эдгээр хуулиуд хэрэгжээд 13 жил өнгөрч байгаа бөгөөд энэ хугацаанд зохицуулж байсан нийгмийн харилцаанд ихээхэн өөрчлөлт гарснаар хөгжлийн шаардлагад нийцүүлэн дээрх хуулиудад нэмэлт өөрчлөлтүүд тусгагдаж байсан хэдий ч зарим өөрчлөлт хийх шаардлагатай юм. Иймээс нээлттэй ба хаалттай хорих талаар өөрийн орны Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай

хуулиудыг бусад улсын эрх зүйн тогтолцоо, эрүүгийн хууль, эрүүгийн байцаан шийтгэх хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулиудтай харьцуулан үзэх нь чухал юм.

Энэхүү асуудлын хүрээнд Монгол Улсын хорих байгууллагын тогтолцоо, эрх зүйн орчинд шинэчлэл хийх нь зүйтэй юм. Монгол Улс нь ардчилсан тогтолцоотой, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.¹ гэж Үндсэн Хуулийн тунхаг хэсэгт тодорхойлсон боловч эрүүгийн хуульд хорих ялын санкц ихтэй мөн хоригдож буй хүний эрх ашиг, нөгөө талаар ял эдэлж байгаа ялтан ч гэсэн өөрийн эрх ашиг, заяамал эрхийг эдлэх асуудалд шийдэл олох юм.

Хорих ялын онцлог: Хорих ял гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдвол шүүх Эрүүгийн хуульд заасан хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлаж, олон нийтээс тусгаарлаж, тусгай дэглэм бүхий хорих анги, гянданд албадан байлгадаг төрийн албадлагын хатуу цээрлэл агуулсан арга

¹ Монгол Улсын Үндсэн хууль 1992 он тунхаг хэсэгээс

хэмжээ юм.² Хорих ялыг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд гэхчлэн нас, хүйсийн байдлыг харгалзан тус тусад нь эдлүүлэхээс гадна ялтанд үзүүлэх эрхийн хязгаарлалтын хэр хэмжээгээр өөр хоорондоо ялгарах дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлдэг.

Энэ нь хүнд, онц хүнд гэмт хэрэгтнээс хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг, онц аюултай болон рецидив гэмт хэрэгтнүүдээс анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг тусгаарлан ялыг эдлүүлэх зорилготой байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Баривчлах байр, жирийн дэглэмтэй хорих анги, Чанга, онцгой дэглэмтэй хорих анги, Гяндан гэсэн хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу хорих ялыг эдлүүлж байна.

Мөн насанд хүрээгүй ялтныг ял эдлүүлэх, эмэгтэй ялтныг ял эдлүүлэх гэх зэрэг салган ангилсан байдаг. Практикт алба хаагчдын хийсэн судалгааны дүнгээс үзэхэд жилдээ хорих байгууллагаар дамжиж байгаа хүмүүсийн тоо 8000 байдаг.³

Улсын хэмжээнд жирийн дэглэмтэй хорих анги 10, насанд хүрээгүйчүүдийн хорих анги 1, эмэгтэйчүүдийн хорих анги 1, баривчлах ял эдлүүлэх анги 1, дамжин өнгөрүүлэх анги 1, эмчилгээний хорих анги 1, чанга дэглэмтэй хорих анги 7, онцгой дэглэмтэй хорих анги 1, гяндан 1 үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнөөгийн байдлаар насанд хүрээгүй хүн нь Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан “Хорих ангийн дотоод журам”-аар заасан эрх зүйн орчинд насанд

хүрэгчидтэй нэгэн адил нөхцөлд цагдан хоригдож, хорих ял эдэлж байна.

2015 онд гаргасан Монгол Улсын шүүн таслах ажиллагааны тайлагаас жишээ болгон дурдвал.

Ял шийтгүүлсэн хүмүүсийг зарим бүлгээр авч үзвэл: урьд ял шийтгүүлсэн хүн 1919 буюу 23,4 хувийг, гэмт хэрэг давтан үйлдсэн хүн 455 буюу 5,5 хувийг, бүлэглэж үйлдсэн хүн 1604 буюу 19,6 хувийг, согтуугаар үйлсэн хүн 1582 буюу 19.3 хувийг, эмэгтэйчүүд 718 буюу 8.7 хувийг, насанд хүрээгүй этгээд 467 буюу 5.7 хувийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулбал бүлэглэж гэмт хэрэг үйлдсэн болон урьд ял шийтгүүлж байсан хүний тоо өсөх хандлагатай байна. Ял шийтгүүлэгчдийн дотроос ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 26 хүн буюу 3.8 хувиар, бүлэглэж үйлдсэн гэмт хэрэг 190 хүн буюу 13,4 хувиар, урьд ял шийтгүүлсэн хүний тоо 221 буюу 13 хувиар, өссөн бол гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүний тоо 128 хүнээр буюу 7,5 хувиар, насанд хүрээгүй этгээдийн тоо 98 хүнээр буюу 17,3 хувиар тус тус буурсан байна.⁴

Хүснэгт 1: Ял шийтгүүлэгчид зарим бүлгээр ангилвал

д/д	Утга	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	Хувь
1	Урьд ял шийтгүүлсэн	1698	1919	221	13%
2	Гэмт хэрэг давтан үйлдсэн	504	455	-49	-9,7%
3	Бүлэглэж үйлдсэн	1414	1604	190	3,4%
4	Согтуугаар үйлдсэн	1710	1582	-128	-7,5%
5	Эмэгтэй	692	718	26	3,8%
6	Насанд хүрээгүй этгээд	565	467	-98	-17,3%

² УДШ, Ханс Зайделийн Сан. “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, 2010 он, Зохиогчдын хамтлаг. 162-163 дах тал

³ Ц.Мөнхбат. УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор. “Хорих ялын хэрэгжилт өнөөгийн байдал”, эрдэм шинжилгээний өгүүлэл, Хууль дээдлэх ёс сэтгүүл 2006 оны №2., 73 дах тал

⁴ Шүүхийн нэгдсэн тайлан “Үнэлгээ, мониторинг”, “Эрүүгийн хэсэг”. 2015 он

Оногдуулсан ялын төрөлөөр нь: торгох ялаар 285, албадан ажил хийлгах ялаар 442, баривчлах ялаар 1053, хорих ялаар 6277 хүн шийтгүүлсэн байна. Хорих ял шийтгүүлэгчдээс биечлэн эдлүүлсэн 2441, тэнсэн сулласан 3396, өршөөлд хамрагдсан 6 хүн байгаа бол насанд хүрээгүй 299 хүн, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг 135 хүнийг шийтгэх тогтоолыг хойшлуулсан байна.

Монгол Улс Нэгдсэн Үндэсний Байгууллагын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт 2 протоколд нэгдэн орсонтой холбоотойгоор цаазаар авах ял шийтгүүлсэн хүн байхгүй байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал шүүхээс баривчлах ял шийтгүүлсэн хүний тоо 18 хувиар, хорих ял шийтгүүлсэн хүний тоо 2,1 хувиар тус тус өссөн бол албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн хүний тоо 5,2 хувиар, торгох ял шийтгүүлсэн хүний тоо 3,4 хувиар тус тус буурчээ.

Хүснэгт 2: Оногдуулсан ялын төрөл

д/д	Ялын төрөл	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	Хувь
1	Торгох	295	285	-10	-3,4%
2	Албадан ажил хийлгэх	466	442	-24	-5,2%
3	Баривчлах	1034	1053	19	1,8%
4	Хорих	6148	6277	129	2,1%


Шүүхээс 2014 онд 285 хүнийг нийт 1 тэрбум 477 сая 241 мянга 600 төгрөгийн торгох ял, 502 хүнийг нийт 350 сая 666 төгрөгийн эд хөрөнгө хураах ялаар шийтгэж, тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах ялыг 244 хүнд, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 584 хүнд оногдуулжээ.

Хүснэгт 3: Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах, эд хөрөнгө хураах ял оногдуулсан хүн

д/д	Ялын төрөл	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	Хувь
1	Эд хөрөнгө хураах	405	502	97	24%
2	Тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах	92	244	152	165%
3	Тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах	586	584	-2	-0,3%


Хорих ялын хугацааны хувьд улсын хэмжээнд 2014 онд шүүхээс нийт 6277 хүнийг хорих ял шийтгэснээс 584 хүнд 1 жил, 2870 хүнд 1-3 жил, 1716 хүнийг 3-5 жил 677 хүнд 5-8 жил, 47 хүнийг 8-10 жил, 247 хүнийг 10-15 жил, 94 хүнийг 15-20 жил, 42 хүнийг 20-25 жилийн хорих ялаар тус тус шийтгэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 20-25 жилийн хорих ял оногдуулсан хүний тоо өмнөх оноос 20 хувиар, 15-20 жил хорих ялаар шийтгүүлсэн хүний тоо 1,1 хувиар тус тус өсчээ.




Хорих ялын дэглэмийн хувьд анхан шатны шүүхээс хорих ял оногдуулсан хүмүүсээс 5479 хүн буюу 87,2 хувьд ялыг жирийн дэглэмтэй хорих ангид, 756 хүн буюу 12 хувьд чанга дэглэмтэй хорих ангид, 39 хүн буюу 0,6 хувьд ялыг онцгой дэглэмтэй хорих ангид, 3 хүн буюу 0,06 хувьд ялыг гянданд эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Хорих ялын дэглэмийн төрлийг өмнөх онтой

харьцуулбал жирийн дэглэмд хорих ялыг эдлүүлэхээр шийдвэрлэсэн хүний тоо 1,9 хувиар өссөн бол чанга дэглэмд ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн хүний тоо 0,8 хувиар, онцгой дэглэмд ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн хүний тоо 17 хувиар тус тус буурсан үзүүлэлтэй байна.⁵



Ял шийтгүүлэгчдийн насны бүлэг: нийт ял шийтгүүлэгчдийг насны бүлгээр авч үзвэл 14-15 настай ял шийтгүүлэгчид 134 буюу 1,6 хувийг, 16-17 настай ял шийтгүүлэгчид 353 буюу 4,3 хувийг, 18-29 настай ял шийтгүүлэгчид 3980 буюу 48,7 хувийг тус тус эзэлж байна. Ял шийтгүүлэгчдийн дотор 18-29 настай ял шийтгүүлэгчид 3980 байгаа нь голлох хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 39 хүнээр буюу 1 хувиар, 35-аас дээш настай ял шийтгүүлэгчид 184 хүнээр буюу 8,8 хувиар тус тус өсчээ. Харин 14-15 настай ял шийтгүүлэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 72 хүнээр буюу 35 хувиар, 30-34 настай ял шийтгүүлэгчдийн тоо 32 хүнээр буюу 2,2 хувиар тус тус буурсан дүнтэй гарчээ.



⁵ Монгол Улсын Шүүн таслах ажиллагааны тайлан УБ хот 2015 он Эрүүгийн хэсэгт

Ял шийтгүүлэгчдийн боловсрол: Нийт ял шийтгүүлсэн хүмүүсээс 1102 буюу 13,4 хувь нь дээд, 2 буюу 0,02 хувь нь техникийн болон мэргэжлийн анхан шатны, 300 хүн буюу 3,6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3507 буюу 42,8 хувь нь бүрэн дунд, 1655 хүн буюу 20,2 хувь нь суурь, 997 хүн буюу 12,1 хувь нь бага боловсролтой, байгаа бол 615 буюу 7,5 хувь нь боловсролгүй хүмүүс байна. Ял шийтгүүлэгчдийг боловсролын түвшингээр нь өмнөх онтой харьцуулж үзвэл дээд боловсролтой ял шийтгүүлэгчийн тоо 15 хувиар, суурь боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 49,8 хувиар, боловсролгүй ял шийтгүүлэгчдийн тоо 4,8 хувиар тус тус өссөн бол бага боловсролтой ял шийтгүүлэгчид 1,7 хувиар, бүрэн дунд боловсролтой ял шийтгүүлэгчид 13,6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.⁶

Ял шийтгүүлэгчдийн эрхлэж байсан ажил, сургууль: нийт ял шийтгүүлсэн иргэдийн 61,1 хувь нь эрхэлсэн ажил, сургуульгүй, 5 хувь нь оюутан, 3,8 хувь нь малчин, 2,8 хувь нь сурагч, 1,8 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч, 1,2 хувь нь төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн албан тушаалтан, 0,7 хувь нь төрийн тусгай албан хаагч, 0,4 хувь нь төрийн захиргааны албан хаагч, 0,28 хувь нь ялтан, 0,19 хувь нь улс төрийн албан тушаалтан, 0,13 хувь нь цэрэг байна. Нийт ял шийтгүүлэгчдээс эрхэлсэн ажил, сургуульгүй 5000 хүн байгаа бөгөөд нийт ял шийтгүүлэгчдын 61,1 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 1,3 хувиар өссөн дүн юм. Ял шийтгүүлсэн оюутан, сурагчдын тоо өмнөх оноос буурсан дүнтэй гарчээ.⁷

Энэхүү садалгаанаас хархад баричлах ял болон хорих ял шийтгүүлэгчдийн тоо жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай байна.

⁶ Монгол Улсын Шүүн таслах ажиллагааны тайлан УБ хот 2015 он Эрүүгийн хэсэгт

⁷ Монгол Улсын Шүүн таслах ажиллагааны тайлан УБ хот 2015.03 сар

Монгол Улсын эрүүгийн хуулийн хорих ялын санкц нь гэм хохирлын хэмжээ бага байсан ч давтан үйлдсэн гэх үндэслэлээр хорих, баривчлах ял нь хорих ялын нэгэн адил ял эдлүүлэн эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа боловч хорих газар байлгаж байгаа нь тохиромжгүй юм.

Монгол Улсын хэмжээнд хорих ангид хоригдож байгаа ялтны эрх зүйн байдлын талаар дурдахад.

1. Жирийн дэглэмтэй хорих ангид хоригдож буй ялтан нь нийгмийн дунд хөдөлмөр эрхлэх (ихэвчлэн барилгын ажил, хөдөө орон нутагт) мөн хүндэтгэн үзэх шалтгаанаар 7 хоногийн чөлөө, ажлын цагаар уулзалт явуулах, жилд 8 удаа урт хугацааны чөлөө буюу 72 цагийн чөлөө авч болно.

2. Чанга дэглэмтэй хорих ангид сард 1 удаа уулзалт, жилд 4 удаа удаан хугацааны чөлөө авч болно.

3. Онцгой дэглэмтэй хорих ангид 4 сард нэг удаа уулзалт, жилд 2 удаа удаан хугацааны уулзалт авч болно.

4. Гяндан жилдээ 2 удаа уулзалт авч болно. Харин удаан хугацааны уулзалт байхгүй.

Эдгээр асуудлууд нь нэг талаас Монгол Улсын Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэрэгт тусгагдсан бөгөөд зарим талаараа хүний эрхийн асуудлыг хөндөж байгаа юм. Гэмт хэрэг хийсэн гэмт этгээд ч гэсэн тухайн хүнд өөрийн заяамал эрх, хүний эрхийн зарим асуудлыг тодорхойлох шаардлагатай юм. Монгол улсын хорих байгууллагын хувьд хүний эрхийн асуудлыг бүрэн хангах боломжгүй боловч хорих байгууллагын тогтолцоог нээлттэй хаалттай тогтолцоонд шилжүүлснээр зарим асуудлыг шийдвэрлэх боломжтой байх талтай юм.

Гадаадын эрдэмтэн, судлаачдын бичсэнийг үзвэл зарим орны хорих ангийн

төрөл, дэглэм нь пенологийн⁸ хөгжлийн үе шатуудад тухай бүр зохицсон байдлаар хөгжиж, төлөвшиж ирсэн байна.⁹ Хуучин Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын задран бутрах үед “ГУЛАГ”¹⁰-ийн тогтолцоог хуулбарлан хэрэглэж байсан “посткоммунист” гэсэн тодотголтой Эстони, Латви, Польш, Чех, Унгар гэх мэт орнууд Европын холбоонд нэгдэн орохын тулд эрүүгийн болон шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн системдээ цоо шинэ өөрчлөлт хийж, хүний эрхийг баталгаажуулсан стандартыг хүлээн зөвшөөрч, тодорхой үр дүнд хүрч байжээ.

Монгол Улс нийгэм эдийн засгийн салбарт хийж буй зарим шинэчлэл, өөрчлөлтийг Евростандартад нийцүүлэх зорилтын хүрээнд эдгээр улсын сайн туршлагыг зээлдэн авах, өөрийн хөрсөнд буулгах зэргээр бодитой ажлыг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Судалж үзсэн гадаадын улсуудад :

- Эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх;
- Хорих ял эдлүүлэх байгууллагын тухай хууль тогтоомжид өөрчлөлт хийх;
- Тусгайлсан хууль гаргах (Prison Act эсвэл Prison code)
- Эрүүгийн хууль тогтоомжийн хорих ялын хэсэгт нэмэлт, өөрчлөлт хийж хоригдлыг нээлттэй, хаалттай дэглэмд ял эдлүүлэх, ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай бодлогын баримт бичиг гаргах;
- Хүний нөөцийг шинэ нөхцөлд ажиллах бэлтгэлийг хангах зэрэг цогц арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

⁸ Penology: deterrence, prison, prison reform, prisoner abuse, prisoners' rights, rehabilitation, recidivism, retribution

⁹ Dirk Van Zyl Smit, Frieder Dьnkel, / 2011/ "Imprisonment today and tomorrow: international perspectives on prisoners' rights and prison conditions

¹⁰ "GULAG" нь хорих ангийн төрөл, дэглэмийн социалист системийн үеийн нэн түгээмэл хэлбэр бөгөөд хүний эрхийг ихэд дордуулсан, бусад байдлаар нэр төрийг нь гутаан доромжилж эрүүдэн шүүж харьцдаг байсан систем. Одоогийн зарим постсоциалист орнууд ЗСБНХУ-ын хорих ангийн төрөл дэглэмийг хуулбарлан хэрэглэж байв.

Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй хаалттай тогтолцоонд шилжүүлэх талаар зарим улс орны туршлага.

1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хууль тогтоомж нь олон хууль (Эрүүгийн хууль, Шоронгийн тухай хууль зэрэг)-ээс бүрддэг. Ялтныг нийгмийн өмнө хариуцлага хүлээхүйц, нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэх, түүнийг нээлттэй хаалттай төрөл дэглэмд ялгамжтай эдлүүлэх зорилгыг эрүүгийн хууль (1975 он) агуулсан байдаг.¹¹ 1976 онд батлагдсан “Шоронгийн хууль” (Prison Act) тус тус хамаарна.¹² Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Шоронгийн тухай хуулийн зорилго нь хорих ялын нээлттэй хэлбэр ялтныг хэвийн амьдралд эргүүлэн оруулах, хуульд захирагдах, өөрийн үйлдлийн аливаа хариуцлагыг хүлээх, хэвийн ажиллаж амьдрахыг хангаж хариуцахад сургадаг. Энэ зорилгын үндсэн ачааллыг хорих байгууллагын нийгмийн алба үүрдэг.

Тус улсад харьцангуй хөнгөн гэмт хэрэг үйлдсэн цөөн жилийн хорих ялтай ялтнуудыг нийгэмд дасгах, хөндийрүүлэхгүй байх зорилгоор суллагдахаас нь өмнө “нээлттэй” ангид байлгадаг.

Хорих ангийн нээлттэй хэлбэр нь

- *Гэртээ харихад бэлтгэх* (Preparations for Release),¹³ Гэртээ харихад бэлтгэх дэглэм нь хуанлийн 21 өдрийн өмнөөс
- *Богино хугацааны хорих хэлбэр*, богино хугацааны хорих хэлбэр нь хорих байгууллагаас гадуур өдөрт хэдэн цаг ажил эрхлэх боломж олгодог
- *Ажил хөдөлмөр эрхлэх дэглэм* гэсэн гурван ялгаатай дэглэмтэй. Ажил

хөдөлмөр эрхлэх дэглэм нь хорих ангийн хяналтаас гадуур хөдөлмөр эрхлүүлдэг. Энэ хэлбэр нилээд түгээмэл бөгөөд Германы нийт хорих ангийн 60 хувь нь ийм нөхцөлтэй байна.

1980-аад онд Германы Хууль зүйн яамны дэргэд “Нийгмийн тусалцааны хүрээлэн” байгуулагдсан ба тэнд хөдөлмөрийн зах зээлийг судалж, гол компани, бусад аж ахуйн нэгж болон шаардлагатай бусад байгууллагатай холбоотой ажиллаж, суллагдаж буй хүмүүст гэр бүлийн болон санхүүгийн бэрхшээлээ гэтлэхэд нь туслахуйц зөвлөгөө өгдөг байна.

Хорих байгууллагын захиргаа, нийгмийн ажилтнууд хөдөлмөрийн биржтэй нягт харилцан ажиллаж, аж ахуйн аль чиглэлийн байгууллага өргөжин тэлж байгааг харгалзан тэнд ажиллах мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр сургалтын материаллаг баазыг бүрдүүлж байдаг.

Ялтны хорих ял эдлүүлэх ажиллагааг хэд хэдэн үе шатанд хуваадаг:

- Хорих байгууллагын нөхцөлд дасах үе;
- Засран хүмүүжих үе;
- Суллагдахад бэлтгэх үе.

Хорих ял эдлэх бүхийл үе шатанд нийгмийн ажилтан тэднийг судалж, хувийн хэрэгт нь төлөвлөгөөний дагуу дүгнэлт бичиж байдаг. Энэхүү төлөвлөгөөнд:

1. Хаалттай болон нээлттэй хорихын аль нөхцөлд байх;
2. Ижил харьцаа бүхий хэсэгт бусадтай хамт байж болох эсэх;
3. Ажил хийх, мэргэжил эзэмших, мэргэших болон давтан сургалтад хамруулах;
4. Мэдлэгээ дээшлүүлэх;
5. Тусгайлсан тусламж үзүүлэх;
6. Ял эдлэх нөхцөлийг хөнгөрүүлэх;
7. Суллагдахын өмнө ажил гүйцэтгэх гэсэн хэлбэртэй байна.

¹¹ <http://www.germanlawjournal.com/article.php?id=31>

¹² http://www.cgerli.org/fileadmin/user_upload/interne_Dokumente/Legislation/Prison_Act.pdf

¹³ Prison act Section 134

Чөлөөт амьдралд оруулахын тулд хорих ялын дэглэмийг бууруулж болох ба суллагахаас 3 сарын өмнө 7 хоногийн чөлөө олгох, мөн хорих байгууллагаас гадуур чөлөөтэй явах эрхтэй ялтанд сар бүр 6 хоногийн чөлөө олгодог. Энэ нь дээр дурдсан 3 төрөл дэглэмийн онцлогт тохирсон байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хорих ангийн нээлттэй төрөл, дэглэмийг үзвэл тус улсын Эрүүгийн хуулиас гадна “Ял шийтгэлийн тухай хууль” (Penal Code), “Шоронгийн хууль” (Prison Act) гэх мэт салбар хуулиуд үйлчилдэг, хорих нээлттэй хэлбэрүүд болох гэрт нь харихад бэлтгэх хэлбэр, богино хугацааны хорих хэлбэр зэрэг нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн “баривчлах”, “албадан ажил хийлгэх ял” гэх зэрэг хэлбэрийн хувьд төстэй мэт боловч тухайн улсын ялын тогтолцооны онцлогтой бүрэн нийцсэн, зарчим, зорилгын хувьд эрс ялгаатай байгаа юм.

2. Эстони Улс: Постсоциалист орон гэгдэх энэ улс Европын холбоонд амжилттай нэгдэн орохын тулд 1994 онд Эрүүгийн хууль (Criminal code) болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх (Code of Enforcement procedure) тухай хуульдаа зарчмын шинжтэй өөрчлөлт хийжээ.¹⁴ Ингэснээр өмнө байсан “ГУЛАГ”-ийн хорих лагераас бүрэн татгалзаж хорих ялын төрөл, дэглэмийг

- Хаалттай хорих (Closed prison)
- Хагас хаалттай хорих (Semi-closed prison)
- Нээлттэй хорих (Open prison) гэж ангилсан байна.

Тус улс хорих ангийн нээлттэй хэлбэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 98, 119-124 дүгээр зүйлд заахдаа ажил хөдөлмөр эрхлэх боломжтой

байх, гэр бүлийнхэнтэйгээ уулзаж, өөрт тохирсон хөдөлмөр эрхлэх талаар оруулсан байна. Тус улс 1996-1997 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон хорих байгууллагадаа томоохон өөрчлөлт, шинэчлэл хийж улмаар 2000 онд Шоронгийн тухай хууль (Prison Code)-ийг батлан гаргажээ. Энэ хуулийг батлан гаргахдаа Герман, Франц улсын холбогдох хуулиудын зарим хэсгийг судлаж үзсэний үндсэн дээр “зээлдэн” авч хэрэглэсэн байна.

3. Их Британи Хорих байгууллага нь Дотоод хэргийн яаманд байх бөгөөд дараах хэлбэртэй байна.¹⁵

- 3-аас дээш жилтэй ялтнуудын нэгдсэн хорих анги;
- 12 сараас дээш ял эдлэх анх удаа ял шийтгүүлсэн ялтнуудын хорих анги;
- 21-ээс дээш насны гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн хорих анги;
- Анх удаа гэмт хэрэг үйлдсэн ялтнуудын хорих анги;
- 21 хүртэл насны хүмүүст зориулагдсан хорих анги;
- Насанд хүрээгүйчүүдийн богино хугацаагаар засан хүмүүжүүлэх төвүүд байдаг.

Ялтны ял эдлэх хугацааг дараах байдлаар ангилдаг Үүнд:

1. Туршилтын хугацаа (ганцааранг нь байлгах)
2. Засан хүмүүжүүлэх үе (хамтаар байлгаж, хөдөлмөрт татан оролцуулах)
3. Хугацаанаас өмнө тэнсэн суллах (ялын 4/3-ийг эдэлсэний дараа)

Засан хүмүүжүүлэх болон суллахын өмнө байршлын завсар шилжилтийн үе гэж болох “хагас чөлөөтэй үе” байдаг бөгөөд энэ үед хянагчгүйгээр ажилд гарч, гадна орчинтой чөлөөтэй харьцдаг энэ хэлбэр өөр олон улсад түгээмээл тархсан байдаг

¹⁴ <http://legislationline.org/documents/action/popup/id/5715/> холбогдох хуулийг хавсаргав/

¹⁵ <http://legislationline.org/documents/action/popup/id/7236>

нь нийгмийн амьдралд амжилттай дасахад чухал ач холбогдолтой.

4. Америкийн Нэгдсэн Улсын шийдвэр гүйцэтгэх байгууллага нэг талаас Хууль зүйн яам, нөгөө талаас оршин байгаа нутаг дэвсгэрийн засаг захиргаанд давхар харьяалагддаг. Хорих ялыг:

- Холбооны;
- Мужийн;
- Орон нутгийн ял эдлүүлэх байгууллагад эдлүүлдэг байна.

Орчин цагийн Америкийн Нэгдсэн Улсын ял эдлүүлэх байгууллагын бүтцэд “Оборн систем”¹⁶ голлох байр суурь эзэлдэг ажээ. Америкийн Нэгдсэн Улсын хорих ангиудад хатуу тогтоосон болон уян хатан тогтоосон дэглэм журам аль аль нь үйлчилдэг байна.

Америкийн Нэгдсэн Улсад хорих ангийг дараах гурван төрөлд ангилдаг:

1. Дээд зэргийн хяналтын түвшинтэй хаалттай хорих
2. Хамгаалалтын дунд түвшний хорих, “энэ нь ялтан номын санд очих, салхинд гарах боломжтой”
3. Хялбаршуулсан түвшний хорих буюу “нээлттэй хорих”

Нээлттэй хорих анги нь зэвсэглэсэн хамгаалалтгүй, хөнгөн дэглэмтэй, хоригдогсад нь гадны байгууллагад хөдөлмөр эрхлэх эрх эдэлдэг байна. Нээлттэй дэглэмд хорих ял эдлэгсдийн эрхэлдэг хөдөлмөрийн гол чиглэл нь барилга байгууламж барих, зам засах, хөдөө аж ахуйн болон бусад ажил байдаг. Түүнчлэн насанд хүрээгүйчүүдийн хорих ялыг хүмүүжлийн сургуульд эдлүүлдэг, дэглэм, харуул хамгаалалтын нөхцөл насанд хүрэгчдийнхтэй жишихэд харьцангуй зөөлөн байдаг.

¹⁶ Америкийн Нэгдсэн Улсын ял эдлүүлэх тогтолцоо нь муж улс бүхэнд өөр байдаг бөгөөд Оборн нэртэй хорих ял эдлүүлэх хэлбэр түгээмэл байдаг.

Насанд хүрээгүй хоригдлууд өдөрт нь хорих ангийн байрлалд байрлан ажиллаж, сурах бөгөөд шөнө нь гэртээ очиж хонож болдог. Энэ нь хоригдлуудын хүмүүжилд нааштай нөлөө үзүүлдэг. Америкийн Нэгдсэн Улсад сүүлийн үед эрх чөлөөг нь хэсэгчлэн хязгаарлах, тухайлбал хорих байгууллагаас гадуур байж сурч, ажиллахаа хэвийн үргэлжлүүлэх шийтгэлийн хэлбэр нилээд түгээмэл болж байна.

5. Япон Улс нь: “Суллагдагсад тусламж үзүүлэх тухай”, “Насанд хүрээгүй ялтны ялыг эдлүүлэх байгууллагын тухай”, “Шоронгийн тухай хууль” болон бусад эрх зүйн актуудаар энэхүү харилцааг зохицуулдаг байна.¹⁷ Япон Улсын Эрүүгийн хуульд заасан ял нь

1. Бага хэмжээний торгууль;
2. Торгууль;
3. Баривчлах;
4. Албадан болон албадан хөдөлмөрлүүлэхгүйгээр хорих;
5. Цаазаар авах гэсэн төрлүүдтэй¹⁸.

Ял эдлүүлэх байгууллагын бүтцэд урьдчилан хорих байр, насанд хүрэгчдийн болон насанд хүрээгүйчүүдийн хорих байгууллага багтана. Японы ял эдлүүлэх байгууллага нь нилээд төвлөрсөн боловч нарийвчилсан ангилалтай байдаг.

Хорих ял шийтгэгдсэн ялтныг:

- Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн;
- Гадаадын иргэн;
- 8 аас дээш жилийн хорих ялтай;
- 20 хүртэлх насны залуучууд;
- Эрүүл мэндийн байдал сул, өвчтэй хүмүүс гэдгээр тус тус ангилдаг.

Хорих ангийн нээлттэй системийг бага хэмжээгээр хэрэгжүүлж хоригдлыг хүмүүжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь хөдөлмөр гэж үздэг. Хоригдлууд нь өдөрт 8, долоо хоногт 44 цаг ажилладаг байна.

¹⁷ <http://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/PC.pdf>

¹⁸ <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?ft=1&re=02&dn=1&x=0&y=0&co=01&ia=03&ky=criminal+law&page=58>

6. Оросын Холбооны Улс 1996 онд батлагдан гарсан Эрүүгийн ял эдлүүлэх хууль нь 1998, 1999, 2001 онуудад нэмэлт өөрчлөлтийг оруулсан бөгөөд бүтцийн хувьд 8 хэсэг, 24 бүлэг, 190 зүйлээс бүрдэнэ. ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хууль нь Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуультай зарчмын хувьд олон зүйлээр ялгаатай.

Энэхүү хуулиар ОХУ-ын эрүүгийн ял эдлүүлэх нийтлэг үндэслэлийг “Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг хүмүүжүүлэх болон бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино” гээд хуулийн зорилгод арга хэрэгсэл, хэв журмыг тогтворжуулах, ял эдлэх нөхцөл байдлыг хангах, ял эдлүүлэх арга хэлбэрийг тодорхойлох, тэдний эрхийг хамгаалах, зөвхөн хуульд зааснаар л эрхийг нь хязгаарлах, нийгэмд дасан зохицох, нөлөөлөл, тусламж үзүүлэх, гэж тодорхойлоод хоригдлыг нийгмээс тусгаарлахгүйгээр ял эдлүүлэх, баривчлах, хорих ял эдлүүлэх нөхцөл, журам, ял эдлэгсдийг суллах, суллагдасдад үзүүлэх тусламж, дэмжлэг, хяналт тавих арга, хэлбэр, цаазаар авах ялыг хэрхэн хэрэгжүүлэх талаар эрх зүйн зохицуулалтыг хийж өгсөн байна. ОХУ-ын хорих байгууллагууд нь дараах төрөлтэй байна.

1. *Суурингийн колонид* урьд нь хорих ялаар шийтгүүлж байгаагүй, хөнгөн болон хүндэвтэр гэмт хэргийг санамсар, болгоомжгүйн улмаас үйлдсэн хоригдлууд.
2. *Хумуужлийн колонид* шүүхийн шийтгэх тогтоол гарах үед 18 насанд хүрээгүй эрэгтэй, эмэгтэй хоригдлууд, шүүхээс уг колонид 21 нас хүртэл нь ял эдлүүлэхээр тогтоосон хоригдлууд.
3. *Эмчилгээний колонид* шүүхээс уг колонид ял эдлэхээр заагдсан, архаг

архичин, сэтгэл мэдрэлийн өвчтэй, хүний асрамжинд байдаг мансуурах бодисонд донтогсод, урьдчилан хорих байрны аж ахуй, үйлчилгээнд ажиллахаар заагдсан хоригдлууд;

4. *Журийн дэглэмтэй колонид* чанга, онцгой, гяндангийн дэглэмээс бусад дэглэмд хоригдохоор заасан этгээдүүд болон эмэгтэй хоригдлууд.
5. *Чанга дэглэмтэй колонид* онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, дахин давтан гэмт хэрэг үйлдэгсэд, онц аюултай гэмт хэрэгтнүүд болон урьд нь ял шийтгүүлж байгаагүй, анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэйчүүд, мөн онц аюултай гэмт хэрэгтнүүд, эсвэл урьд нь ял эдэлж байгаагүй онц аюултай гэмт хэргийг үйлдсэн эрэгтэй, эмэгтэй этгээдүүд.
6. *Онцгой дэглэмтэй колонид* бүх насаараа хорих ял шийтгүүлсэн эрэгтэйчүүд, мөн онц аюултай гэмт хэрэгтэн эрэгтэйчүүд.
7. *Гяндангийн дэглэмд* онц аюултай гэмт хэрэгт 5-аас дээш жилийн хорих ялаар шийтгүүлсэн этгээд болон онц аюултай гэмт хэрэгтний ялын хугацааны зарим хэсгийг эдлүүлж болно.

7. БНХАУ-ын шоронгийн ажлын нийгэмшилтийн үндсэн ухагдахуунд дараах ойлголтуудыг үзэж болох юм. Шоронгийн ажлын мөн чанар дээрээс авч үзвэл шорон нь нийгмийг түшиж ялтны дахин нийгэмшилтийг ахиулах явдал болно. Ялтны гадаад орчинтой харилцах завшааныг нэмэгдүүлнэ. Сурган хүмүүжлийн эх баялагыг гүйцэт ашиглаж зах дэлгүүрийн соёлын шаардлагыг нэмэгдүүлэн ялтны сурган хүмүүжлийг нийгэмтэй ойртуулж нийгмийн шаардлагад тохиролцуулах. Ялтны шоронгоос гадуур хянан хамаарах ба шоронгийн дотор

хөдөлмөр хийлгэх хугацааг багасгах зэрэг аргаар ялтныг сурган хүмүүжүүлэх загварыг нийгэмчлүүлэх. Шоронгийн орчин тойрны бүтээн байгуулалтыг нийгэмчлэх шинжлэх ухаанч төлөвлөлт ба бүтээн байгуулалтаар шоронгийн орчин тойрныг ногооруулж сайхан болгож шорон доторх дэлгүүр, номын сан зэрэг газар бий болгож ялтны урмыг хөгжөөж сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах.

Шоронгийн ажлын нийгэмшилтийн үйлдлийн туршлагын хувьд:

- Нээлттэй сурган хүмүүжлийг хэрэгжүүлсэн
- Хавсран жолоодох гэрээг тогтоосон
- Нийгмийн хүчнийг ашиглан ялтанд тусгай мэргэжлийн боловсрол хийх
- Туршин ажиллах, туршин сурах зэрэг ажлыг зохион байгуулсан
- Шоронгийн ажлыг ил болгох ажлыг хэрэгжүүлсэн
- Ар гэрийн хүмүүст нь ялтантай уулзахаар ирэхийг зөвшөөрсөн
- Хотын зах орчим сурган хүмүүжүүлэх ажлыг түлхүү явуулсан.

Судалгааны дүгнэлт

ХБНГУ, Эстони, Их Британи, ОХУ, Япон, АНУ, БНХАУ гэсэн орнуудын хорих ангийн нээлттэй хаалттай дэглэм, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан үзэхэд тухайн улсууд нь эрх зүйн тогтолцооны онцлогоос шалтгаалаад хорих ангийн төрөл дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэхдээ дараах байдлаар шийдвэрлэжээ. Үүнд:

№	Орнууд	Хэрэгжүүлсэн арга зам
1	Япон	Эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх
2	Эстони, ХБНГУ, АНУ, Их Британи	Тусгайлсан хууль гаргах (Prison Act or Penal Code)

3	ОХУ	Эрүүгийн хууль тогтоомжийн хорих ялын хэсэгт нэмэлт, өөрчлөлт хийж хоригдлыг нээлттэй, хаалттай дэглэмд ял эдлүүлэх, ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай бодлогын баримт бичиг гаргах
---	-----	---

Эрх зүйн тогтолцооны онцлогоос шалтгаалан хорих ялыг эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт адилгүй боловч бүхэлдээ хорих ялыг эдлүүлэхдээ хорих байгууллагад ажиллах хүний нөөц, боловсон хүчний чадавхжуулалт, ялтныг нийгэмшүүлэх тодорхой төрлийн ажлууд, эргэлт уулзалт, хөдөлмөр эрхлэх боломж, хоригдлын ял эдлэх орчин зэргээрээ ялгагдаж байна.

Ялтныг нийгэмшүүлэх ажлыг нийгмийн ажил төрөл хэлбэр хэмээн үзэж тусгайлсан хуулиар зохицуулж байгаа улс байхад хөтөлбөр гарган хэрэгжүүлж байгаа жишиг ч байна. Ял эдлэж байгаа хүмүүсийг нийгэмд дасан зохицоход нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ажил нь нийгмийн үйлчилгээний нэг төрөл бөгөөд¹⁹ үүнийг зарим орны туршлагаас үзэхэд төрийн аль нэг институтээр гүйцэтгүүлдэг байна.²⁰

Хорих ангийн нээлттэй төрөл, дэглэмтэй дээрх орнуудын хувьд ялтныг хөдөлмөр эрхлүүлэх эрх зүйн зохицуулалтыг дэлгэрэнгүй болон тодорхой зааж өгсөн байна. Энэ нь :

- Хорих байгууллагаас гадуур хөдөлмөр эрхлэх, (Эстони)
- Хорих байгууллага дотор буюу

¹⁹ Шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгэмшихэд нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ойлголтыг гадаадын зарим оронд нийтлэг байдлаар "resocialization эсвэл reintegration and rehabilitation of criminal offender" хэмээн томъёолдог бөгөөд тусгайлсан институтууд энэхүү үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх үүрэгтэй байна.

²⁰ Америкийн Нэгдсэн Улсад Halfway house нэртэй нэгж нь хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг 120-180 өдөрт шаардлагатай бол түр байршуулах хэлбэрээр эргэн нийгэмшихэд нь дэмжлэг үзүүлдэг бөгөөд хагас хяналттай үүндээ цагдаагийн байгууллагын туслалцааг авах хэлбэрээр хамтран ажилладаг.

суллагадааас өмнө хөдөлмөр эрхлэх (ХБНГУ)

- Гэрээгээр хөдөлмөр эрхлэх (АНУ, ОХУ, Япон)
- Шүүхээс ногдуулсан хорих ялыг хөдөлмөр эрхлэх хэлбэрээр солих гэх мэтчилэн ялгавартай тусгаж өгсөн ч хорих ангийн хаалттай дэглэмээс ялгагдах гол шинж нь ажил хийлгэх, хөдөлмөр эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэнд байна.

Дурдсан орнуудад ялтны хөдөлмөр эрхлэлтийг явуулахдаа энэ талаар бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө, журам, заавар гаргахдаа юуны өмнө хорих ангид хөдөлмөр эрхлэх сургалт, дадлагажуулалтын асуудлыг шийдвэрлэсний дараагаар эрхлэх хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгажээ. Зарим оронд тухайлбал Эстони Улсын Хорих ял эдлүүлэх тухай хуулийн зүйл, хэсгийг үзэхэд хорих ангийн гадна хөдөлмөр эрхлэх хугацаа, хорих ангид байх хугацаа, ажлын хөлс, сургалт, хөдөлмөр эрхэлж болохгүй байдал, насны хязгаар гэсэн байдлаар нэг бүрчлэн тодорхой хуульчилжээ.

Санал

Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэхэд анхаарах дараах бүлэг асуудлыг анхаарах. Үүнд:

Нэг. “Баривчлах ял”-ийг хорих ялын альтернативыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу эдлүүлэх шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, хорих ангийн нээлттэй байх хувилбарыг хэрэгжүүлэхдээ иргэнд дөхөмтэй хувилбарыг сонгож авах.

Хоёр. Гадаадын зарим орны сайн хувилбарыг өөрийн хөрсөнд буулгаж “нутагшуулах”-даа зөвхөн нээлттэй гэсэн нэр томъёонд анхаарахаас илүүтэй ялтныг

хөдөлмөрлөх, нийгэмд ажиллаж, гэр бүлийнхэнтэйгээ холбоотой байх боломж олгосон, хүний эрхийг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх буюу хүний заяамал эрхийг бүрэн хангах, олон улсын стандартад нийцсэн байх шинжийг энэ тэргүүнд харгалзах. (хөдөлмөр эрхлүүлэх нөхцөл, хязгаар, хорих ангийн дотор болон гадна хөдөлмөр эрхлэх зэрэг боломжийг тусгах.)

Гурав. Хоригдлын хөдөлмөрлөж хохирлоо нөхөн төлөх бололцоог хангах ажлыг зохион байгуулж, үүнд аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, тэдгээрийг урамшуулах санхүүгийн болон бусад арга хөшүүргийг олох. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан ажилладаг туршлагыг харгалзах. Анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялаар шийтгэгүүлсэн ялтнуудын хорих ял эдлэх хугацаандаа эрхэлсэн ажил хөдөлмөрийг ажилласан жилд оруулан тооцох асуудлыг судлах.

Ном зүй

1. УДШ, Ханс Зайделийн Сан. “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, 2010 он, Зохиогчдын хамтлаг. 162-163 дах тал

2. Ц.Мөнхбат. УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор., “Хорих ялын хэрэгжилт өнөөгийн байдал”, эрдэм шинжилгээний өгүүлэл, Хууль дээдлэх ёс сэтгүүл 2006 оны №2., 73 дах тал

3. http://www.prisonstudies.org/info/worldbrief/wpb_country.php?country=104 /last visited 2011.10.31/

4. Dirk Van Zyl Smit, Frieder Dыnkel, / 2011/ “Imprisonment today and tomorrow: international perspectives on prisoners’ rights and prison conditions

5. Penology: deterrence, prison, prison reform, prisoner abuse, prisoners' rights, rehabilitation, recidivism, retribution

6. "GULAG" нь хорих ангийн төрөл, дэглэмийн социалист системийн үеийн нэн түгээмэл хэлбэр бөгөөд хүний эрхийг ихэд дордуулсан, бусад байдлаар нэр төрийг нь гутаан доромжилж эрүүдэн шүүж харьцдаг байсан систем. Одоогийн зарим постсоциалсит орнууд ЗСБНХУ-ын хорих ангийн төрөл дэглэмийг хуулбарлан хэрэглэж байв.

7. <http://legislationline.org/documents/action/popup/id/5715> /холбогдох хуулийг хавсаргав/

8. <http://legislationline.org/documents/action/popup/id/7236>

9. Америкийн Нэгдсэн Улсын ял эдлүүлэх тогтолцоо нь муж улс бүхэнд өөр байдаг бөгөөд Оборн нэртэй хорих ял эдлүүлэх хэлбэр түгээмэл байдаг.

10. <http://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/PC.pdf>

11. Шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгэмшихэд нь туслалцаа дэмжлэг үзүүлэх

ойлголтыг гадаадын зарим оронд нийтлэг байдлаар "resocialization эсвэл reintegration and rehabilitation of criminal offender" хэмээн томъёолдог бөгөөд тусгайлсан институтууд энэхүү үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх үүрэгтэй байна.

12. Америкийн Нэгдсэн Улсад Halfway house нэртэй нэгж нь хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг 120-180 өдөрт шаардлагатай бол түр байршуулах хэлбэрээр эргэн нийгэмшихэд нь дэмжлэг үзүүлдэг бөгөөд хагас хяналттай үүндээ цагдаагийн байгууллагын туслалцааг авах хэлбэрээр хамтран ажилладаг.

13. н.Тэгшээ ОХУ-ын эрүүгийн ял эдүүлэх ажиллагаа нийтлэл 2010 он

www.ihzhasag_orshil.minih.com

<http://www.judcouncil.mn/main/660--.html>

http://www.amnesty.mn/files/publications/2012/shudargaar_shuulgeh_erkh.pdf

<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?ft=1&re=02&dn=1&x=0&y=0&co=01&ia=03&ky=criminal+law&page=58>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХГҮЙ БАЙХ ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРЧИМ БА СОЁЛЫН НӨЛӨӨ



Хүний эрхийн активист,
Монгол Улсын Их Сургуулийн
Хууль зүйн сургуулийн докторант

Б.БОЛОРСАЙХАН

Товч утга: Энэхүү өгүүлэлд хүн төрөлхтөн эрт дээр үеэс бэлгийн мөн чанарыг илэрхийлж ирсэн туршилагыг товч хөндөх бөгөөд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд соёл, шашин хэрхэн нөлөөлж ирснийг тодруулах болно. Ялангуяа хүний эрхийн зарчимд шашин, улс төрийн эрх мэдэл, албадлага хэрхэн сөргөөр нөлөөлж, үнэт зүйлийг өөрчлөх, ялгаварлан гадуурхах үндэс болж байгааг өгүүлнэ.

Түлхүүр үгс: түүх, шашин, жендэр, бэлгийн мөн чанар, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл

Оршил

Хүний эрх нь хүнд угаас заяагдсан, өөрт нь байдаг төрөлх чанарыг илэрхийлсэн, хүн болж төрснийх нь хувьд байгалиас заяагдсан өгөгдөл бөгөөд түүнийг харин олон улсын түвшинд болон үндэсний түвшинд баталгаажуулах, хамгаалах үүргийг төр, байгууллага, хамт олон, хүмүүст хүлээлгэдэг¹. Ийнхүү хүний эрхийг

хангах, хамгаалах үүргээ төр биелүүлэхдээ үндэсний хууль тогтоомж, олон улсын гэрээгээр баталгаажуулахдаа тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхахгүй байх, түгээмэл байх, хүний эрхэм чанарыг дээдлэх, салшгүй байх зэрэг зарчмыг удирдлага болгодог². Тодруулбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) зүгээс ялгаварлан гадуурхах нь хүний эрхийн зөрчлийн суурь болж байгааг таслан зогсоох зорилгоор гишүүдийнхээ нутаг дэвсгэрт хуулийн нэгэн адил биелэх эрх зүйн хэм хэмжээг баталдаг туршлага бий. Гэхдээ хүний эрхийн асуудлыг бусад улсаар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд зөөлөн шинжтэй хэм хэмжээ буюу тунхаглал байдлаар хүлээн зөвшөөрүүлж, аажимдаа үзэл баримтлалыг өөриймшүүлсэн тохиолдолд заавал биелүүлэх олон улсын гэрээ байдлаар баталдаг. Үүнийг Хүний эрхийн түгээмэл тунхаглал баталж, хожим хоёр пакт байдлаар соёрхон баталснаас харж болно. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл ялгаварлан гадуурхах явдал түгээмэл тохиолдохын хамт

¹ П.Болормаа, Азийн сан, Хүний эрхэд суурилсан хандлага, Улаанбаатар хот, 2015 он. 15 дахь тал.

² Мөн тэнд, 22-25 дахь тал.

хүний эрхийн зөрчлийг үүсгэж, цаашилбал нийгэмд тэгш бус байдлыг гааруулахад улам сөргөөр нөлөөлж байна. Үүнд соёлын нөлөө их байгааг олон зүйлээс харах боломжтой.

Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим

НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлд “арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгаа”-гаар ялгаварлан гадуурхахгүйгээр эрхээ эдэлвэл зохих тухай заасан байдаг. Мөн үүнд тухайн хүний амьдарч буй улс, нутаг дэвсгэр, нөхцөл байдалд хязгаарлагдмал нөхцөл үүссэн ч ялгаварлан гадуурхахыг зөвтгөх үндэслэл болохгүй. Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим нь тэгш байдлыг хангах, түгээмэл байх, салшгүй байх, хүний эрхэм чанарыг дээдлэх гэх мэт бусад зарчимтайгаа салшгүй уялдаж, нөхцөлдөж байдаг.

Хүснэгт №1. Ялгаварлан гадуурхахыг хориглосон хэм хэмжээ

Заавал биелүүлэх шинжтэй	Тунхагийн шинжтэй
Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Алагчилахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 111 дүгээр конвенц (1958)	Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)
НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Боловсролын талаар алагчилахтай тэмцэх тухай конвенц (1960)	Аливаа хэлбэрээр үл хүлцэх, шашин, итгэл үнэмшлээр ялгаварлан гадуурхахыг устгах тухай тунхаглал (1981)
НҮБ-ын Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (1965)	Хөгжих эрхийн тухай тунхаглал (1986)

НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)	Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг олон улсын хүний эрхийн эрх зүйд ашиглах тухай Жогжакартагийн зарчим (2006)
НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966)	Уугуул хүмүүсийн эрхийн тухай тунхаглал (2007)
НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979)	Хүний эрхийн боловсрол, сургалтын талаарх тунхаглал (2011)
НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989)	
НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (2008)	

Үүний зэрэгцээ олон улсын гэрээгээр тодорхойлсон шалгуур нь хүний эрхэм чанарыг үгүйсгэж байсан хүн төрөлхтний түүхэнд зонхилон тохиосон үйл явдлаас жишээлсэн бөгөөд бусад үндэслэлээр ялгаварлан гадуурхаж болно гэсэн үг биш,

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 1 дүгээр зүйлд заасан хүний эрхэм чанар (human dignity) нь тэгш байдлыг хангах зарчмын үндэс бөгөөд хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнэтэй амьдрах, бусдыг хүндэтгэх, бусдаар хүндэтгүүлэх, эрхээ эдлэхийг илэрхийлэх тул ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхахыг хэрхэвч хүлээн зөвшөөрч болохгүй. Дэлхийн хаана байх, ямар зан заншил, уламжлал, ёс зүйн үнэт зүйлстэйгээс үл хамааран хүнийг эрхэм чанартай бодьгал хэмээн хүлээн зөвшөөрөх нь түгээмэл байх зарчмын тулгуур юм. Ямар ч тохиолдолд “хуульд заасан үндэслэл”, “уламжлалт зан үйл”, “шашны хэм хэмжээ” зэрэгт үндэслэж, хүний эрхэм чанарыг үл хүндэтгэсэн, дордуулсан, хүчирхийллийг

зөвтгөсөн, хүч, албадлага хэрэглэхийг хөхиүлэн дэмжсэн үйлдэл гаргаж болохгүй. Үүнийг салшгүй байх зарчим гэнэ³.


Соёлын илрэн гарах хэлбэр

Америкийн Нэгдсэн Улсын Миннесотагийн Их сургуулийн Хэл сурах явцыг судлах төвийн “Соёл хоорондын судлал төсөл”-ийн зүгээс “соёл гэдэгт зан төлөв, харилцан үйлдэхүй, танин мэдэхүйн байгууламж, төдийгүй нийгэмших байдлаар суралцдаг бусдад нөлөөлөхүйц ойлголтыг агуулсан хүмүүсийн дунд нийтлэг орших шинжийг ойлгоно. Энэхүү дундаа хуваалцаж байгаа шинжээр соёлын бүлэгт хамаарах гишүүдийг бусад бүлгээс ялгах боломжтой” хэмээн тодорхойлжээ. Судлаач Усийм өөрийн “Хүний байгууллага” бүтээлдээ “соёлыг олон янзаар тодорхойлж болох ч товчхондоо хүн төрөлтөн хоорондоо харилцаж байгаа нийгмийн бүлгийн хамтдаа суралцаж, хуваалцсан зан төлөв” гэж тодорхойлсон бол судлаач Ледерахын “Энх тайванд бэлтгэх нь: Соёлуудын дунд зөрчилдөөн хувиран өөрчлөгдсөн нь” бүтээлдээ “соёл бол тодорхой бүлэг хүн өөрийн эргэн тойрны нийгмийн бодит байдлаа өөрийнхөөрөө хүлээн авч, тайлбарлаж, илэрхийлж, хариу үйлдэл үзүүлж байгааг илтгэсэн дундын шинжтэй мэдлэг, схем” гэжээ. Мөн Судлаач Бэнкс, МакГий нарын “Олон соёлт боловсрол” бүтээлд “Соёл нь ил болон далд байдлаар илрэх шинжээс бүрдэх ба бэлгэ тэмдгээр олж авсан, дамжуулсан зан төлөвийг агуулж, эртний эдлэлд тусгалаа олсон байдлаар хүмүүсийн бүлгийн ололт амжилтыг ялган харуулдаг. Мөн хүмүүсийн өөрт нь хамаарах уламжлалт санаа бодол, үнэт зүйлсийг дотроо агуулдагаараа онцгойрох ба соёлын тогтолцоо үйл

ажиллагаанаас үүдэн гарсан байхын хамт ирээдүйд хийх алхамыг тодорхойлж ч болдог онцлогтой” гэжээ⁴.

Соёлын детерминист үүднээс харвал нийгмийн гишүүдийн хувиар хүмүүс санаа бодол, утга учир, итгэл үнэмшил, үнэт зүйлийг сурч, аажимдаа хүний мөн чанар бүрэлддэг гэж тайлбарладаг. Хүн сурсан зүйлээ илэрхийлэн гаргадаг гэж тайлбарлах боломжтой. Харин соёлын ялгааг олж харахын тулд соёлд юу ямар байдлаар байр сууриа эзэлснийг нягтлах нь зүйтэй.

Зураг № 1. Харилцан адилгүй түвшинд соёлын илрэн гарах байдал⁵



Ийнхүү илрэн гарах хэлбэрээсээ хамаарч хүний зан төлөвт харилцан адилгүй нөлөөлөх хэдий ч соёл нь нийгмийн үзэгдлийн хувиар бүлэг хүмүүст нөлөөлж чаддаг. Судлаач Гийрт Хофстидэ хүний зан төлөв нь жендэр, нас, хувийн мөн чанар, сэтгэл хөдлөлийн байдал, хувийн харилцаа зэрэг олон зүйлээс хамаарах бол хүний хувийн болон нийгмийн хүчин зүйлээс хамааралтайгаар өөрийн зан төлөвөө бүрдүүлж байгааг 3 түвшинд харах боломжтой гэж тодорхойлсон байна⁶.

³ Мөн тэнд, 25 дахь тал.

⁴ Соёлын тодорхойлолт. Дэлгэрэнгүйг: <http://carla.umn.edu/culture/definitions.html>

⁵ B. Endrass, Cultural Diversity for Virtual Characters, 15 дахь тал.

⁶ Мөн тэнд, 13 дахь тал.

Зураг № 2. Хүний оюуны хөтөлбөрийн ялгарах байдлыг илэрхийлсэн түвшин



- ◆ **Хувийн шинж:** Хувь хүнд шууд хамаарах бөгөөд зарим зүйлээ эцэг эхээс өвлөж, зарим зүйлийг бусдаас суралцаж байдаг. Суралцах гэдэгт бусдын туршлагаас эсвэл хүмүүсийн соёлын нөлөөн дор өөрчлөгдөхийг хэлнэ. Тухайн хувь хүнийг илэрхийлэх, бусадтай тэр бүр хуваалцаад байдаггүй шинжийг агуулах нь бий.
- ◆ **Соёл:** Хүний зан төлөвийг тодорхойлдог хэсэг. Гэр бүл, хөршийн холбоо, ажлын байр, тухайн улсын хамтдаа амьдарч байгаа иргэд гээд маш өргөн хүрээг хамрах тодорхой бүлэг, орчин хамааралтай. Соёлоос хамаарч хүн өөрөө мэдэлгүй өөрийн зан төлвөө бий болгож, хүлээн авч байдаг.
- ◆ **Хүний мөн чанар:** Хүн бүрт хамаарна. Хүний генээр дамжиж авсан бие махбодын, сэтгэлзүйн үндсэн үйлдэл багтдаг. Айх, баярлах, гуних, уурлах, хайрлах гэх мэт сэтгэл хөдлөлийг хүн бүр илэрхийлэх боломжтой. Мөн хүний орчныг ажиглах, бусадтай ярилцах, харилцах ур чадварыг хамарна.

Соёл хэрхэн илэрч байгааг танин мэдэхийн тулд бэлгэ тэмдэг гэсэн давхаргад тодорхой утга бүхий үгс, хөдөлгөөн, зураг,

эд зүйл болон соёлыг дагадаг гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хувцас, хэллэг, үсний засалт зэрэг багтана. Хуучин бэлгэ тэмдэг арилах зуур шинэ бэлгэ тэмдэг ямагт хөгжиж байдаг. Баатар гэж хүний зан төлөвт үлгэр жишээ болох, чиглүүлэх зорилгоор үйлчилдэг тухайн соёлд алдартай хүмүүсийг ойлгодог. Жинхэнэ хүн байх албагүй бөгөөд туулийн баатар Манас, зохимол дүр Хүн-Аалз, Барби хүүхэлдэй ч байж болно. Зан үйлийн ёслолд хамтач шинжтэй үйл ажиллагаа багтах ба мэндлэх, бусдыг хүндлэхээс шууд харах боломжтой. Мөн аливаа зүйлд хандах тогтсон хандлага, ярианы хэлц, хэл ч орно. Гэхдээ утга учрыг гаднаас ажиглах боломжгүй, өөрийн олж харсан зүйлээ ажиглагч хэрхэн тодорхойлж, шийдвэрлэж байгаагаас бүрэн хамаардаг онцлогтой. Үнэт зүйлийн тухайд сайн муу, энгийн ялгаатай, хэвийн хэвийн бус, зөвшөөрсөн зөвшөөрөөгүй, аюултай аюулгүй, хориглосон зөвшөөрсөн, бузар ариун гэх мэт үнэлэмжийн хослолыг илэрхийлдэг.

Орчин үед бид үнэт зүйл, зан үйлийн ёслол, баатар, бэлгэ тэмдгийн гайхам хослолыг туулиас харж болно. Тууль бол нийгмийн хөгжлийн бүхий л үеийн хөгжил хувьсал, ард түмний аж байдал, хэв заншил, тухайн нийгмийн ёс суртахуун, урлагийн үзэл, боловсролын байдал зэрэг нийгмийг тал бүрээс нь тусгасан аман түүх юм⁷. Үүний бодит нотолгоог өнөөгийн бидний өдөр тутам гэртээ ашигладаг хоол хийх, цай буцалгах том жижиг саваас ч харж болно. Нүүдэлчид өөрсдийн хоол, ундыг бэлтгэхдээ том жижиг тогоо хэрэглэж байсныг судлаачид туулиас харуулахуйц баримт тэмдэглэсэн байна. Жишээлбэл, хаан тулга, хатан тулга, боол тулга нь том,

⁷ Монсудар, Монгол хэл соёлын хүрээлэн; Тууль; Улаанбаатар, 2014 он. 23 дахь тал.

дунд, жижиг тогоо тавих зориулалттай тулга байсан гэж нотолдог. “Аргил цагаан өвгөн” (1960) туулиас:

...Аргил цагаан өвгөн
Хайрын хар бараан илдээ
Гал бадартал суга татаад
Хар көкө күүг нь
Тас огтлох гэтэл
Хад харгалдаксан шинг
Хальтарч одоод
Мөс харгалдаксан шинг
Мөлтөрч байв гэнээ л.
Боол тулгаа холби татан
Дор нь дүрээд,
Ноён тулгаа холби татан
Дээрээс нь тас цокиж
Арай чамай тасалж
Баал улаан күвүүнээ
Зуун иргийн арсанд

Арай багтааж боож авчээ... хэмээн монгол гэр доторх хамгийн хатуу эд зүйлээр дөнгөж төрсөн баатар хүүгийнхээ хүйг тасалж байгааг дүрсэлжээ.

Өнөө цагт ашиглаж байгаа морь эдлэх соёлын нэг хэсэг болох уургыг нүүдэлчид олон янзаар ашиглаж ирсэн билээ. Эрт дээр үед тал нутагт мэдээлэл дамжуулах боломжгүй тохиолдолд уургыг дээш хатган таних тэмдэг байдлаар ашигладаг туршлага бий. Оросын Холбооны Улсын найруулагч Никита Михалковын Франц, Өвөр Монголын уран бүтээлчидтэй хамтран 1991 онд туурвисан “Урга: Территория любви” уран сайхны кинонд уурга нь амраг хосын учирч байгааг харуулдаг дохио байдлаар олноо толилуулсан юм. Өмнө дурдсан “Аргил цагаан өвгөн” (1960) туульд:

...Эмгэн улаан хатандаа
Утэр түргэн очиж
Кэлдэг юман гэгээд
Далай цагаан өргөөгөө
Тэмцээд зүглээд одвол

Баруун хаяанд
Шахаж ирж ёвахад
Баруун цамархайгаар нь
Хусан баханын ацад
Таван өнгийн хив уяад,
Гаргаж кийсгээд орхиксон
Байхы нь алдалгүй үзээд,
Аргил цагаан өвгөн

Улам улам баярлаж... гэснээр удаан хугацаанд хүүхэд төрөөгүй гэрийнх нь баруун талаар урт модны үзүүрт тод өнгийн давуу уяж “Хүү төрлөө” хэмээн мэдээлж байна. Үүнээс урт модоор дохиолохын зэрэгцээ монгол гэрийн хоёр талыг эрэгтэй, эмэгтэйд хамааруулан хувааж байгаа ахуйн соёлын илрэлийг танин мэдэх боломжтой.

“Цуутын цагаагч гүү”, “Яриг цагааны ингэний сариг цагаан ботго” зэрэг бүтээлийг манай зарим судлаач туулийн шинжтэй байсан ч үлгэрийн байдалтай болж өөрчлөгдсөн гэж дүгнэсэн байна. Ялангуяа “Цуутын цагаагч гүү” нь адгуусны тууль байдлаар тухайн үеийн нийгмээ харуулсан бүтээл буюу эхийн эрхт ёсноос эцгийн эрхт ёсонд шилжиж байгааг өгүүлжээ. Цуутын цагаагч гүү ижил сүргээ шим тэжээлтэй газар аваачих, очсон газраа шувууны өндөг хагалахгүй байх, шувуун цэргээс болгоомжлох талаар удаа дараа сануулж, болгоомжилсон ч сүргийн манлай азарга үгийг нь огт тоохгүй, өөрийн шийдвэр гаргаж, олноор шувуун цэрэгт алуулж байгааг өгүүлдэг. Мөн өөрийн унагаа биеэрээ хамгаалаад үхэх мөчид эмэг эхдээ очихыг гэрээслэж байгаа нь эцгийн эрхт ёс тогтож байсан тухайн үед эхийн эрхт ёсыг дэмжсэн овог аймаг байсныг гэрчлэх баримт гэж Ц. Дамдинсүрэн, Б. Я. Владимирцов нар үзжээ.

Түүхийн баримтанд тулгуурлан туулийн гарал үүслийг хөөж үзвэл он цагийн хувьд хэдийд үүссэн нь тодорхойгүй

бөгөөд хүй нэгдлийн үеийн эцгийн эрхт овгийн байгууллын үед буюу хэл яриа үүссэн, эр хүнийг дөвийлгөн гаргаж, алдаршуулах үзэл бий болсон, нум сум хэрэглэж эхэлсэн, малыг гаршуулж, морийг уналга, эдэлгээнд хэрэглэдэг болсон үетэй зэрэгцэх боломжтой. Судлаач Н.Поппе монгол туулийн үүсэл хөгжлийг тоймлон судлаад дараах үечлэлийг гаргажээ. Үүнд:

1. *Үл мэдэгдэх үеэс XIII зууны дунд үе хүртэл:* Энэ үед буриад монголчуудын дунд уламжлан ирсэн эхийн эрхт овгийн байгууллын үеийн (40'000-15'000 жилийн өмнө) нийгмийн амьдралыг голдуу дүрсэлсэн туулиудыг хамруулан үзсэн;

2. *XIII зууны дунд үеэс XVII зууны дунд үе хүртэл:* Энэ үеийг Чингис хаан нэгдсэн Монгол Улс байгуулсан цаг үеийн амьдралтай;

3. *XVII зууны дунд үеэс XX зуун хүртэл:* Энэ үеийг XVII зууны үеийн монголчуудын задрал бутрал, шарын шашин дэлгэрсэн үетэй;

4. *XX зуунаас хойшихи:* XX зууны эхэн үеэс монголын нийгмийн амьдралд гарсан өөрчлөлттэй холбон үзсэн⁸.

Соёл, ахуйн зэрэгцээ шашны нөлөөнд туулийн үгс, агуулга өөрчлөгдөж ирснийг нэг туулийн хэд хэдэн хувилбарт хэрэглэх шадаас харж болно.

Хүснэгт № 2. Туулийн өөрчлөлт

“Хан харангуй” тууль		
Магнай дээр нь	Магнай дээрээ	Зулай дээр нь
Мазаалай баавгайн хүчин	Махагалын гэрэлтэй	Зонхавын адис тогтсон
Магад гурав эргээд төрсөн	Зулай дээрээ	Манлай дээр нь
	Зонхавын гэрэлтэй	Махгалын дүр тогтсон

⁸ Монсудар, Монгол хэл соёлын хүрээлэн; Тууль; Улаанбаатар, 2014 он. 6-7 дахь тал.

Монгол туулийн гурван том бүтээлийг харьцуулан харвал:

Хүснэгт № 3. Тууль дахь ургийн бичгийн хэлбэр

	Хан харангуй	Гэсэр	Жангар
Эцэг эх	Хаан сайхан аав Хатан тунгал ээж	Сэнлон ноён Го баяны охин Амаржил	Тансаг Бумба хааны ач Үйзэн Алдар хааны хүү
Хань	Хан харангуй Толь гуа дагина (Агь буурал хааны)	Гэсэр (Нусан Жур) Рогма	Жангар Агай Шавдал (Ном Төгс хааны)
Үр	Хар Соно	Ажу мэргэн хатнаас хүү төрсөн ч үхсэн	Хар Жилган

- ◆ “Хан харангуй” туулиас хүн төрөлхтний байгалийн эсрэг сөрөн зогсож, оршихын төлөө тэмцэж байсан хүй нэгдлийн үеийг харах бол “Гэсэр” туульд овгийн байгууллын задралыг тод томруун илтгэж, “Жангар” туульд төрт улсын үүслийг илтгэх баримт гардаг.
- ◆ Хатны дүр нь олон сайн шинжийг агуулсан, зарим тохиолдолд тухайн туулийн гол учгийг зангидах, мангасыг дарах аргыг олох, тус болох, зөгнөх гэх мэтчилэн гол дүрийн нэгэн адил чухал байр суурьтай төдийгүй мангас, муу талын баатарт олзлогдсон ч эргэн хамтдаа амьдарч, амар сайхандаа жаргадаг.
- ◆ Аль ч туульд гол дүр хэнээс төрсөн, түүний үр удам хэн болох талаар заавал хэлдэг. Ургийн бичиг хөтлөхдөө Монголын нууц товчооны эхэн хэсэгт бичсэн эрийн талыг дангаар барихаас илүүтэйгээр эр, эмийн талыг нэгэн зэрэг бичдэг байжээ.

Гэтэл манай нэгэн хошин шог үлгэрт “Ямаан толгой ямбанд ордоггүй, янтгар хатан хуулинд ордоггүй, тэмээн толгой тэвшинд ордоггүй, тэнтгэр хатан зарга шүүдэггүй, хонины толгой хоймроо домбойдог, хотгор сайхан ноёноо ирэхэд шийтгүүлнэ” хэмээн Могжоохон даагатай Жогжоохон хүү хэлдэг⁹. Шоглон хошигносон байдлаар хатныг үл тоосон мэт өгүүлэх энэхүү үлгэр “Эрт урьд цагт Манжийн хааны үед” гэж эхэлдэг. Тодруулбал, XVII зууны сүүлч үеэс XX зууны эхэн үе хүртэлх нийгмийн амьдралд эмэгтэй хүнийг үл тоох, нийгэмд эзлэх байр суурь (статус) бусдаас доогуур байх, зарим тохиолдолд ямарваа нэгэн шийдвэр гаргах эрх мэдэлгүй байсан байж болзошгүй. Үүнтэй уялдан туульд эрхэмлэн дээдэлдэг байсан хатан хожуу үеийн үлгэрт үнэлэмжгүй болсныг харж болно. Гол шалтгаан нь тухайн үеийн хуультай шууд холбоотой бөгөөд хуулиар дамжуулан нийгэмд ямар үнэт зүйлс бүрэлдэж байгааг мэдэх боломжтой. Жишээлбэл:

§ Эм гээх. Аливаа хүн авсан гэргийгээ гээвэл эр, эмийн сайн ахуй цагт хэрэглэж барсан юмыг үл төлүүлнэ. Эдүгээ бүхүй эмийн инж дагуулан авч одсон юмыг цөм эмд гэдрэг өгнө.
Монгол цаазын бичиг (1795)¹⁰

Монголын эртний үеийн зарим хуулийн зохицуулалт
§4. Ноёд хүний сүйтийг мэдэж өгвөөс гурван зуун анз өгөх. Тэр эмийг нь хариулж өгвөөс юу өгөх буй.
Усан үхэр жилийн (1613) өчүүхэн цааз
§33. Бас нэгэн зүйл.
§33.1. Хан хүний охин авайг харц хүн сүйлэх бөгөөс цагаан тэмээ мөнгөн буйлтай, цагаан морь булган молцогтой, мөнгөн аяга архиар дүүргэсэн, нүхгүй сувд эрдэнэ эднээр сүйлснийг сүйд тооцно.
§33.2. Бас ноёд тавнангуудын охинг гуйваас мөнгөн аяга, сувд архиийг хүргэвээс тооцно. Үгүй бөгөөс тооцохгүй.
§33.3. Бас харц хүн өөр зуураа сүйлэх бөгөөс архи болоод хонины гэдэс дотор эвэр туур гүйцэд болбоос тооцох. Эднийг гэрчтэй болоод гэрч мэдвээс тооцох. Гэрчгүй ба гэрч эс мэдвээс тооцохгүй.
Гурван хошууны их цааз (1709)

Бага хаадын задрал, Манжийн үеэс эмэгтэй хүнийг объектжуулах¹¹ нь улам нэмэгдэж, эрх мэдэлтэй этгээдийн зүгээс угсаа гарал, нийгэмд эзлэх байр сууриас нь хамаарч, гэрлэх, өмчлөх эрхийг баталгаажуулж, зарим тохиолдолд субъектив байдлаар/дур зоргоор тухайн эрхийг хязгаарлах боломжтой зохицуулалт үйлчилж байжээ. Мөн эмэгтэй хүнийг “нүхлээгүй сувд”, “цагаан, мөнгөн” гэсэн ойлголтоор “ариун, нандин, онгон” байхыг бэлгэдсэн мөртлөө бусдын сүйт бүсгүйг эрх мэдлээр түрэмгийлж, ял шийтгэл хүлээхгүй эзэрхийлэх боломжийг “эм хариулах” гэсэн нэрэн дор бүрдүүлсэн байна. Гэрлэлтийг гэрчээр баталгаажуулах, жинхэнэ гэрлэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд гэрч нарыг “Гэрлэснийг мэдээгүй” гэж хэлүүлэх замаар тухайн гэрлэлтийг хүчингүйд тооцох зэргээр хуулийн зохицуулалтыг эрх мэдэлтэн хийдүүлэх, нөгөө талаар эмэгтэй хүнийг эд зүйлээс ялгалгүй харсан үзэгдэл байжээ. Үлгэр, домог, тууль, аман ярианаас нийгмийн үнэт зүйлс хэрхэн бүрэлдэж, дамжуулж байсныг бүрэн харах боломжтойн зэрэгцээ орчин үед хэрхэн хувиран өөрчлөгдөж байгааг ч тодорхойлж болно.

Орчин үед туулийн үүргийг урлагийн өөр төрөл гүйцэтгэх болсон төдийгүй илүү өргөн цар хүрээтэйгээр хувь хүнд нөлөөлөх боломжтой болсон. Тодруулбал, нийтийн дамжуулга (public media) - ын нэг хэлбэр

⁹ БНМАУ-ын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Ш.Гадамба, Д.Цэрэнсодном; Монгол ардын аман зохиолын дээж бичиг; Улаанбаатар, 1978 он. 191 дэх тал.

¹⁰ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл (1206-1910)-ээс дэлгэрэнгүй үзнэ үү.

¹¹ Хүнийг ямар нэгэн бодит эд зүйлээр үнэлэх, тооцох, хэмжих боломжтой гэж тооцох, хүн биш эд зүйл гэж үзэх үзэл.

болох зурагт, сүүдэр ший, дүрс бичлэгээр олон нийтэд түгээсэн бүтээлээс харцгаая.

Хүснэгт №1. Олонд түгсэн орчин үеийн бүтээлийн анхны хувилбарын агуулга

Хүүхэлдэй	Гол дүр	Үлгэрийн анхны хувилбар
Нойрсож буй гүнж	Аврора	Хаан охины хажуугаар өнгөрч явахдаа түүний унтаж байгааг мэдэн хүчирхийлдэг. Нойрссон хэвээр гүнж ихэр хүүхэд төрүүлдэг.
Цасан царайг ба долоон одой	Цасан царайг	Хатан хаан түүний жинхэнэ эх байсан бөгөөд охиноо үхсэнийг мэдэхийн тулд элэг, уушгийг нь идэх гэдэг. Эцэст нь улайдам халаасан төмрөн гуталтай бүжиглэсээр үхдэг. Хунтайж охиныг үнсэж сэрээлгүй мориндоо дүүрэн авч явдаг. Харин охин морин цогион дунд сэрдэг.
Рапунцель	Рапунцель	Гриммийн 1812 оны хувилбарт охин дээр хунтайж байнга ирсээр жирэмсэлдэг. Удалгүй хувцас нь багадаж, ихэр хүүхэд төрүүлдэг.
Үнсгэлжин	Үнсгэлжин	Дагавар эгч нар нь гутланд хөлөө тааруулахын тулд хуруу, өсгийгөө тайрч, цусаа гоожуулдаг. Хожим тэдний нүдийг шувуугаар ухуулж сохлох ба тэд гуйлгачин болж төгсдөг.
Гүнж, мэлхий хоёр	Тиана	Мэлхий хаан гүнжид элдэв санал тавьдаг. Сүүлдээ хамт унтахыг хүсдэг. Уурласан гүнж мэлхийг хана савж шидэхэд хаан болон хувирдаг. ¹²
Бяцхан лусын дагина ¹³	Ариель	Лусын дагины хувьд алхах нь сэлмэн дээр яваа мэт маш зовиур шаналантай байсан ч хунтайжид зориулан бүжиглэдэг. Хунтайж өөр хүнд дурламагц түүнийг алж амиа аврахаас илүүтэйгээр үхлийг сонгон далайн хөөс болон хувирдаг.

¹² Францын зохиолч Шарль Перро ардын үлгэрт тулгуурлан Улаан малгайт, Үнсгэлжин буюу Бяцхан болор шаахайт, Гуталт муур, Нойрсож буй гүнж зэрэг шидэт үлгэрийн төрлийг бий болгосон нь ах дүү Гримм, Л. Тик, Г. Х. Андерсоны бүтээлд нөлөөлсөн билээ. Ялангуяа Перрогийн хувилбарыг ах дүү Гримм өөрсдийн герман ардын үлгэрээр баяжуулан хэрцгий, хүчирхийллийн хэлбэрийг тусгажээ. Тэд Цасан царайт, Рапунцель, Үнсгэлжин, Мэлхий хунтайж буюу Төмөр Генри гэх мэт үлгэрийг нэмж туурвисан байна.

¹³ Данийн Копенгаген хотноо 1837 онд хэвлэсэн Г. Х. Андерсоны "Хүүхдэд зориулсан шидэт үлгэр. Анхны хувилбар"-т эмгэнэлт байдлаар дүрсэлсэн байдаг.

Үзэсгэлэнт охин, араатан хоёр ¹⁴	Белла	Араатан охинтой шөнө хамт нойрсож, тэврэн үнсдэг. Түүний дагавар эгч нар охиныг хуурч цайзад очиход саад болдог. Атаархалдаа автсан тэднийг араатан чулуу болгон хувиргадаг.
---	-------	--

Дээрхээс тухайн үеийн нийгмийн нөхцөл байдлаас хамааран үлгэр, домгийг хүмүүс туурвин бүтээж, өөрчлөн найруулж байгааг, мөн эрх мэдэл, хуулиар албадах байдлаар хүлээн зөвшөөрүүлж, аажимдаа заншил, уламжлалын хэв шинжтэй болсныг харлаа. Гэхдээ өнгөрсөн түүхээс эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, тэднийг эзэрхийлэх, дарамтлах явдал түгээмэл, амьдралын нэг хэсэг байсныг гэрчилж байна.

Ялгаварлан гадуурхсан шинжтэй соёлын нөлөө

Тэгвэл ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхсан, бусдыг үл хүндэтгэсэн соёлын илрэл хэзээнээс эхтэйг тодруулж, хариултаа эртний Хиндү домогзүй¹⁵ талаас эрэлхийлье.

Хүмүүс утга учир бий болгодог амьтад. Бид юуг ч бэлгэ тэмдэг болгож чадна. Бэлгэ тэмдэг нь дохионоос ялгарч, тухайн хүй элгэний дотор ярьдаг хэл болох бөгөөд хүй элгэн дотроо ямар ч төрлийн тайлбар хийх боломжтой байдаг. Жишээлбэл, эртний Энэтхэгийн аман үлгэрт буудай нүдэхдээ уур, нүдүүр ашиглаж байгаагаар гетеросекс шинж, гар тээрэм ашиглаж байвал лесби харилцааг илтгэх санаа агуулдаг. Хэл өөрөө рациональ байх албагүй. Гагцхүү өөрийн мэдрэмжээ илэрхийлэх гэснээр логикийг үгүйсгэж, шинжлэх ухаантан, математикч, шашны төлөөлөгчдийн ундууцлыг төрүүлж

¹⁴ Францын зохиолч Габриэль-Сюзанн Барбот де Вильневийн 1740 онд нийтэлсэн шидэт үлгэрийг 1756 онд дахин хянаж, хураангуйлан өнөөгийн хэлбэрээр нийтэлжээ.

¹⁵ Домогзүй нь түүх, бэлгэ тэмдэг, зан үйлээр хувь хүмүүсийн илэрхийлдэг үнэнийг судалдаг.

мэднэ. Ямар нэгэн домог, бэлгэ тэмдэг, зан үйлийг тайлбарлахад тайлбарлагч этгээдийн итгэл үнэмшлийн зэрэгцээ тайлбар сонсож буй хүний итгэл үнэмшил ч нөлөөтэй. Үүнтэй уялдан объектив тайлбар гэж байхгүй.

Хорвоо дээр маш олон хүн бий. Бид хэнийг танин мэдэж, хэнийг бий болгодог вэ? Танин мэдсэн үйл нь жам ёсны шинжтэй бол бий болгосон үйл нь жам ёсны бус, байгалиас ангид, хүний гараар бүтээсэн, соёлын хамааралтай байдаг. Христийн сургаалыг биширсэн хүмүүст Бурхны арван зарлиг нь жам ёсны байдаг бол Хиндү сургаалд соёл (sanskriti) нь байгаль дээр бүтээсэн зохиомол тулгалт (prakriti) ажээ. Хүмүүсийн түүх, бэлгэ тэмдэг, зан үйл нь хатуу чанд болж, түүнийг байгалиас хэтийдсэн хүчтэй нэгэн улам бэхжүүлэх үед шашин үүсдэгийг мартаж болохгүй.

Жайнчууд, эртний Буддистуудын дунд, мөн Хиндү домогт гардаг тасралтгүй эргэдэг төрөх, үхэх хүрд (samsara), одоо цагт илрэх өнгөрсөн үйлдлийн болон ирээдүйд нөлөөлөх өнөөгийн үйлдлийн үр нөлөөг (карма) илтгэсэн дахин төрөх тухай санааг эртний Грек, эсвэл библийн, нэг бол Барууны домгоос харахгүй. “Таны амьдрал цорын ганц, дахин амьдрах гэсэн зүйл байхгүй” гэж үздэг ертөнцтэй харьцуулахад амьдрах олон тохиол бий хэмээн тэс ондоогоор номлодог. Үйлийн үрийн үүднээс (Хиндү домог зүй) авч үзвэл та ямар нэгэн сайн үйл хийхээр эсвэл өмнөх нүглийнхээ лайг үүрч яваа нэгэн. Цор ганц амьдралтай ертөнцийн тухайд та бол ийм л байх ёстой буюу оршихоос аргагүй (Грек домог зүй) эсвэл Бурхан/Чөтгөр ийнхүү хүссэн учраас (библийн домог зүй) амьдарч байгаа нэгэн билээ.

Хиндү домог зүйд “эцгийн эрхт ёс буюу эрчүүд эмэгтэйчүүдээс ямагт илүү гэсэн

үзэл бол зохиомол” гэж үздэг. Тодруулбал, “Махабхарат” туульд¹⁶:

Анхандаа гэрлэх гэсэн ойлголтгүй үе байжээ. Гэрлэх шаардлагагүй, хүссэн хүн рүүгээ тэмүүлэх, очих боломжтой байсан.	“Гэрлэх албагүй”
Эцэг нь хэн бэ гэдгийг шаарддаг болсон.	“Энэ бол миний хүү”
Эмэгтэйг эрхшээхийн хамт түүний үнэнч байдлыг үнэлэх болсон.	“Тэр эмэгтэй миний үрийг тээх бумба”
Өмч чухал болсон.	“Энэ бол минийх”
Эцэг ч өмчийг өв залгамжлуулахад анхаарч эхэлсэн.	“Миний гэсэн зүйлс хөвгүүнд маань очих ёстой”
Мөнх амьдарна гэсэн найдвараар хүмүүст өмчлүүлэх, өв залгамжлуулах болсон.	“Би үхэх хэдий ч өөрийн хөвгүүдээрээ дамжуулан өөрийнхөө амьдралаас илүү амьдрах болно.”

Феминизм буюу эрэгтэй, эмэгтэй гэсэн хүйст ялгалгүй бүгд адил тэгш хүмүүс гэсэн үзэл санаа нь Хиндүизмын¹⁷ ном сударт сүнс (soul) болон махан биеийн ялгааг тайлбарласнаар тод томруун харагдана. Сүнсэнд жендэр байхгүй, жендэр махан биеэс эхтэй. Гэгээрээгүй нэгэн сүнснээс илүүтэйгээр жендэрээс шалтгаалан махан биеийг эрхэмлэнэ. Иймээс гэгээрээгүй нэгэн эмэгтэй махан биеэс эрэгтэй махан биеийг

¹⁶ Махабхарат буюу Их Бхаратын удмынхны хаанчлалын тухай туульс нь НТӨ IV – НТ IV зууны хооронд Хиндүизм төхөхөд үнэтэй хувь нэмэр оруулсан, 19 ботиос бүрдэх дэлхийн хамгийн том Энэтхэг тууль юм.

¹⁷ Хиндүизм гэсэн нэр томьёог XIX зуунд Британийн колоничлогчид Энэтхэгийг захирч байхдаа ашигласан. Тус нэр томьёогоор 4000 гаруй жилийн түүхтэй Ведийн сургаалын үндэс, сүүлийн 2000-аад жилд боловсорсон Пурана, Агама, Тантра, бхактигийн ном бүтээлийг илэрхийлдэг. Эртний Ведийн уламжлалын Пураны уламжлал зонхилж, хожим НТӨ V зуунд Буддизм, Жайнизм зэрэг лам нарын бүлэг хүчээ авсан учир Буддизмын өмнөх болон дараах Хиндүизмын хэлбэр гэж ангилан харвал зохино. Хиндүизм хувиран өөрчлөгдөхөд Буддизм ч гэсэн өөрийгөө өөрчилсөн. Буддизмын эхэн үеийн Теравадын сургууль НТ I зууны үеэс Махаянагийн сургуульд зайгаа тавьсан гэж болно. Үүнтэй уялдан Буддист тэг дүр эрэгтэйлэг шинж зонхилсон байснаа эмэгтэйлэг дүртэй болж эхэлсэн. Зовсон хүмүүсийн шаналанг сонссон Будда уйлахад нулимснаас нь төрсөн Дарь эх эмэгтэйлэг дүр илэрхийлдэг болжээ.

илүүд үзэж, хөгшин биеэс илүүтэй залуу цогцост анхаарч, бараан арьснаас илүү цайвар арьсыг шохоорхохын хамт тухайн махан биеийн эзэмшиж байгаа өмч хөрөнгө, цусан төрлийн холбоот гэр бүл, нийгэмд эзэлсэн байр сууриа эрхэмлэдэг. Гэгээрсэн хүн махан биеийг зөвхөн яаж ашиглаж байгаагаар нь ангилж үздэг:

- ◆ Өөрийн биеэ бусдад зориулсан нэгэн (devadasi)
- ◆ Өөрийн биеэ хэнд ч зориулаагүй нэгэн (sanyasi)

Сүм хийд “эмэгтэй хүн бол зугаа цэнгэл хангахын төлөө төрсөн, эрчүүдийн зорих тэнгэрлиг зам мөрийг гажуудуулахуйц буруу үйлд татах завхай” болохыг нээснээс хойш бүх зүйл өөрчлөгдсөн. Эмэгтэйчүүд онгон, ариун явдалтай байснаар ид шидийн хүч эрхшээж¹⁸, бэлэврэхээс хамгаалуулдаг бол¹⁹ гоонь эрэгтэйчүүд “хишиг хүртээх” (олон эмэгтэйтэй нөхцөх) эсвэл харааж зүхэх (“бузар, ариун бус” гэж зарлах) эрх мэдэлтэй болжээ²⁰.

Хиндү домог зүйд эмэгтэй эсвэл эрэгтэй шинжийг нэг мөр тодорхойлох боломжгүй түүхийг ихээр агуулсан ба эмэгтэй болсон эрчүүд, эрэгтэй болсон эмэгтэйчүүд, эр хүнгүй хүүхэд бүтээсэн эмэгтэй, эмэгтэйгүйгээр хүүхэд бүтээсэн

эрэгтэй байтугай макара²¹ (makara) буюу загас, заан/матар/гөрөөс-ийн хослол, яали (yali) буюу арслан, зааны хослолыг хүртэл дүрслэх нь бий²². Үүний зэрэгцээ санскрит, пракрит, тамил хэлнээ клиба (kliba), напумсака (napumsaka), мухабхага (mukhabhaga), санда (sanda), панда (panda), пандака (pandaka), педи (pedi) гэж бэлгийн мөн чанар, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой тайлбар хийдэг байна.

Зөвхөн Хиндү домог зүй л энэ талаар өгүүлдэггүй. Жишээлбэл, Арктикийн бүс нутагт амьдардаг Инүитүүдийн домогт дэлхий дээр анх хоёр эрэгтэй байсан ба өсч үржихгүй байсан тул нэг нь эмэгтэй болсон гэдэг. Умард Америкийн уугуул овгийнхон дунд “хос сүнстэн” (two-spirits) буюу эрэгтэй болон эмэгтэй чанарыг нэгэн зэрэг илэрхийлж байгаа хүнийг нэрлэж, гурав дахь хүйст тооцохын хамт сүнсний ертөнцтэй ойр амьдардаг бөө байдлаар аж төрдөг байжээ. Мексикийн төв хэсгээр амьдарч байсан Ацтекийн домог зүйд гарах Урлаг, үзэсгэлэн гоо, эрдэнэ шиш, бүжиг, дууны бурхан, дүр хүсэл, ижил хүйстнээ хүсэмжлэх хүслийн элч болсон эрх танхи, булбарай, цэцгэн хунтайж Зочипилли (Xochipilli)-ийг онцолж болно. Кубын Сантериагийн домог зүйд өөрийн хүүтэйгээ тохиолдлоор энгэр зөрүүлсэн далайн дагины тухай түүх бий. Өөрөөс нь төрсөн хэлгүй, дүлий хоёр хүүгээсээ ичсэн тэрбээр гүн далайн ёроолд нуудаг. Цөллөгдөж,

¹⁸ Эртний соёлт нийгэмд эмэгтэйчүүдийн байр суурь нь удган, анагаагч, эм баригч, сүнсээр холбоо тогтоогч гэх мэтчилэн харилцан адилгүй нэртэй ч өндөр байр суурьтай байсан. Дэлгэрэнгүйг: <http://www.suppressedhistories.net/articles/priestesses.html>

¹⁹ James Pritchard, Ancient Near Eastern Texts Relating to the Old Testament, Princeton, 1969.

²⁰ Эртний грекийн газарзүйч Страбогийн (НТӨ 63 – НТ 24 он) Египетийн тухай тэмдэглэлд эмэгтэйчүүд сүмд бэлгийн зорилгоор очихын хамт Египетийн Исис, Амон, Мут, Осирис зэрэг бурхадыг төлөөлөгч - сүмийн мяндагтантай энгэр зөрүүлдэг. “Бурхадын гэргий” гэсэн гүншин бүхий эмэгтэйчүүд байсан тухай, Соломон хааны тухай Хаадын 1 дүгээр ботийн 11:3-т “700 эхнэр, 300 татвар эм/зиндаа доогуур эм”-тэй байсан тухай дурдсан байдаг. “Ширэнгийн түүх” номын зохиолч Редьярда Киплинг анх “Дэлхийн хамгийн анхны мэргэжил бол бие үнэлэгч (prostitute)” гэсэн хэллэгийг 1888 онд бие үнэлэгчийн тухай түүх өгүүлэхдээ “Лалун бол дэлхий дээрх хамгийн эртний мэргэжил эзэмшсэн хүний нэг” гэж бичсэнээр англи хэлт орнуудад утгачилан түгээжээ.

²¹ Макара нь мөрөн голын охин тэнгэр Ганга, далайн бурхан Варунагийн хөлөг болдог. Мөн хайрын/дур хүслийн охин тэнгэр Камадевагийн бэлгэ тэмдэг болдог.

²² Бурханч лам Г.Пүрэвбатын байгуулсан Аглаг бүтээлийн хийдийн ойр орчмын чулуугаар урласан Матар, лавай хоёрын дундаас төрсөн Лавайт матар, Халиу, загасны дундаас төрсөн Үст загас, Гарьд, арслан хоёрын дундаас төрсөн найман хөлт Арслан нь үл зохилдох хямрал бүхэн амирлах, үл зохилдохуй бүхэн үгүй болох, эв найр, энх амгалан дэлгэрэх элзий бүхэн оршоох бэлгэдлээр бүтээсэн байх жишээтэй. Үүгээр хэнбугай ч үзэн ядах, ялгаварлан гадуурхахгүй, хүчирхийлэл, дарамт, шахалт, айдас үгүй, нэг нэгэнтэйгээ найрсан амьдрахын бэлгэдэл хэмээн тайлбарлах боломжтой.

ганцаардсан ах дүү бие биенээ энхрийлж хайрласан тухай үргэлжилдэг. Ертөнцийн үүслийн тухай өгүүлж байгаа хэдий ч хайрлах, энхрийлэх нь жам ёсны үзэгдэл хэмээн үзэх боломжтой.

Эртний Египетийн домогт Сет Египетийн захирагч, Эзэн хаан, өөрийн төрсөн ах Осирисыг алдаг. Удалгүй түүний хүү Хорустай маш өвөрмөц байдлаар хаан ширээг авахын төлөө үзэлцэж ялагдсанаар орчин үеийн хаан ширээ хаанаас хүүд шилжих зарчмыг нотолсон нотолгоо хэмээн ард түмний дунд хэлэлцэж заншжээ²³. Японы Шинтогийн домог зүйд заримдаа эрэгтэй, заримдаа эмэгтэй хэмээн тодорхойлдог Инари бурхан байдаг²⁴ бол Хятадын Таоист домог зүйд үхэшгүй мөнхийн найман хутагтын нэг Лан Цайхег байгалийн мөн чанараас хамаарч эрэгтэйлэг, эмэгтэйлэг хувцасладаг байсан²⁵. Таоист сургаалаар Эзэн хаан Тэнгэрээс олгосон эрхийн дагуу Луун чимэгт сэнтийд заларч, даян дэлхийд дэг журам, эв зохицол бий болгох ёстой. Үүний тулд Эзэн хаан Хориотой хотод цорын ганц үр тогтоох чадвартай эр байхын тулд тайганаар үйлчлүүлдэг. Тайган бол өөрийн үр тогтоох эрхтнээ хааны тусын тулд санаатай огтолж, хатад, татвар эмс, хүүхдүүдэд үйлчилдэг, трансгендэр биш эрийг хэлнэ. Тайганчуудыг үхэхэд биенийнх нь тасдаж авсан хэсгийг хайрцагт нандигнан хийж хамт оршуулах бөгөөд тэнгэрийн оронд өвөг дээдэстэйгээ уулзахдаа бүтэн байхыг бэлгэддэг²⁶. Күнзийн сургаал нь Таоист сургаалийн шингэн мэт уян хатан байхыг эсэргүүцэж, “байгаль бол соёлоор удирдан хянавал зохих эмх замбараагүй байдал” гэж үздэг. Бараа бологч хаанд,

²³ <http://www.egyptartsite.com/battle.html>

²⁴ <https://www.britannica.com/topic/Inari>

²⁵ http://www.newworldencyclopedia.org/entry/Lan_Caihe

²⁶ <http://www.ancient-origins.net/history/fascinating-life-chinese-eu-nuch-forbidden-city-china-002524>

залуус өтгөст, эмс эрчүүдэд мэхийх ёстой хэмээн номлодог. Энэхүү чанд тогтолцооны улмаас хааны ордон, сүм хийд, цэргийн албанд эрчүүдийн байр суурь улам бэхжсэн үеийг одоо хүртэл түүхчид Алтан үе хэмээн нэрлэдэг. Эзэн хаан Айн тухай “тасархай ханцуйны доорх таашаал²⁷” гэсэн хэллэг ижил хүйсийн бэлгийн харилцааг илтгэх ба энэхүү харилцаа нь нийгмийн тогтвортой байдалд нөлөөлдөг гэж үздэггүй байжээ. Харин бусад улстай харилцах, төрийн үйл хэрэг явуулах, хүү төрүүлэхэд саадтай хэмээн түшмэд тодорхойлж “Хааны цэцэн ухааны сарниулах хараа булаам сайхан эрээс болгоомжлох” гэсэн зүйр үг зохиосон түүхтэй²⁸.

Эртний Мезопотамын домог зүйд бусад бурхны зүгээс төгс бус хэмээн үзсэн амьтдад Энки гэдэг бурхан үүрэг ногдуулж буй тухай үлгэр бий. Тэрээр сохор эрийг хөгжимчин, үр тээх боломжгүй эмэгтэйг татвар эм, хүйсгүй эрийг харем буюу эхнэрүүдийн өргөөний манаач болгох жишээтэй.²⁹ Эртний Шумерын Гильгамешийн тууль нь Аугаа хаан Гильгамеш өөрийн дотны анд, дайчин нөхөр Энкидүг үхэхэд асар ихээр харамсан гуниглаж, уйлдаг³⁰. Энэхүү дүрслэлийг Библи сударт гарах таалал

²⁷ Хятадын алдартай хууч түүх бий. Жишээлбэл, “Тоор хуваасан нь”: ... Мизи Шиа цэцэрлэгт зугаалж явахдаа тоор хазсанаа амттай байсан тул нөгөө талыг нь хааныг амсана уу хэмээн өгөв. Хаан “Чиний хайр ямар хүндэтгэм юм бэ? Өөрийн идэх хүслийг умартан намайг амтанг ид гэж өглөө” гэж дуу алдав..., “Лүн Ян, загас хоёр”: Хаан “Чи юунд уйлав?” хэмээн асуухад Лүн Ян ноён “Би нэг жижиг загас барьсан ч том загас барьмагцаа хаяхыг хүссэн. Энэ муу ёрын үйлдлийн дараа би таны орноос хөөгдөнө. Ертөнц дээр тоо тоомшгүй гоо хүмүүс бий. Иймээс олон хүн миний талаар дуулмагч таны анхаарлыг татахыг хичээнэ. Би бол жижиг загас. Би хаягдах нь тодорхой. Иймээс би уйлахгүй байж чадахгүй.” гэжээ. Үүнийг сонссон хаан “Өөрийн гэрт байгаа сайхан хүний талаар ярьсан хүнийг гэр бүлтэй нь цаазална” гэж зарлиг буулгажээ., “Тасалсан ханцуй”: Эзэн хаан Ай өдөр Дүн Шантай гараараа тэврэн унтаж байлаа. Хаан босох гэтэл ДүнШан унтсаар байсан тул түүнийг сэрээхгүйн тулд ханцуйгаар таслан босчээ. Түүний хайр, халамж үнэхээр аугаа буй за...

²⁸ <http://www.ucpress.edu/book.php?isbn=9780520078697>

²⁹ <http://oracc.museum.upenn.edu/amgg/listofdeities/enki/>

³⁰ http://www.bibliotecapleyades.net/serpents_dragons/gil-gamesh01.htm

өгсөн Жонатаны араас гашуудах Давид хаан, Грекийн Илиад туулийн Патроклийн хойноос гашуудах Ахилл баатар, Монголын нууц товчооны Тэмүүжин Жамухыг хөнөөж, ихэд гашуудсантай адил билээ. Грекийн бурхадын хаан Зевс Леда гүнжийг хүчирхийлэхийн тулд хун болон хувирч, хунтай Ганымедийг өөрийн болгохын тулд бүргэд болж зүсээ хувилгадаг. Мөн сайхан залуу Хаяацинтын төлөө Баруун зүгийн салхины бурхан Зефир болон Аполло бурхан тэмцэлддэг³¹. Лесбос арлын шүлэгч Саффо, ан хийж, эмэгтэйчүүдээр хүрээлүүлэх дуртай Артемис (Диана) охин тэнгэр гэх мэтчилэн дүр нь байгалийн шинжтэй хүйс, соёлын шинжтэй гэрлэлтээс өмнө дурлах, хайрлах нь жам ёсны шинжтэй хэмээн ард түмэн диалоги үүсгэж байсны илрэл болно.

Персийн домог зүйд гарах хорон санаат нэгэн буюу Чөтгөр – Ахриман/Ахирман бол бараа бологч чөтгөрүүдээ төрүүлэхийн тулд өөртэйгээ анусаараа нөхцдөг хэмээн гардаг.³² Тус санаа нь Ойрхи Дорнодод хэлбэрээ олж байсан библийн домог зүйд, мөн хөрш зэргэлдээ Мезопотам (усан галав юүлэх, Бурхны зарлиг), Египетийн (хөвч таслах) домог зүйд ч нөлөөлсөн. Библийн домогзүйд тулгуурлан Иудаизм, Христэч үзэл, Исламын суурь бүрдсэн төдийгүй хэлбэр, хүйст баригдахгүй хувцас өмсөх, ижил хүйсийн харилцааг илт буруутгах болсон ажээ. Библийн домогзүйн үүднээс цор ганц Бурхан байх бөгөөд хүний замнах амьдралын нэг л зам бий. Тэрээр өөрийн үгээ Сонгомол хүмүүсээр л дамжуулж, хүн төрөлхтөнд хүргэдэг. Мөн зүй зохистой байх тухай зарлиг буулгаж, шийтгэхийг эн тэргүүнд үзэхийн хамт үг сонсохгүй хүүхдээ өршөөх, хайрлахдаа учир дутагдалтай.

³¹ <http://www.greekmythology.com/>

³² <http://www.mythencyclopedia.com/A-Am/Ahriman.html>

Жишээлбэл, Бурхны зөвшөөрөөгүй бэлгийн зан үйлтэй, нүгэлт Содом, Гоморра хотын иргэдийг өөрчлөхийн тулд зөнч Лут (исламаар Лот) илгээсэн ч чадахгүй болмогц нь хотыг үнсэн товрог болгодог³³.

Харин Христийн Шинэ гэрээнд библийн Бүтээгч халамжит, хайраар дүүрэн эцгийн дүрд хувирсан ч түүний хэлснээс өөр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг хайрлахгүй орхисон гэж болно. Бэлгийн зан үйлийг үл таашаах, ялангуяа ижил хүйсийн харилцах үл зөвшөөрөх хандлага нь аливаа соёлын дунд гэрлэлт, бэлгийн харилцаанаас ангид байхыг хөхиүлэн дэмжиж, сүм хийдийн шийдвэр хүчтэй болсноос үүдэлтэй. Эмэгтэй хүний бие махбодоос татгалзах, эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг хязгаарлах, тэдний баялаг хөрөнгө хураасан тойргийн гадна аваачих, объект гэж харах болсон нь Буддизмд эмэгтэй хүн бол дур хүслийн чөтгөр Марагийн охин гэж тодорхойлох, Гаутама амьдралын зовлонгийн шалтгааныг олохын тулд өөрийн эхнэр хүүхдээ үл тоож, орхиход хүрсэн байж болзошгүй. Буддагийн номлол, Винайн ёсонд эрэгтэй, эмэгтэй хүн лам байж болох тухай номлосон ч хермафродит (ubhatovyanjanaka), ижил хүйстнийг (pandaka) “хэт их” сексийн хүслээсээ шалтгаалан лам нарын гэгээрлийн замд саад учруулах, сүмийн дэг журмыг мөрдөхгүйд хүрч магад хэмээн тусгасан байдаг³⁴.

Европт сүмийн нөлөө улам өргөжиж, төртэй улам ойртон “Шулмыг ангуучлах”, “мөрдөн мөшгих”, үзэл сургаал, номлолыг үл зөвшөөрсөн этгээдийг шүүх, цаазаар авах эрх мэдэлтэй болсон. Хожим “Сэргэн мандлын зуун”, колоничлолын эрин үед Ази, Африк, Америк тивд библийн домогзүйд үндэслэсэн байдлаар амьдралыг

³³ <https://www.biblegateway.com/passage/?search=Genesis+19>

³⁴ Devdutt Pattanaik, Shikhandi and other tales they don't tell you, Penguin Books and Zubaan, New Delhi, 2014. 24 дэх тал.

илэрхийлэн болсон билээ. Дорнын ихэнх итгэл үнэмшил өөрийгөө “шашин”, “нийгмийн институт” гэж хэзээ ч харж байгаагүй боловч орчин цагийн шаардлагаар “эх сурвалжит судар”, “зан үйлдээ удирдлага болгох зарлиг”, “сүм” гэсэн загвараар өөрийгөө тодорхойлоход хүрч байна. Үүнийг нео-Буддизм, даян дэлхийн шинжтэй Сихизм, улс төрийн Хиндүизмээс харж болно.

Дүгнэлт

Одоогоос 1500 гаруй жилийн тэртээ Европт Грекийн домогзүйг библийн домогзүй шахаж, Ромын эзэн хаан христэч үзэлд уусгасан байна. Олон ургалч байдлыг үгүйсгэн нэгэн загвар шаардсанаар Грекийн олон бурхадын оронд библийн цор ганц Бурханд итгэж бишрэх болжээ. Таван зуун жилийн өмнө Сэргэн мандлын зуунд Грекийн домогзүй сэргэсэн ч Грек бурхадаас илүүтэйгээр Грекийн баатар, ялангуяа хэмжээлшгүй, туйлын эрх мэдэлтний эсрэг сөрөг зогссон хувь хүмүүсийг дүрслэх болсон юм. Энэ үеэс Бурхан, “ард түмэн” хэмээн санааг дахин эргэцүүлж эхэлсэн төдийгүй зарим сэтгэгч нийгмээ, хүмүүсээ төр хэрхэн тодорхойлж, хандаж байгааг судалсан. Маркс хөрөнгө чинээтэй болсон хүмүүс өөрсөддөө бусдаас илүү эрх мэдэл олгож, давуу эрх эдлэн бусдаас ангид амьдарч байгааг ангийн давхарга гэсэн санаагаар илэрхийлсэн ба тэрээр ямарваа нэгэн нийгмийн ангигүй тэгш байдал хангасан ертөнцийн тухай дуугарсан байна. Энэхүү санааны ачаар эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн эдлэх давуу байр суурь хаанаас эхтэйг асууж, эцгийн эрхт ёс буюу эрх мэдлийн тогтолцоотой тэмцэлдэж, феминизмийн үзэл санааны хөрс бүрдсэн бол Энэтхэгт “хүрч болшгүй” хүмүүс яагаад брахман кастаас дор байх

ёстойг эргэцүүлэхэд хүрсэн. Мөн олонхийн давуу байдлын эсрэг цөөнх дуугарч, соёлоор зохиосон эрэгтэй, эмэгтэй гэсэн хатуу чанд тодорхойлолтод багтдаггүй, нийгэмд өөрийгөө илэрхийлэхээс ямагт айдастай оршдог, олонх дунд цөөнх болсон, “үл үзэгдэгч” гей, лесби, бисексуаль, транжендэр, интерсекс, хижра, хүйсээ эсрэгцүүлэн хувцасладаг гэх мэтчилэн олон хүнийг күйр (queer) гэсэн нэр томьёонд багтаан илэрхийлжээ.

Грек, библийн, хятадын зэрэг ихэнх домогзүйд өөрийн эрхшээн төрсөн цор ганц амьдралдаа яаж зөв амьдрах тухай хүмүүсийн зан үйлийг чиглүүлэхийг зорьдог. Харин Хиндү домогзүй нь үхэх, төрөх хүрдэнд суурилан, хүмүүс бидний амьдрал нэгээр дуусахгүй төдийгүй өөрсдийн хийсэн үйлийн үрээр орших тул үүнд тохирсон цор ганц дүрэм байх боломжгүйг илэрхийлдэг. Зан үйл, дүрэм журам бол хүн төрөлхтнийг зохицуулахаас илүүтэй хүн төрөлхтөн ялгаатай байдалд найрсан оршихыг номловол зохино.

Библийн домогзүй	Хиндү домогзүй
<ul style="list-style-type: none"> • Нэг бурхан оршиж, нэг амьдралын зам заадаг. • Бурхны үг туйлын үнэн хууль. • Нэг дүрэм журамтай байна. • Дагахгүй бол шийтгэдэг. 	<ul style="list-style-type: none"> • Амьдрал асуудал биш. • Төрөх, үхэх хүрдэд орших тул нэг аргаар шийдэх боломжгүй. • Хэн дарлаж, хэн дарлуулаад байна гэхээс илүүтэй ертөнцийг хэрхэн харах вэ? • Хүн бүрт үйлчлэх нэг “үнэн”, “хууль” гэж байхгүй. • Учир нь хүн бүр дахин давтагдашгүй.

Аливаа түүх зохиомол бөгөөд анхдагч хэлбэрээ хадгалж байгааг хэн ч бүрэн тодорхойлж чадахгүй. Тодруулбал, орчин

үед 700 гаруй хэлбэрээр санскрит хэлнээс орчуулсан хэдэн түмэн шад шүлэгтэй Махабхарат туулийг хамгийн анх 2000 жилийн тэртээ бичиж тэмдэглэсэн гэж үздэг. Энэ туулийг анх Ганеш бурхан Вьяст, Вьяс шавь Вайсампаяанад, Вайсампаяана Ломахаршанд өгүүлсэн бол Ломахаршан сонссоноо өөрийн хүү Саутид, туульч Саути Наймиша ой дотор Шаунак аршид хэлсэн гэдэг. Үг бүрчлэн дамжуулсан гэх нотолгоо үгүй. Бхагават Гита хэрхэн тайлбарлахаас хамаарч харилцан адилгүй санаа илэрхийлдэг. Жишээлбэл, Косамби марксист, Тилак радикал, Ганди энх тайванч онцгөөс харж байсан³⁵. Харын ёсны үүднээс (секулар) Гитаг хүн төрөлхтөнд зориулсан цэцэн мэргэний номлол эсвэл цаг үеэ өнгөрөөсөн эцгийн эрхт ёсны үзэл суртал гэж магад.

Бодит байдлыг дүрслэх нь ³⁶			
Шашин	Сүсэг бишрэл	Итгэл үнэмшил, үнэт зүйл	Үнэн (субъектив)
Шинжлэх ухаан	Учир шалтгаан	Үйл явдал, мэдлэг	Үнэн (объектив)
Хүний хувийн туршлагын харилцан адилгүй аспект	Танин мэдэх харилцан адилгүй арга зам	Өөр өөр үр дүнд хүрдэг	Ялгаатай мөн чанар (оршихуйн үндэс)

Өндөр ёс суртахуунт зан төлөв (virtue), үнэт зүйл, соёл, амин чанар (national identity) зэрэг нийгмийн шинжлэх ухааны судлагдахуун нь тогтонги бус, хөдөлгөөнт (dynamic) шинжтэй учир бид субъектив үнэнг цор ганц хэмээн тодорхойлохоос ангид байх, үүгээр нийгмийн шинжлэх ухааны “үзэсгэлэн гоо”-г хэмжвэл зохино.

³⁵ Devdutt Pattanaik, Shikhandi and other tales they don't tell you, Penguin Books and Zubaan, New Delhi, 2014. 33 дахь тал.

³⁶ Nancy R. Pearcey, Total Truth: Liberating Christianity from Its Cultural Captivity, 2008. 31 дэх тал.

Шинжлэх ухаанч байдлаар объектив үнэнг хүлээн зөвшөөрөх хүртлээ хүн бүр “Бид дахин давтагдашгүй, эрхэм чанартай бодгал” хэмээн эн тэргүүнд харж хэвших, айдас, хүчирхийллээс ангид байх нь маш чухал.

Үүнтэй уялдан өөрт хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд хүний эрхийн үндэсний байгууллагаас дараах арга хэмжээг авах нь зүйтэй гэж зөвлөж байна.

Зөвлөмж:

- ◆ Түгээмэл байх хүний эрхийн зарчмын үүднээс аливаа соёлын (зан заншил, уламжлал, зан үйлийн ёслолоор илрэх) хэм хэмжээг дахин үнэлэх;
- ◆ Ямарваа нэгэн байдлаар хүнийг ялгаварлан гадуурхсан, дорд үзсэн, эрхэм чанарыг дээдлээгүй тохиолдолд хуулиар хориглох;
- ◆ Орчин үеийн нийгэмд илрэлээ олж байгаа “Биеэ үнэлэгчид бол бузар, амар хялбар аргаар амьдрахыг хүсдэг хүмүүс”, “Охид ариун бол төр ариун”, “Гадаад хүнтэй суусан эмэгтэйн үсийг хус”, “Төрийн гал тахих ёслолд эмэгтэй хүн оролцуулахгүй” зэрэг бусармаг үйлдлийг таслан зогсоох, үүнд хүний эрхийн үндэсний байгууллага мэргэжлийн төвшинд оройлон ажиллах;
- ◆ НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 2 дугаар зүйлд заасан арга хэмжээг авах;
- ◆ Жогжакартагийн зарчмыг төрийн байгууллагын албан хаагчдад эн тэргүүнд таниулах.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГАА БА ХҮНИЙ ЭРХ



Улсын Ерөнхий Прокурорын газрын
Сургалтын төвийн хяналтын прокурор

У.ЭРДЭНЭТУЯА

Өнөөгийн глобальчлагдсан хавтгай дэлхий дээр оршин тогтнож буй улс гүрний нэг нь Монгол Улс болохын хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхтэй холбогдсон мөрдөн байцаагч, прокурорын үйл ажиллагаанд үндэсний хууль тогтоомжоос гадна олон улсын гэрээ, конвенц, цаашилбал зарим тохиолдолд гадаадын зарим орны хууль тогтоомжийн заалтыг удирдлага болгон хэрэглэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар олон улсын гэрээ нь Монгол Улс нэгдэн орж, соёрхон баталснаар дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.¹ Түүнчлэн одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон шинээр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулах боломжтой болохыг баталгаажуулсан².

Эдгээр хуулийн зохицуулалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулж буй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад олон улсын хэм хэмжээг хэрэглэх замаар хүний эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх боломжтой болохыг харуулж байна.

Практикт, сүүлийн жилүүдэд Монгол Улсын хуулийн байгууллагаас гадаад оронд эрүүгийн хэргийн талаар туслалцаа үзүүлэх талаар хүсэлт илгээх, мөн гадаад орны хүсэлтийг биелүүлэх тоо өсөн нэмэгдэж байгаа³ боловч тийнхүү хүсэлт, даалгаврыг илгээхэд хэрхэн бэлтгэх, анхдагч мэдээллийг цуглуулах, олон улсын ямар хэм хэмжээг хэрхэн иш үндэс болгох талаарх мөрдөн байцаагч, прокуроруудын ойлголт нэг түвшинд хүрээгүй⁴; холбогдох сургалт байнга үргэлжилсэн байдлаар хийгддэггүй, гарын авлагын хүртээмж сул, мөн эрхзүйн хуучирсан, бүрхэг орчинтой байна.

¹ хэрэг хянан шийдвэрлэх хууль, 1,2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

³ Улсын Ерөнхий прокурорын газрын 2013, 2014 оны жилийн тайлан.

⁴ Нийслэлийн прокурорын газраас хийсэн судалгааны материал, 2014.

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

² Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 3 дугаар зүйл, 2002, Эрүүгийн

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад шаардлагатай тохиолдолд эрх зүйн харилцан туслалцаа хүсэх замаар нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхүйц баримт, мэдээллийг гадаад орноос хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан үндэслэл, журмын дагуу цуглуулан авах нь хэргийг бүх талаас нь бүрэн бодитойгоор шалгаж шийдвэрлэх, цаашилбал хүний эрхийг баталгаатай хамгаалах практик ач холбогдолтой. Тиймээс энэхүү өгүүлэгийн зорилго нь эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааны өнөөгийн эрх зүйн орчин ямар байгаа, түүнийг практикт хэрэгжүүлэхэд учирч буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх ямар арга зам байж болох талаар санал, дүгнэлтээ гаргахад оршино.

Эрх зүйн орчин ба бодит байдал

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад Монгол Улс нь гадаад улсын холбогдох хуулийн эрх бүхий байгууллагатай нотлох баримт цуглуулах, зарим эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулах, тодорхой мэдээлэл, баримт авах, өгөх, эрүүгийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх, шилжүүлэн авсан хэргийг шалгаж шийдвэрлэх⁵ зэргээр хамтран ажиллаж байна.

Монгол Улсын хуулийн байгууллага гадаад улсын холбогдох байгууллагатай эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх эрх зүйн үндэслэлийг 2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45 дугаар бүлгээр бэхжүүлж өгсөн ба 2016 оны 05 дугаар сард шинээр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ч мөн бие даасан бүлгийг оруулж өгсөн.

Өнөөдрийн байдлаар Монгол Улс нь гадаадын улс орнуудтай эрүүгийн хэргийн

талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд Эрүүгийн байцаан шийтгэх хуулиас гадна 17 орны Засгийн газартай байгуулсан гэрээ, түүнчлэн НҮБ-аас батлан гаргасан Авлигын эсрэг конвенци, Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц зэрэг олон талт гэрээ, конвенцийн⁶ хүрээнд хамтран ажиллах өргөн боломжтой байна.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий прокурорын тушаалаар 2015 онд батлагдсан прокурорын хяналтын ажилд болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд ЭБШХ-ийг дагаж мөрдөх аргачилсан зааварт эрх зүйн харилцан туслалцааны асуудлыг бие даасан бүлгээр зохицуулж өгснийг практикт мөрдөж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад Монгол Улс дээр дурдсан хууль, гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд буюу эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа бодит байдалд хэрхэн хэрэгжиж буйд уншигч таны анхаарлыг хандуулья.

Нэг. “Эрх бүхий төв байгууллага” нэг байх шаардлага.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэдэг байгууллага нь “эрх бүхий төв байгууллага” байдаг. НҮБ-аас дэлхийн улсуудад гэмт хэрэгтэй тэмцэх, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд тавьдаг гол шаардлагын нэг нь улс бүрт “эрх бүхий төв байгууллага” байх, ингэхдээ хэд хэд бус улсын хэмжээнд нэг байхыг илүү зохистой гэж үздэг.⁷

Одоогоор Монгол Улсад эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар

⁶ Гэрээний жарсаалтыг <http://mfa.gov.mn/images/ppbx/zg-2-talt-geree.pdf> болон <http://mfa.gov.mn/images/ppbx/1.pdf>-с үзнэ үү.

⁷ https://www.unodc.org/documents/organized-crime/Publications/Mutual_Legal_Assistance_Ebook_E.pdf, part E, p33.

⁵ Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002, 402, 403 дугаар зүйл.

гадаад улстай харилцах “эрх бүхий төв байгууллага” нь 17 орны Засгийн газар хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдэд зааснаар Хууль зүйн яам, Улсын Ерөнхий прокурорын газар, Улсын Дээд шүүх, Цагдаагийн ерөнхий газар зэрэг хэд хэдэн газар байгаа. Дээрх 17 гэрээ, хэлэлцээрээс харахад, 13-т нь “эрх бүхий төв байгууллага” Улсын Ерөнхий прокурорын газар байдаг. Зарим гэрээнд, тухайлбал, ОХУ-тай байгуулсан гэрээний 3 дугаар зүйлд заахдаа Монгол Улсын хувьд Монгол Улсын Хууль зүйн яам, Улсын Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн Ерөнхий газраар тус тус дамжуулан харилцаж байхаар заасан. Практикт, Улсын Ерөнхий прокурорын газар нь Оросын талтай шууд харилцаж байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 6-д⁸ зааснаар Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “эрх зүйн туслалцаа”-ны асуудал багтсан байдаг. Дээрх байдлаас харахад, эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар Монгол улсын хувьд нэг “эрх бүхий төв байгууллага”-тай байх эрх зүйн боломж одоогийн байдлаар бүрхэг, ойлгомжгүй байгааг харуулж байна.

Хоёр. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага.

Монгол улсын нэгдэн олон талт гэрээ, конвенцийн заалтуудаар нээж өгсөн боломжуудыг дотоодын хууль тогтоомжоор хориглосон заалт байхгүй байгаа ч зориуд тусган баталгаажуулах нь практик хэрэглээний ач холбогдолтой гэж үзэж байна. Тухайлбал, 2002, 2016 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад аль алинд нь хамтарсан болон зэрэгцсэн мөрдөн

байцаалтын ажиллагаа явуулах талаар ямар нэг зохицуулалт байхгүй байгаа бол Авлигын эсрэг конвенцийн 49, Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц буюу Палермогийн Конвенцийн 19 дүгээр зүйлд тус тус энэ асуудал нээлттэй байна. Мөн гэрч, хохирогч, шинжээч нутаг дэвсгэрт нь байгаа оролцогч улс нь нөгөө талын хүсэлтийн дагуу боломжтой нөхцөлд дотоодын хууль тогтоомжийнх нь тулгуур зарчимтай нийцэж байвал видео уулзалтын хэлбэрээр байцаалтыг явуулах, хэрэг хэлэлцэхийг зөвшөөрч, энэ талаар урьдчилан тохиролцож болохыг дээрх 2 конвенцид⁹ тус тус баталгаажуулж өгсөн. Манай улсын Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тулгуур зарчмуудад дээрх заалтыг хориглосон шинжтэй заалт тусгагдаагүй байгааг энэ дашрамд дурдах нь зүйтэй.

Гурав. Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа хүсч буй хүсэлт, даалгаврын агуулгад тавигдах шаардлагыг хуульд дэлгэрэнгүй тодорхой болгох

а) Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45 дугаар бүлгээр гадаад улсад хүсэлт, даалгавар илгээх, түүнийг боловсруулах, гадаад улсын эрх бүхий байгууллагын даалгаврыг биелүүлэх талаар заалтууд байгаа ч процессын хувьд нарийвчлан тодруулах буюу холбогдох загвар хүсэлтийг боловсруулан гаргах шаардлагатай болох нь практикаас харагдсан¹⁰. Тухайлбал, гадаад улсад илгээж байгаа мөрдөн байцаагчийн даалгаварт уг даалгавартай холбоотой хуулийн этгээдийн хувьд хуульд¹¹ заасны

⁹ Авлигын эсрэг конвенцийн 15 дугаар зүйлийн 18, Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенцийн 18 дугаар зүйлийн 15 дахь хэсэг.

¹⁰ Нийслэлийн прокурорын газраас 2015 оны 1-р улиралд хийсэн шалгалтын материалаас.

¹¹ Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002, 399 дугаар зүйлийн 399.1.4 дэх хэсэг; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2016, 41-р бүлэг, 41.2 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэг.

⁸ <http://www.legalinfo.mn/law/details/344>

дагуу түүний зөвхөн нэр, хаягийг дурдах нь даалгаврыг хүлээн авагч талын хувьд хангалтгүй мэдээлэл байдаг. Тухайн хуулийн этгээдийн нэр, оршин байгаа газар, хаяг, утасны дугаар, и-мэйл хаяг, улсын бүртгэлийн дугаар, бүртгүүлсэн газар тодорхой байхыг хүсэлт хүлээн авагч тал ямагт шаардаж байдаг.

б) Хүнийг шашин шүтлэг, үндэс угсаа, гарал үүсэл, улс төрийн үзэл бодлоос болж түүнийг мөрдөн байцаах, ял шийтгэх зорилго агуулаагүй, хүнийг нэг гэмт хэрэгт болон өмнө шийтгэгдсэн хэрэгт дахин шалгаагүй болох талаар баталгааг эрх зүйн туслалцаа хүсч байгаа тохиолдолд заавал гаргадаг байх, үүнийг мөн хууль, зааварт тусган баталгаажуулах.

Тийнхүү баталгаа гаргаж өгөх явдал аль ч тохиолдолд хүсэлт, даалгаврын нэг хэсэг нь байдаг. Зарим улс тухайлбал, БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонг Конг өөрийн хуулиар “татвар хураах анхдагч зорилго агуулаагүй, улс төрийн шалтгааны улмаас хүнийг мөрдөж, яллах зорилго агуулаагүй талаар” тус тус баталгаа гаргахыг шаарддаг, уг баталгааг гаргаагүй байх нь тухайн хүсэлтийг биелүүлэхээс татгалзах үндэслэл нь болж байдаг¹².

Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 399 дүгээр зүйлд ихэнх оронд тухайн хүсэлт, даалгаврыг биелүүлэхээс татгалзах гол үндэслэл болдог “баталгаа” буюу хүсэлтэд дурдагдсан мэдээллийг хүсэлтэд заасны дагуу тухайн эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд ашиглах, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх тухай нууцын баталгаа болон даалгаврыг хүлээн авагч орны эрх ашиг, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулах

байдлаар ашиглахгүй байх талаарх шаардлага, гэрээгүй оронтой харилцахад зайлшгүй хэрэглэгддэг харилцан бие биедээ туслалцаа үзүүлэх (reciprocity) зарчмыг тусгаж өгөх нь зүйтэй болов уу.

Дөрөв. Хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 400 дугаар зүйлийн 400.1-д “Олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гадаад улсад байнга буюу түр хугацаагаар оршин сууж байгаа Монгол Улсын харьяат гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээчийг тухайн улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан дуудаж болно” гэж заасан байдаг.

Энэ заалт нь гадаад улсад байгаа Монгол Улсын иргэнийг Монгол Улсын мөрдөн байцаагч тухайн улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан зарлан дуудаж болох талаар зохицуулсан байна.

Практикт, ялангуяа БНХАУ-ын Эрээн хотод байрлах Монгол Улсын Консулын газрын байранд Монгол Улсын Цагдаагийн байгууллагын ажилтнууд Монгол Улсын иргэдээс гэрчийг байцаалт авах явдал нэлээд гардаг. Үүнийг тайлбарлахдаа, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 3 дугаар зүйлийн 3.1¹³-д зааснаар байцаан шийтгэх ажиллагааг Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулах, тодруулбал Монгол Улсын нутаг дэвсгэрт хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөг хамаарч байгаа тул эрх зүйн үндэслэл нь байна гэж тайлбарладаг.

¹² Mutual Assistance on Criminal Matters Ordinance of Hong Kong, [http://www.legislation.gov.hk/blis_pdf.nsf/6799165D2FEE3FA94825755E0033E5327A0315FC5CDE045C482575EF0013BD2B/\\$FILE/CAP_525_e_b5.pdf](http://www.legislation.gov.hk/blis_pdf.nsf/6799165D2FEE3FA94825755E0033E5327A0315FC5CDE045C482575EF0013BD2B/$FILE/CAP_525_e_b5.pdf)

¹³ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 3 дугаар зүйлийн 3.1. “Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаань гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан бүх нөхцөлд энэ хуулийн дагуу явагдана.”

Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч нар нь нэг мөрдөн байцаагчийнхаа даалгавраар гадаад улсад очих, гадаад улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яамны байранд байцаалт авах талаар урьдчилан бичгээр ямар нэг зөвшөөрөл аваагүй байхдаа Монгол Улсын иргэнийг өөрсдийн утас, и-мэйлээр дуудан, гэрч, хохирогчоор байцаах, тайлбар авах эрх зүйн ямар нэг үндэслэлгүй байна.

Тав. Анхдагч мэдээллийг цуглуулсан байх шаардлага

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа хүсэхдээ тухайн хүсэлттэй холбоотой анхдагч мэдээллийг цуглуулсан байх шаардлагатай байдаг. Энэ шаардлага биелэгдээгүй байх нь хэт ерөнхий шинжтэй даалгавар бичих, хүлээн авагч тал биелүүлэхээс татгалзах, буцаах, нэмэлт мэдээлэл хүсэх, улмаар хэргийн хугацаа сунгагдах, шийдвэрлэлтийг удаашруулах шалтгааны нэг болж байна.¹⁴

Мөн Монгол Улсын прокурор, цагдаагийн байгууллага ижил түвшний байгууллагатай хамтран ажиллах талаар байгуулсан санамж бичиг, хэлэлцээрүүдийг үндэслэн авсан мэдээлэлд тулгуурлан эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа хүсч даалгавар илгээх боломжтой. Гэвч практикт хоёр орны хил залгаа хуулийн байгууллагууд хоорондоо хамтран ажиллах санамж бичиг, гэрээний дагуу ялангуяа хилийн зөрчил, малын хулгайн гэмт хэрэгт олж авсан баримт сэлтийг шүүх үнэлэхгүйгээр хэргийг буцаах тохиолдлууд гарч байхад прокурор түүнийг нотлох баримтын хэмжээнд үнэлэн хэргийг эцэслэн шийдвэрлэх явдал байсаар байна¹⁵.

¹⁴ Нийслэлийн прокурорын газраас 2015 оны 1-р улиралд хийсэн шалгалтын материалаас.

¹⁵ Мөн тэнд.

Зургаа. Орчуулгын чанар, зардалтай холбогдсон асуудал

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 398 дугаар зүйлийн 398.3 дахь хэсэгт “Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол даалгаврыг явуулж байгаа улсын хэл дээр үйлдэнэ” гэсэн, мөн хуулийн 399 дүгээр зүйлийн 399.2 дахь хэсэгт “Даалгавар түүнд хавсаргаж байгаа баримт бичиг, нотлох баримтыг хүлээн авах улсын албан ёсны хэл дээр орчуулж, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, шаардлагатай бол тэмдэг дарна” гэсэн заалт байгаа хэдий ч бодит байдалд орчуулга, түүний зардал, чанарт тавих хяналт хүндрэлтэй асуудлын нэг болсон.

Тухайн хэрэгт бичигдсэн хүсэлт, даалгаврын орчуулга хийгдэхэд тодорхой цаг хугацаа шаардлагатай байдаг, тухайн хүсэлт даалгавар нь шаардлага хангаагүйгээс буцсан тохиолдолд орчуулгын зардал мөн дахин гаргах шаардлага үүсч хүндрэл гардаг, түүнчлэн шаардлагын түвшинд мэргэжлийн орчуулгыг богино хугацаанд хийх чадвартай орчуулагч нарын талаарх нэгдсэн мэдээлэл, жагсаалт мөрдөн байцаагч, прокуроруудад байдаггүй, нэгэнт хийгдсэн орчуулга нь чанарын шаардлага хангасан эсэхийг мөрдөн байцаагч, прокурорын хэн аль нь хянах боломжгүй, энэ хяналтыг эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгаврыг гадаад улсад илгээж байгаа эрх бүхий төв байгууллага болох Улсын Ерөнхий прокурорын газар, Хууль зүйн яамны аль нь тавих, хэрэв орчуулганд хяналт тавих бол мэргэжлийн орчуулагч тэнд ажиллах эсэх талаарх асуудал өнөөдрийг хүртэл тодорхойгүй, ямар нэг зохицуулалтгүй явж иржээ. Энэ нь зарим талаар хэргийн нууцлалтай ч холбоотой байна.

Долоо. Гарын авлага

Гарын авлагын хүртээмж хангалтгүй, тухайн хүсэлт хүлээн авагч орны эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай бие даасан хуулиудын монгол хэл дээрх албан ёсны орчуулга нь ялангуяа уг хүсэлтийг тавьдаг гол субъектүүд болох прокурор, мөрдөн байцаагч нарын албан хэрэгцээнд нэн тэргүүнд шаардлагатай байна. Энэ нь олон улсын гэрээ, хэлэлцээрээс гадна тухайн орны хуулиар тавигдсан шаардлага хангасан хүсэлт даалгаврыг боловсруулан илгээж, хариуг шуурхай авах, хэргийг аль болох түргэн хугацаанд бүрэн бодитой шийдвэрлэхэд дөхөм болох талтай.

Найм. Сургалт

Монгол Улсын хувьд мөрдөн байцаагч, прокуроруудын хүсэлт, даалгаврыг боловсруулах ур чадвар шаардлагын түвшинд хүрэхгүй байгаа нь тэдэнд зориулсан гарын авлага, үргэлжилсэн сургалт зайлшгүй хэрэгцээтэй байгааг харуулж байна. Тухайлбал, зөвхөн 2015 онд Улсын Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэст гадаад улсад илгээхээр ирүүлсэн нийт 32 даалгаврын 18-ийг буюу 60 шахам хувь, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 20 даалгаврын 7 буюу 35 хувь нь хууль, гэрээ хэлэлцээрийн шаардлагад нийцээгүй үндэслэлээр буцаагдсан байна. Үүнд,

- ✓ Хүсэлт, даалгаврын зорилго, түүнийг гадаад улсад зайлшгүй гүйцэтгүүлэх шаардлага тодорхойгүй
- ✓ Мөрдөн байцаалтаар тогтоогдсон нөхцөл байдлуудын талаар тодорхой дурддаггүй
- ✓ Шаардлагатай нотлох баримтуудыг хавсаргаж ирүүлдэггүй
- ✓ Даалгаврыг утга, найруулгын хувьд

алдаатай, хэт товч бичих, даалгаврын агуулгаас хальсан, хамааралгүй асуудлыг дурддаг

- ✓ Орчуулгагүй ирүүлдэг
- ✓ Харилцах төв байгууллагаар дамжуулж ирүүлээгүй
- ✓ Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гэрээний холбогдох зүйл хэсгийг баримтлан бичдэггүй, огт хамааралгүй зүйл хэсгийг баримтлан ирүүлдэг
- ✓ Гэрээний нэр, он сар өдрийг буруу бичдэг¹⁶ зөрчил нийтлэг гарчээ.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд гарч буй дээр дурдагдсан тулгамдсан асуудлууд, баримт, фактууд нь эрүүгийн хэргийг бүх талаас нь бүрэн бодитой шалгаж, хурдан шуурхай шийдвэрлэх явцыг удаашруулж, улмаар хохирогч, сэжигтэн зэрэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдыг чирэгдүүлэх, хүний эрх зөрчигдөх эрсдэлийг дагуулж байгаа тул тэдгээрийг зайлшгүй шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

ДҮГНЭЛТ

Дээрх нөхцөл байдлуудад дүгнэлт хийхэд, цаашид Монгол Улс нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны салшгүй нэг хэсэг болсон эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгаврыг илгээх, биелүүлэхтэй холбогдсон ажиллагаанд чанарын ахиц гаргаж, олон улсын жишиг стандарт, хэм хэмжээнд заасан шаардлагыг хангахын тулд дараах алхмуудыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд,

1. “Эрх бүхий нэг төв байгууллага”-тай байх

Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр харилцах “эрх

¹⁶ Улсын Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн мэдээлэл, 2015 оны 12 дугаар сар.

бүхий төв байгууллага” нь нэг байж, гадаад улсад илгээгдэж байгаа, гадаад улсаас ирж байгаа хүсэлт, даалгаврын гүйцэтгэл болон орчуулгын чанар тавих хяналтыг сайжруулах, холбогдох тоо баримт, мэдээ, мэдээллийг нэгдсэн байдлаар хянах, бүртгэх, мэдээллийн нэг баазтай байхад чухал үүрэгтэй байна. Үүнийг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хоёр талт гэрээ, хэлэлцээрт болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хийх боломжтой.

2. Хууль зүйн мэргэжлийн орчуулга хийх чадвартай орчуулагчийг сонгох, томилох, хянах асуудлыг журамлах

Эрүүгийн хэргийн нууцлалын байдал, орчуулга хийх зардал, цаг хугацаа, чанар зэрэг асуудалтай холбоотойгоор эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааны явцад хууль зүйн мэргэжлийн орчуулга хийх чадвартай орчуулагчийг сонгох, томилох, тэдгээрийн зардлыг шийдвэрлэхтэй холбогдсон асуудлыг зохих байгууллагууд нарийвчлан журамлах бодит шаардлага үүссэн болохыг өмнө өгүүлсэн.

3. Гадаад орнуудын бие даасан хуулийн албан ёсны орчуулга, Эрх зүйн харилцан туслалцаатай холбоотой гэрээ, хэлэлцээр, гарын авлагаар хуульчдыг хангах арга хэмжээ авах.

4. Монгол Улсыг гадаад улсад төлөөлөн томилогдон ажиллаж байгаа Консулын ажилтан, албан тушаалтнуудын Консулын

харилцааны тухай Венийн конвенцоор¹⁷ хүлээсэн үүрэг хариуцлага, олон улсын гэрээ хэлэлцээр болон өөрийн орны хууль тогтоомжийн мэдлэгийг сайжруулах, тэднээс авдаг шалгалтанд энэ талаар тодорхой асуудлыг тусгадаг байх. Ингэснээр гадаад улсад тавигдсан эрүүгийн хэргийн талаарх хүсэлт, даалгаврын гүйцэтгэл, чанар үр дүн, богино хугацаанд зөв шийдвэрлүүлэх, бусад холбогдох арга хэмжээг авахуулах боломжийг нэмэгдүүлнэ.

5. Эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгаврыг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан шаардлагын хэмжээнд хэрхэн боловсруулах, даалгаварт тусгагдсан байх ёстой тодорхой мэдээллүүдийг албан болон албан бусаар хэрхэн олж авах арга замуудын талаар хуульчдад зориулсан гарын авлагыг боловсронгуй, хүртээмжтэй болгох, холбогдох үргэлжилсэн сургалтыг тогтмол зохион байгуулахад хуулийн байгууллагууд, төсөл хөтөлбөрүүд хамтран ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Гарын авлага гаргах, сургалт зохион байгуулах асуудал нь хууль, заавраар тусгайлан зохицуулах боломжгүй асуудал байдаг. Мөн эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгаврыг бичих ур чадварыг нэг удаагийн сургалтаар эзэмших боломжгүй буюу анхан, дунд, ахисан шатны сургалт зайлшгүй шаардлагатай байдаг.

¹⁷ Консулын харилцааны тухай 1963 оны Венийн Конвенц, 5 дугаар зүйл.

ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАНГАХАД ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД



Хүний эрхийн Үндэсний Комиссын
Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Г.ЗОЛЖАРГАЛ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасны дагуу тус Комисс нь бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улс дах хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл бичиж, Улсын Их Хуралд танилцуулдаг. Илтгэл нь хүний эрхийн анхаарал татсан асуудалд хууль тогтоох байгууллага, олон нийтийн анхаарлыг хандуулах замаар хууль тогтоомж, бодлого, практикийн өөрчлөлт гаргуулах нөлөөллийн чухал хэрэгсэл юм.

Хохирогчийн эрхийг хангах асуудлаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 2003 оноос эхлэн судалгаа хийж, 2004, 2008, 2009, 2013, 2014, 2015 онуудад Улсын Их Хуралд танилцуулсан “Монгол Улс дах хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”-дээ тусгаж, санал зөвлөмж гаргаж байв. Гэрч, хохирогчийг хамгаалах, нөхөн төлбөр олгох эрх зүйн орчныг бий болгох зэрэг илтгэлүүдэд дэвшүүлж байсан санал, зөвлөмж хэрэгжсэн. Харин одоо ч анхаарал хандуулах шаардлагатай хэвээр байгаа дараах асуудлууд байна.

“Хохирогч”-ийг хуульд тодорхойлсон нь
НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”, “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”, түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”-д нэгдэн орсны хувьд Монгол Улс хохирогчийг хамгаалах, эрхийг нь сэргээн эдлүүлэх талаарх олон улсын хэм хэмжээг мөрдөх ёстой билээ.

Дээр дурдсан олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан эрхийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 тогтоолоор баталсан “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашиглах явдлын хохирогчийн асуудлаарх эрх зүйн үндсэн зарчмуудын тухай тунхаглал”, 2005 оны 60/147 тогтоолоор баталсан “Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний

зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд”, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 2005/20 тогтоолоор баталсан “Хүүхэд хохирогч, гэрч болсон гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд баримтлах эрх зүйн удирдамж”-д илүү нарийвчлан авч үзсэн байдаг.

Эдгээр зарчмуудад “хохирогч” гэж “гэмт хэрэг, эрх мэдлээ хортойгоор ашигласан болон хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас бие эрхтэн, оюун сэтгэхүйн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, сэтгэл санааны зовлон шаналалд автсан, эд материалын хохирол хүлээсэн, үндсэн эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдсөн хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ” гэж тодорхойлжээ.¹

Харин манай улсад хохирогч гэж хэн бэ гэдгийг тодорхойлохдоо Гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. дэх хэсэгт заасны дагуу Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн “гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ” гэсэн тодорхойлолтыг баримталж байна. Энэ тодорхойлолт нь үндсэн эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдсөн этгээдийг орхигдуулсан нь хуульд зааснаас бусад хэлбэрээр эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн этгээд эрхээ сэргээлгэж, хохирлоо төлүүлэх боломжийг тодорхой хэмжээнд хязгаарлаж байгаа юм.

Олон улсын дээрх баримт бичгүүдэд зааснаар тухайн хүнийг хохироосон үйлдлийн гэм буруутан нь тогтоогдсон эсэхээс үл хамааран “хохирогч”-ийг тогтооно гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдсон,

хэрэг илэрсэн эсэхээс үл хамаарч хохирсон этгээд “хохирогч”-оор тооцогдож, төрийн хамгаалалтад орох, зохих дэмжлэг туслалцаа авах эрх үүсдэг байна. Харин манай улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зөвхөн гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, ял шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш л хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал тавигддаг учраас эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийн цаана олон мянган иргэд хохирч, зөрчигдсөн эрх, эрх чөлөөгөө сэргээлгэж чадахгүй үлдэж байна.

“Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашиглах явдлын хохирогчийн талаарх эрх зүйн үндсэн зарчмуудын тухай тунхаглал”-д зааснаар хохирогч гэдэгт шаардлагатай тохиолдолд хохирогчийн гэр бүлийн гишүүд эсвэл түүний шууд асрамжинд байдаг этгээд түүнчлэн зовж шаналж буй хохирогчид туслалцаа үзүүлэх, хохирохоос урьдчилан сэргийлэхээр оролцохдоо гэмтэж бэртсэн, хохирсон этгээдийг хамааруулж ойлгодог. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4. дэх хэсэгт “Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно” гэсэн нь тухайн этгээд хохирогчтой адил статустай байх эсэхийг хэлж буй нь тодорхойгүй байна.

Эрх сэргээн эдлүүлэх, хохирол арилгах талаар

Гэмт хэргийн хохирогч

НҮБ-ын зарчмуудад заасны дагуу гэм буруутан буюу гуравдагч этгээд нь хохирогч, түүний гэр бүл, асрамжинд байсан хүмүүст учруулсан хохирлыг шударгаар арилгах ёстой. Өөрөөр хэлбэл

¹ “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 7 дахь илтгэл”, 2008, 69 дэх тал

эд хөрөнгийг нь эргүүлж өгөх, учирсан хохиролд нь нөхөн төлбөр төлөх, хохирсны улмаас үүссэн зардлыг төлөх, шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, эрхийг нь сэргээн эдлүүлэх асуудал үүнд багтдаг.

Хохирлыг бүрэн дүүрэн барагдуулах нь хохирол нөхөн төлүүлэх эрх хангагдах үндсэн нөхцөл мөн. НҮБ-ын зарчмуудад нөхөн төлбөр нь хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн хэр хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургуульд хамрагдсан байдлыг аль болох өмнөх хэмжээнд нь хүрэхүйцээр сэргээн бүрдүүлэх ёстой гэж заасан байдаг. Хохирогчийн бие махбод, сэтгэл санаа, зан суртахуунд учирсан хохирол, ажил хөдөлмөр, сургууль боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ зэрэг алдагдсан нөхцөл, бодит болон бий болох орлого, хууль зүй, сэтгэл зүй, эмнэлэг, нийгмийн үйлчилгээний зардлыг бүрэн гүйцэд барагдуулахаар олон улсын эрх зүйн баримт бичигт заасан.²

УИХ-ын Хууль зүйн Байнгын Хорооны 2015 оны 29 дүгээр тогтоолоор тус Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлийг хэлэлцээд хохирогчдын эрхийг хамгаалах, эдийн бус гэм хорын хэмжээг мөнгөн дүнгээр тооцож нөхөн барагдуулахад чиглэсэн зохицуулалтыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төслүүдэд тусгаж, УИХ-д өргөн мэдүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон билээ. Одоогийн шүүхийн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээний зардал, оршуулгын зардал, тээврийн зардлын баримт, түүнчлэн аймаг,

дүүргийн Засаг даргын тамгын газрын санхүүгийн хэлтсийн үнэлгээний комиссын үнэлгээ зэргийг харгалзан хохирлыг тогтоож, нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргаж байна. Өөрөөр хэлбэл энэхүү зардалд эд хөрөнгийн хохирол хамаарах бөгөөд эдийн бус хохирол тооцогдохгүй орхигддог. Ялангуяа гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нотлогдоогүй хэсгийг барагдуулахаар иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг шүүхийн тогтоолд дурддаг боловч иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргахад санаа сэтгэл, бие эрхтэн, амь насны хохирлыг мөнгөөр үнэлэх зохицуулалтгүйн улмаас хохирлоо нэхэмжлэх эрхгүй болдог³. Тиймээс эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, олон улсын болон бусад улс орны эрх зүйн хөгжлийн чиг хандлагыг харьцуулан судалж, өөрийн улсын онцлог дадал, практикт нийцүүлэн энэхүү хуулийн төсөлд шүүх хэргийг шийдвэрлэхдээ баримтлах эдийн бус хохирлын хэмжээг тооцох аргачлалыг батлан мөрдүүлэх шаардлагатай байна.

Олон улсын зарчмуудад хохирогч шуурхай, шударга, өртөг багатай, хүртээмжтэй байдлаар хохирлоо барагдуулах бололцоог төр хангасан байхыг үүрэг болгодог. Энэ нь зөвхөн шүүхээр барагдуулахыг хэлэхгүй бөгөөд захиргааны журам, тогтолцоо мөн энд багтана. Энэ хүрээнд эвлэрүүлэн зуучлах, арбитр эсвэл тухайн улсын тогтсон заншлын эрх зүйн арга хэлбэрээр маргааныг шийдвэрлэх албан бус арга хэлбэрүүдийг авч үзэхийг зөвлөсөн байдаг.

Манай улсын хууль тогтоомжийн зохицуулалтаар шүүхээр шийдвэрлэх хэрэг

² Мөн тэнд

³ Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаа, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, 2013

маргааны хувьд хэргийн шинж байдал, шүүхийн шийдвэрийг давж заалдах, хянуулах эсэхээс хамаарч, хохирлоо нөхөн төлүүлэх шийдвэр гаргуулах хүртэл ойролцоогоор 2 сар 7 хоногоос 35 сар хүртэлх хугацаа шаардлагатай байгаа юм. Хохирлоо нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарсан ч энэ шийдвэр биелэгдэх хүртэл дахиад багагүй хоног, сар болж, зарим тохиолдолд биелэгдэх эсэх нь ч эргэлзээтэй байдаг⁴.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих НҮБ-ын хороодын болон манай улсын хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцээд НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжүүдэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон эмэгтэйчүүдэд нөхөн олговор олгох тэднийг хамгаалалт (хамгаалалтад авах шүүхийн шийдвэр, эмнэлгийн шинжилгээ, нөхөн сэргээх эмчилгээ)-д нэн даруй авах, халамж авдаг болох нөхцөлүүдийг хангах, алслагдсан газруудад хамгаалалтын байрыг илүү олноор барих, хүн худалдаалах гэмт хэргийн бүх хохирогчдод нөхөн олговор олгож, боломжийн хэрээр нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах, институцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчдод эдлэх эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэх, хангалттай хэмжээний нөхөн олговор болон нөхөн сэргээх үйлчилгээ авах нөхцөлийг хангах үүднээс эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэрэгт бие даасан, үр нөлөө бүхий мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэхийг зөвлөсөн байдаг.⁵ Эдгээр зөвлөмжийг хэрхэн

хэрэгжүүлсэн талаараа Монгол Улсын Засгийн газар дараагийн ээлжит тайландаа тусгах үүрэг хүлээж байгаа юм.

Төрийн албан тушаалтны буруутай үйл ажиллагааны хохирогч

“Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашиглах явдлын хохирогчийн талаарх эрх зүйн үндсэн зарчмуудын тухай тунхаглал”-д гэм буруутан нөхөн төлбөрийг бүрэн төлөх чадваргүй бол бие махбодод ноцтой гэмтэл учирсан, эд эрхтэн, сэтгэцийн эрүүл мэндээрээ хохирсон хохирогч, хэрэв хохирогч нас барсан эсвэл хөдөлмөрийн болон оюуны чадвараа алдсан бол түүний гэр бүл, асрамжинд байсан хүмүүст төрөөс нөхөн төлбөр олгох, энэ зорилгоор засгийн газрын сан байгуулж, өргөжүүлэхийг зөвлөжээ.

Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт “Зохих сан бий болгох, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах даатгалд хамруулах зэргээр гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, эхний ээлжинд хариуцагч нь тодорхойгүй, эсхүл төлбөрийн чадваргүй иргэдийн хохирлыг төр урьдчилан төлж хариуцагчаар нөхөн төлүүлэх журмыг хуулиар тогтоон, цаашид боловсронгуй болгоно” гэсэн зорилт бий. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1. дэх хэсэгт гэмт хэргийн хохирогчид Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³ дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгохоор заасан боловч энэ нь *нэгдүгээрт* тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчдод л олгогдохоор, *хоёрдугаарт* амь нас хохирсон юм уу хүнд гэмтэл учирсан нөхцөлд л олгогдохоор хязгаарлагдмал байна. Хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлын нөхөн төлбөр огт орхигдсон байна.

⁴ “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 7 дахь илтгэл”, 2008, 69 дэх тал

⁵ НҮБ-ын Хүний эрхийн Хорооны зөвлөмж, 2010 он, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны зөвлөмж, 2009 он, НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн зөвлөмж, 2010, 2015 он

Тус хуулийн дагуу батлагдсан “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”-ын дагуу өргөдөл гаргасан хохирогчдод нөхөн төлбөр олгох асуудлыг Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, 2015 онд Хууль зүйн сайдын тушаалаар 16 хохирогчдод 51.275.822 сая төгрөгийн нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэжээ⁶.

Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас олгох нөхөн төлбөрийн хамрах хүрээ нь ийм хязгаарлагдмал байгаа тул хохирогчдын хохирлоо арилгуулах бололцоог нэмэгдүүлэхийн тулд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шатанд хэрэгт холбогдогчийн эд хөрөнгийг илрүүлэх, хамгаалах, хохирлын хэмжээг тогтоох, иргэний нэхэмжлэгчийн эрх, үүргийг хангах зэрэг ажиллагааг сайжруулах хэрэгтэй байна. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэргийг илрүүлэх, гэм бурууг нотлоход голлон анхаарч, хохирол нөхөн төлүүлэх ажиллагааг орхигдуулах хандлагатай байдаг тул энэхүү дутагдлыг арилгаж, хөрөнгө хамгаалах ажиллагааг иргэний нэхэмжлэл гаргаж болох бүх хэргүүдэд хүсэлт гарсан эсэхийг үл харгалзан хийж хэвших, энэ ажиллагаанд тавих прокурорын хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг Хүний эрхийн Үндэсний Комисс өмнөх илтгэлдээ дурдаж байсан⁷.

“Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашиглах явдлын хохирогчийн талаарх эрх зүйн үндсэн зарчмуудын тухай тунхаглал”-д төрийн албан тушаалтан буюу төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчсөний улмаас иргэнд учирсан хохирлыг төр хариуцан барагдуулна гэж заасан байдаг.

⁶ <http://mojha.gov.mn/images/files/Tailan-2016-onii-ehonii-hagas-jil.pdf>

⁷ “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 7 дахь илтгэл”, 2008, 69 дэх тал

Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2010 оны 11 дүгээр сарын 1-нээс 19-ний өдрийн 45 дугаар хуралдаанаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тайланг хэлэлцээд өгсөн зөвлөмжийн 17-д “Эрүүдэн шүүх, зүй бус аливаа үйлдлийн хохирогчдыг шударга шүүх, нөхөн олговор, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах үр дүнтэй, цогц арга хэмжээ аваагүй байгаад Хороо харамсаж байна. Нөхөн олговрыг зохицуулсан Монгол Улсын хууль тогтоомжид эрүүдэн шүүхээс болж хохирсон хохирогчдод нөхөн олговор олгох эрх зүйн үндэс бүрэлдээгүй байгааг Хороо онцолж байна. Үүнийг Монгол Улсад ажиллаад ирснийхээ дараа Тусгай илтгэгч мөн адил хөндсөн юм” гэж дурдаад “Оролцогч улс эрүү шүүлт тулгах үйлдлийн хохирогчдыг нөхөн олговор авах боломжоор хангах, нөхөн олговор нь шударга, хангалттай байх бололцоог бий болгох хэрэгтэй. Түүнчлэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцах аливаа үйлдлийн хохирогчдод нөхөн олговор олгох эрх зүйн үндсийг тогтоосон хууль тогтоомж батлах нь зүйтэй” гэж зөвлөсөн юм.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт заасан зохицуулалт болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор бий болсон Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн тухай журмаар эрүүдэн шүүхийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой ч, эдийн бус хохирлыг үнэлэх, тооцох эрх зүйн зохицуулалт учир дутагдалтай, мөн олон улсын гэрээ, нийтгээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг

хэрэглэхгүй байгаагаас эрүү шүүлтийн хохирогч өөрт учирсан хохирлоо бүрэн дүүрэн, бодитой, шударгаар нөхөн төлүүлж чадахгүй байна. Улсын дээд шүүхийн 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор олон улсын гэрээ, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх зохицуулалтыг тогтоосон боловч харамсалтай нь шүүгчид практикт огт хэрэглэхгүй байна.

Хилсээр эрүүгийн хэрэгт холбогдож, эрүүдэн шүүгдсний улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр төрөөс нэхэмжлэхгүй, хохирогчид айдас, болгоомжлолтой байсан тул гарцаагүй шүүхийн практикт тогтоох шаардлагатай байв. Ийм учраас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн 17.1.1-т заасан Комиссын гишүүн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулах бүрэн эрхийн хүрээнд анх Комиссоос 6 жил 8 сар 23 хоног хоригдож, энэ хугацаанд цаазаар авах ял хилсээр 3 удаа сонсож, эцэст нь цагаадсан иргэн Ч.Э-д учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэхээр 2004 онд шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж, шүүхийн практикт тогтоож байсан юм.

Ийнхүү шүүхийн практикт тогтоосон хэдий ч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 388 дугаар зүйлд заасны дагуу хохирол нэхэмжлэх эрхтэй хүн бүр шүүхэд хандаж чадахгүй байна. Энэ нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Хэрэгсэхгүй болгох болон цагаатгах тогтоолд энэ эрхийг заадаггүй учраас хохирогч нар мэддэггүй.

2. Өөрт учирсан хохирлын хэмжээг тогтоох, нотлох нь хохирогчийн үүрэг тул нотлох баримт бүрдүүлэхэд бий болдог хүнд суртал, цаг хугацаа нөлөөлдөг.

3. Хохирлоо нэхэмжилж шүүхэд хандахаар өөрт нь холбогдох эрүүгийн хэргийг дахин сэргээх вий гэж айдаст автдаг байна.

Өнөөг хүртэл Комисс эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн 24 иргэнийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд шүүхээс нийт: 404,100,322 төгрөгийн гэм хорын хохирлыг хангаж шийдвэрлэсэн байна.

Туслалцаа

“Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашиглах явдлын хохирогчийн талаарх эрх зүйн үндсэн зарчмуудын тухай тунхаглал”-д хохирогчид хууль зүйн, эд материалын, эмнэлгийн, сэтгэл зүйн болон нийгмийн хамгааллын туслалцаа дэмжлэг авах ёстой болохыг онцолдог. Эдгээр туслалцаа дэмжлэгийг төрийн байгууллага, сайн дурын санаачилга болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн арга хэлбэрээр үзүүлэх боломжтой гэдгийг мөн тэмдэглэсэн байдаг. Хохирогчдод нэн ялангуяа эрүүл мэнд, нийгмийн хамгааллын туслалцааны талаар мэдээлэл өгч байх нь чухал. “Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах тухай” конвенцийн нэмэлт протоколд улс орнуудын төр засаг нь хохирогчдыг эд материал, сэтгэл санаа, нийгмийн хамгааллын талаас нөхөн сэргээх арга хэмжээ авах үүрэгтэй болохыг заасан байдаг. Үүнд зохистой орон байраар хангах, хууль ёсны эрхийнх нь талаар хохирогчийн өөрийнх нь сайн ойлгох хэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, эмнэлгийн болон сэтгэл зүйн, материаллаг туслалцаа үзүүлэх, ажил

хөдөлмөр, боловсрол, сургалтын бололцоо бий болгох зэрэг асуудал багтана. Түүнчлэн туслалцаа үзүүлэхдээ хохирогчийн нас, хүйс, бусад онцлог хэрэгцээг харгалзан үзэх шаардлагатай болохыг зөвлөдөг.

Гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хууль зүй, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн туслалцаа үзүүлж болно гэж заажээ. Энэ нь дээрх туслалцааг зөвхөн хамгаалалтад байгаа гэрч, хохирогч л авах боломжтой бөгөөд “туслалцаа үзүүлж болно” гэсэн нь туслалцаа үзүүлэх үүргийг бий болгоогүй байдлаар ойлгогдож байна. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т “эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасны дагуу энэ журам батлагдсан байна. Харин 18 дугаар зүйлийн 18.1.1. дэх хэсэгт заасан хууль зүйн туслалцааг ямар журмаар үзүүлэх нь тодорхойгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 346 тоот тогтоолоор батлагдсан 2016-2024 онд хэрэгжих “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 6 дугаар зүйлийн 6.1-д заасан “төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн (өмгөөллийн) туслалцаа үзүүлэх”, 6.3-т заасан “хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль зүйн туслалцаа үзүүлэх” үйл ажиллагаануудад ямар ч хөрөнгө мөнгө төсөвлөж батлаагүй байгаа нь хохирогч нэн шаардлагатай туслалцааг бодитоор авч чадах эсэхэд эргэлзээ төрүүлж байгаа юм. Хохирогчид үзүүлэх туслалцааны төрөл нь хязгаарлагдмал байгаа бөгөөд нийгмийн хамгааллын туслалцааг орхигдуулсан гэж үзэж болох юм. Хэдийгээр Гэрч,

хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд “хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийг ажилд ороход туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалт, нийгмийн бусад үйлчилгээнд хамруулах журмыг батлан мөрдүүлэх” гэж заасан байгаа ч энэ үйл ажиллагааг зөвхөн Тахарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллагад хариуцуулснаас гадна ямар ч төсөв батлаагүй байна.

Аюулгүй байдлыг хамгаалах

“Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашиглах явдлын хохирогчийн талаарх эрх зүйн үндсэн зарчмуудын тухай тунхаглал”-д зааснаар хохирогчид учирч болох таагүй нөхцөл байдлыг бууруулах, хувийн нууц буюу хувийн мэдээллийг хамгаалах, шаардлагатай тохиолдолд өөрийнх нь болон гэр бүл, түүний гэрчийг сүрдүүлэг, хонзогнолтоос сэргийлж аюулгүй байдлыг нь хамгаалах арга хэмжээг төр засаг зохион байгуулах үүрэгтэй.

Гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт аюулгүй байдлын болон сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг тусгаж зохицуулсан байдаг. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь есөн төрөлтэй байхаар хуульчилсан. Энэ арга хэмжээг зохион байгуулах ажлыг хариуцаж байсан Тахарын албыг 2016 оны 7 дугаар сарын 21-нд батлагдсан хуулиар татан буулгаж, чиг үүргийг Цагдаагийн Ерөнхий Газарт шилжүүлсэн тул хуульд заасан, журмаар зохицуулах шаардлагатай, нууцад хамаарахгүй дөрвөн төрлийн аюулгүй байдлыг хамгаалах журмыг шинэчлэн батлуулах асуудлыг Цагдаагийн Ерөнхий Газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс хариуцан ажиллаж байна. Эдгээр журмын

төслийг боловсруулахдаа Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хохирогч, гэрч, тэдний эрх, ашиг сонирхлыг төлөөлөн ажилладаг байгууллагуудыг татан оролцуулахаас гадна ялгаварлан гадуурхахгүй байх, тухайн этгээдийн онцлог байдал, хэрэгцээг харгалзан үзэх зэрэг хүний эрхийн зарчмуудыг зохицуулалтад тусгаж, гэрч, хохирогч бодитоор, хүндрэл бэрхшээлгүй байдлаар хамгаалалт авах боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

Дүгнэлт

Хохирогч эрхээ сэргээлгэх, учирсан хохирлоо арилгуулах баталгааг үр нөлөөтэй хангуулахын тулд дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна.

1. Хуульд заасан “хохирогч”-ийн тодорхойлолтыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн өөрчлөх замаар эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн этгээдийн эрхээ сэргээлгэж, хохирлоо төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох

2. Эдийн бус хохирлыг үнэлэх, тооцох аргачлалыг батлан мөрдүүлэх

3. Олон улсын гэрээ, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг хэрэглэх талаарх Улсын дээд шүүхийн холбогдох тогтоолыг шүүхийн практикт хэрэглэж хэвших

4. Зөвхөн хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хууль зүй, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн туслалцаа үзүүлж болохоор заасан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлж, хохирогчоор тогтоогдсон бүх хүмүүст туслалцаа авах боломжийг бий болгох

5. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хууль зүйн туслалцааг хохирогчид үзүүлэх журмыг батлан хэрэгжүүлэх

6. Хохирогчийн онцлогоос шалтгаалан хууль зүй, сэтгэл зүй, эрүүл мэндийн туслалцааны цогц үйлчилгээ үзүүлдэг олон улсын жишиг загварыг нэвтрүүлэх асуудлыг судалж, практикт хэрэглэх; шаардлагатай хөрөнгийг төсөвт тусган хуваарилах.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СОНГУУЛИЙН ЭРХ БҮХИЙ ИРГЭНИЙ СОНГОХ ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ



Хүний эрхийн Үндэсний Комиссын
Ахлах референт

3.ӨНӨРЖАРГАЛ

Ард түмний хүсэл зориг нь төрийн бүх эрх мэдлийн үндэс бөгөөд энэхүү хүсэл зориг нь шударга, тогтмол явагддаг сонгуулиар илэрлээ олдог билээ.

Төрийн эрх мэдэл нь ард түмнээс эх үндэстэй төрийн удирдлагын хэлбэр бөгөөд орчин үеийн бүгд найрамдах улсын төрийн хэлбэр нь Үндсэн хуульт ёс, хүний эрх, эрх чөлөөний суурь эрх хэмжээг хэрэгжүүлэх, төрийн эрх мэдлийг хуваарилахыг гол зорилго болгодог. Хүний эрх, эрх чөлөөний суурь зарчмыг хүлээн зөвшөөрч, хууль зүйн хамгаалалтыг ард түмний хүсэл зориг, эрх зүйт хуульд тулгуурлан бүрдүүлсэн, хууль бус албадлагаас татгалзсан төрийн дэглэмийг¹ ардчилсан төрийн дэглэм гэнэ.

Эрх зүйт Үндсэн хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөний орчин (иргэний нийгэм) нээлттэй хамгаалалттай байх, шудрага, тэгш, чөлөөтэй, шууд сонгуулийн тогтолцоо бүрдсэн байх, олон ургальч үзэл бодол

хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүний эрх, эрх чөлөөний суурь зарчим, хэм хэмжээгээр төрийн эрх мэдлийг хязгаарласан байх, хууль шудрага ёсонд үйлчилдэг бие даасан хараат бус шүүхийг тогтоосон байх зэрэг нь ардчилсан дэглэмийн үндсэн шинж юм.²

Хүн бүр өөрийн улс орны нийгмийн амьдрал, төрийн үйл хэрэгт оролцох эрхтэй бөгөөд ийм боломжоор хангагдах ёстой. Энэ эрхээ шууд буюу бүх нийтийн сонгууль, санал асуулгад оролцох, сонгуульд өрсөлдөх замаар хэрэгжүүлэх, эсвэл чөлөөтэй сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулж эдэлдэг. Иймээс сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд иргэд сонгох буюу сонгогдох эрхтэй хэмээн ойлгоно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэн харьцаж, бусдын адил, тэгш эрх эдлэх боломж нь хүний эрхийн зарчим юм. Энэ зарчмын үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

¹ Төрөөс эрх мэдлээ хэрэгжүүлэх эрх зүйн дэг журмын арга, механизм, түүний шинж чанарыг төрийн дэглэм гэнэ. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх аргын шинж чанараар нь дэглэмийг ардчилсан, ардчилсан бус гэж ангилна. (Төрийн онол, Н.Лүндэндорж, УБ, 2008 он)

² Төрийн онол, Н.Лүндэндорж, УБ, 2008 он

улс төр, нийгмийн амьдралд идэвхтэй оролцсоноор тэд өөрсдийн эрх ашгаа хамгаалах төдийгүй улс орны хөгжил, нийгмийн байгууламж, үнэт зүйлсийг тодорхойлоход өөрийн биеэр шууд, эсвэл чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан хувь нэмрээ оруулдаг билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн эрх бүхий иргэн нь ямар нэгэн ялгаварлан гадурхалтгүйгээр, аливаа дарамт шахалт, айдас сүрдүүлгээс ангид байж, хууль бус нөлөөлөлгүйгээр хуульд заасан арга хэлбэрээр хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх, саналаа нууцаар гаргах боломжийг хангасан сонгуульд оролцох эрхтэй болно.

Эрх зүйн ойлголтод сонгууль гэдэг нь 2 буюу түүнээс дээш нэр дэвшигч этгээд тухайн мандатын (суудал, эрх) төлөө өрсөлдөж байгаа нөхцөлд санал хураалт явуулах замаар төрийн байгууллагуудыг байгуулах буюу түүний албан тушаалтнуудын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх процедур юм. Иймд сонгууль нь төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг санал хураалтын тусламжтайгаар бүрдүүлэх арга юм.³

Иймээс сонгуулийн эрх бүхий иргэн нь төрийн сонгуульд байгууллага ба нутгийн өөрөө удирдах байгууллагыг бүрдүүлэх, мөн ард нийтийн санал асуулгад оролцохыг сонгох эрх, төрийн сонгуульд байгууллага ба нутгийн өөрийн удирдлагын байгууллага, түүнчлэн төрийн сонгуульд ба нутгийн өөрийн удирдлагын албан тушаалд нэр дэвшин сонгогдохыг сонгогдох эрх гэж ойлгоно. Сонгох, сонгогдох эрхийг ерөнхийд нь сонгуулийн эрх гэж тодорхойлдог ба энэхүү эрх нь иргэний улс төрийн эрхийн бүлэгт хамаардаг болно.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээ буюу Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал болон

³ Эрх зүйн эх толь бичиг, С.Нарангэрэл, УБ, 2011 он

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад⁴дэлхий нийтээрээ сонгох эрхийг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл бол бүх нийтийн сонгууль гэдгийг хүлээн зөвшөөрч, хүн бүрийн төрийн хэргийг явуулахад оролцох, сонгох, сонгогдох, төрийн алба хаших эрхтэй болохыг баталгаажуулсан байдаг. Мөн тухайн улс ямар Үндсэн хууль засаглалтайгаас үл хамааран иргэддээ эдгээр эрхийг эдлэх эрхийг бүрдүүлэх зорилгоор шаардлагатай хууль тогтоох болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын⁵ 21 дүгээр зүйлд “Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй”; “Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй”; “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахууц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус

⁴ Хүний эрхийн суурь баримт бичгүүд:

- Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал (1948)
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт Протокол (1966)
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II Протокол (1989)
- Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966)

Эдгээр хүний эрхийн суурь баримт бичгүүдэд хүн төрөлхтөнд хамааралтай, хүний эрх, эрх чөлөөний асуудлаарх нийтлэг, түгээмэл хэм хэмжээг тогтоож өгсөн учир “Хүний эрхийн билл” хэмээн нэрлэдэг.

⁵ НҮБ-ын Дүрмийн 68 дугаар зүйлд “Эдийн засаг, нийгмийн зөвлөл эдийн засаг, нийгмийн салбарын болон хүний эрхийг сахиулах асуудал эрхлэх комиссууд түүнчлэн чиг үүргээ биелүүлэхэд шаардагдах бусад комиссыг байгуулна” гэж заасны дагуу 1945 онд Женевт хуралдсан НҮБ-ын бага хурлаараа Эдийн засаг, нийгмийн зөвлөлд хэд хэдэн тодорхой салбарт ажлын хэсэг байгуулах үүрэг өгчээ. Үүнтэй уялдаж Эдийн засаг, нийгмийн зөвлөл нь 1946 оны анхдугаар хурлаараа НҮБ-ын Хүний эрхийн Комиссыг байгуулсан байна. Тус Комиссын анхдагч гол үүрэг нь Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын төслийг боловсруулах явдал байв. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал нь санал, зөвлөмжийн шинжтэй байсан ч хүний эрхийг хамгаалах тогтолцооны үүсэл хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж, хүний эрхийг хамгаалах тогтолцоо бүрэлдэх үндэс суурь баримт бичиг болсон билээ.

сонгуулиар илрэлээ олно” хэмээн тус тус заасан байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын⁶ 25 дугаар зүйлд “Төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй”; “Сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрхтэй”; “Тэгш эрхийн ерөнхий нөхцөлтөйгөөр улсаа төрийн алба хаших”; хэмээн тус тус заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, хэм хэмжээ ба олон улсын гэрээ нь манай улсын эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг юм. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд “Үндсэн хуульд харшлахгүй олон улсын гэрээг Монгол Улс үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөнө, түүнчлэн дотоодын хууль тогтоомжийн зүйл заалт Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй зөрчилдвөл олон улсын гэрээний заалтыг баримтална” гэж заасан байдаг. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ нь сонгуулийн тухай холбогдох заалтаараа сонгуулийн эрх зүйн эх сурвалж болдог учир сонгуультай холбогдолтой олон улсын гэрээний заалтыг Монгол Улсын Үндсэн хуульд харшлахааргүй бол дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил баримтлана.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь нийгмийн харилцаанд оролцоход жирийн хүмүүсээс илүү нэмэлт нөхцөл, тусгай хэрэгцээ шаарддаг учраас үүнийг хэдий хэмжээгээр бүрдүүлнэ төдий хэмжээгээр тэд нийгмийн харилцаанд бусдын адил мөр

зэрэгцэн оролцох боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс төрийн халамж, дэмжлэгийг хүртээд гэр бүл, найз нөхөд, хэн нэгнээр тэжээлгэн гэртээ суухаасаа илүү сурч боловсрон, мэргэжил эзэмших, ажил хөдөлмөр эрхлэх, улс төр нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, өөрийгөө хөгжүүлэх чин хүсэлтэй байдаг. Энэхүү нэмэлт нөхцөл, хэрэгцээ шаардлагын үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, эрх чөлөөг баталгаажуулах зорилгоор НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протоколыг батлан гаргажээ.

Монгол Улс 2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг соёрхон баталсан билээ. Тус конвенцийн 29 дүгээр зүйлд заасны дагуу оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн эрхийг баталгаажуулж, эдгээр эрхээ бусдын нэгэн адил эдлэх боломжийг бий болгох үүднээс тодорхой үүрэг хүлээдэг.

Тухайлбал, тус конвенцид зааснаар бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрх, боломжийг оролцуулан шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулан улс төр, нийгмийн амьдралд үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох байдлыг дараах хэлбэрээр хангах ёстой байна. Үүнд:

- ◆ сонгууль өгөх журам, байр, сонгуулийн хуудас нь ашиглахад зохистой, хүртгэмжтэй болон ойлгох, ашиглахад хялбар байх явдлыг хангах;
- ◆ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгууль болон ард нийтийн санал асуулгад ямар нэг сүрдүүлэггүйгээр саналаа нууцаар өгөх, сонгуульд нэрээ дэвшүүлэх,

⁶ Монгол Улс 1968.01.05-ны өдөр гарын үсэг зурж, 1974.11.18-ны өдөр соёрхон баталсан.

болон шаардлагатай тохиолдолд туслах болон шинэ технологи ашиглах замаар албан тушаал хаших, төр, засгийн байгууллагын аль ч түвшинд төрийн алба хаах эрхийг дэмжиж хамгаалах;

- ◆ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгогчийн хувьд өөрийн санал, бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үүний тулд шаардлагатай тохиолдолд тэдгээр хүмүүсийн хүсэлтээр сонгосон хүний туслалцаатайгаар саналаа өгөх зэрэг болно.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусадтай адил тэгш байх үндсэн дээр ямар нэг ялгаварлан гадуурхалтгүйгээр төрийн удирдах хэрэгт бүрэн дүүрэн, үр нөлөөтэй оролцох орчин бүрдүүлэх явдлыг идэвхтэйгээр хөхиүлэн дэмжиж, тэдний нийгмийн үйл хэрэгт оролцох оролцоог тус конвенцид оролцогч улсууд дэмжих үүрэгтэй байна.

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 1996 оны 57 дугаар чуулганаар баталсан 25 дугаар ерөнхий зөвлөмжид тайлбарласнаар “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад сонгуулийн ямар тогтолцоотой байх тухай заагаагүй боловч оролцогч улсад хэрэгжиж байгаа аливаа сонгуулийн тогтолцоо нь сонгох, сонгогдох эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцсэн байх бөгөөд сонгогчид хүслээ чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулж, ямар нэгэн бүлгийг ялгаварлан гадуурхах, иргэдийн сонгуульд чөлөөтэй оролцох эрхийг үндэслэлгүй хязгаарлах ёсгүй” гэжээ.

Манай улс ардчилал, зах зээлийн нийгэмд шилжин, 1992 онд баталсан Үндсэн хууль нь төрийн эрх мэдлийг хуваарилах, хүний эрх, эрх чөлөөг хангах, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн харилцааны тулгуур үндсийг бүрдүүлэх, нутгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хууль дээдлэх ёсыг

хэрэгжүүлэх хяналтыг тогтоосон гол хууль юм.

Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх заалтад “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно” хэмээн тус тус заажээ.

Үүнээс үзэхэд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх нь шууд ардчилал⁷, төлөөллийн ардчилал⁸-гэсэн ардчиллын үндсэн хоёр хэлбэрээр хэрэгжиж, сонгох эрхийг 18 наснаас, сонгогдох эрхийг хуульд заасан шаардлагын дагуу эдлэхээр байна.

Мөн манай улсад сонгуультай холбоотой дараах хуулиуд хэрэгжиж байна. Үүнд:

⁷ **Шууд ардчилал:** улс төрийн чухал шийдвэр гаргах, засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд ард түмэн ямарваа нэгэн төлөөлөлгүйгээр оролцох бололцоог хангахад чиглэх бөгөөд энэ утгаараа ардчилсан нийгэмд ард түмний хүсэл зориг нь төрийн эрх мэдэл гэсэн ойлголттой нэг утга санааг агуулна. Шууд ардчилал нь ард түмэн улс орны хэмжээний асуудлыг шийдвэрлэхэд төлөөлөгчийн байгууллагуудаараа уламжлах бус бүх ард түмний санал хураалт, хууль санаачлах эрхийг иргэнд олгох зэргийг хамруулсан ойлголт юм. Шууд ардчилал нь бүх нийтийн сонгууль, санал асуулгын хэлбэрээр хэрэгждэг. Иймээс чухал хууль эрх зүйн акт, стратегийн шинж чанартай улс төрийн шийдвэр гаргах, орон нутгийн хэмжээний асуудлыг шийдвэрлэх зэрэг асуудалтай холбоотой байдаг.

⁸ **Төлөөллийн ардчилал:** ард түмэн сонгож байгуулсан төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх, энэ зорилгоор сонгуульд оролцох, өөрсдийн төлөөлөгчдийг томилох үйл явцаар илэрхийлэгдэнэ. Ард түмэн түүнээс сонгогдсон төлөөлөгчдийн харилцаа нь харилцан итгэлцэл, төр засгийн байгууллагын эрх мэдлийг Үндсэн хуулийн замаар хязгаарлах, сонгогчдын зүгээс тэдний үйл ажиллагаанд тавих хяналт зэрэг хүчин зүйлүүдэд тулгуурладаг. Иймээс төлөөллийн ардчилал нь сонгосон байгууллагаар нь дамжин хэрэгждэг учир төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны бүхий л түвшинд хэрэгжинэ. (Сонгуулийн тухай зарим ойлголт, товч тайлбар, Ж.Ядамсүрэн, УБ, 2008 он, Эрх зүйн эх толь бичиг, С.Нарангэрэл УБ, 2011 он)

- Монгол Улсын Үндсэн хууль (1992)
- Ард нийтийн санал асуулгын тухай хууль (2016)
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (2006)
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль (2011)
- Сонгуулийн тухай хууль (2015)

Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн сонгох, сонгогдох эрхээ эдлэх наад захын баталгаа, орчны хүртээмж, тусгай хэрэгцээ, нэмэлт нөхцөлийг бүрдүүлэх, тэдний сонгуулийн боловсролыг дээшлүүлэх замаар улс төр, нийгмийн амьдралд оролцох идэвх оролцоог нэмэгдүүлснээр тэд хуульд заасан эрх, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх боломжтой юм.

Гэвч хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн сонгуульд оролцох идэвх, оролцоо сул, сонгуультай холбоотой хууль эрх зүйн мэдлэг дутмаг, санал авах байрны орчны хүртээмжгүй байдал зэргээс шалтгаалан зарим тохиолдолд сонгуульд бүрэн дүүрэн оролцох боломжоор хязгаарлагддаг байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг баталгаажуулан, санал авах байрыг тэдэнд нийцтэй, хүртээмжтэй байдлаар зохион байгуулах, сонгуульд бүрэн дүүрэн оролцох боломжоор хангах, шинээр батлагдсан Сонгуулийн тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулж, тэдний сонгуулийн боловсролыг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай билээ.

2015 онд УИХ-аас Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай (2011), Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай (2012), Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай (2012), Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай (2012) хуулиудыг хүчингүй болгож, Сонгуулийн тухай хуулийг баглан

хэрэгжүүлж байна. Тус хуульд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн эрхийг хангаж, хамгаалах чиглэлээр дараах зохицуулалтыг тусгасан байна. Тухайлбал, Сонгуулийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.4-т “Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд нэг байна”, мөн зүйлийн 87.5-д “Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчдын тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна”, мөн зүйлийн 87.6-д “Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна” гэж тус тус заасан байна.

Мөн 2016 онд УИХ-аас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна” гэж заажээ. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн эрх бүхий иргэний сонгох эрхийг хангаж хамгаалсан хуулийн заалт сонгуулийн зохион байгуулах явцад төдийлөн тогтвортой хангагдаж хэрэгжихгүй байна.

Тухайлбал, 2011 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8-д “... санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна” гэж заасан нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн эрхийг баталгаажуулсан шинэ зохицуулалт болсон юм. 2012 оны УИХ болон НИТХ-ын сонгуулиар санал өгөх байранд тэргэнцэртэй

иргэд зорчих налуу зам, зориулалтын бүхээгтэй байсан бол нэг жилийн дараа буюу 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар тэргэнцэртэй иргэд санал өгөх боломжоор хязгаарлагдаж байжээ. Харин 2012 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6-д “Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд нэг байна” гэсэн заалт нь харааны бэрхшээлтэй сонгогч сонгох эрхээ бусдын адил бие даан хэрэгжүүлэн оролцох боломжийг бий болгосон байна.⁹

2012 оны УИХ болон НИТХ-ын сонгуулийн үеэр сонгуулийн санал авах байрны дэд бүтцийн хүртээмжтэй байдлыг хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод тохиромжтой байдлаар зохион байгуулахад нөлөөлөл үзүүлэх, тэдний сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын сонгуулийн үйл ажиллагаанд хяналт тавих чадавхийг нэмэгдүүлэх зорилго бүхий богино хугацааны төслийг Мерси Кор Монгол Олон улсын байгууллага болон АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн дэмжлэгтэйгээр Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллагууд хэрэгжүүлсэн болно.

Сонгуулийн өмнө санал авах байрны хүртээмжийн байдалд 2 үе шаттай үнэлгээг хийж, эхний үнэлгээг аймаг, нийслэлийн

⁹ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR)-ийн 22 дугаар хуралдаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилтийн байдлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудаас бэлтгэсэн мэдээлэл, 2014 он

50 санал авах байранд хийхэд санал авах байруудын 37 хувь нь хоёр болон түүнээс дээш давхарт, 10 хувь нь подвальд, 38 хувь нь засварын байдалтай, 15 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод нийцтэй, хүртээмжтэй байдлаар засварлан тохижуулагдсан байжээ. Хоёр дахь үнэлгээг аймаг, нийслэлийн 94 санал авах байруудад хийхэд 60 хувь нь хүртээмжтэй, 28 хувь хоёр болон түүнээс дээш давхарт, 15 хувь нь стандартын бус, 8 хувь подвальд байрласан байжээ.¹⁰

2016 оны УИХ, Аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуультай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй сонгогч саналаа өгөх боломж, орчны хүртээмжийн байдалтай Нийслэлийн зарим дүүргийн 20 санал авах байртай танилцахад санал авах байруудын дийлэнх нь тухайн байгууламжийн 2, 3 дугаар давхар, эсвэл хонгилын давхарт байрлаж байв. Үүнээс үүдэн хөдөлгөөний бэрхшээлтэй буюу тэргэнцэртэй иргэн ганцаараа бусдын ямар нэгэн оролцоо, дэмжлэггүйгээр саналаа өгөх нөхцөл боломжоор хангагдаагүй байна. Ихэнх санал авах байруудын үүдний шат нь налуу замтай боловч тэр нь тэргэнцэртэй хүн гарах боломжгүй хэт өгсүүр, эсхүл хоёр талдаа бариулгүй, гялгар плитагаар хийгдсэн учраас халтирч гулгаад өгсөх боломжгүй байв. Гадна талын налуу замаар бие даан орсон ч давхар хоорондын шатнуудад налуу зам байхгүйгээс үүдсэн бэрхшээлүүд үүсэхээр байлаа.

Мөн ерөнхий боловсролын сургуулийн урлагийн танхимд байрласан зарим санал өгөх байрны гарах хаалга нь урлагийн танхимын тайзны хэсэгт байрласан нь тэргэнцэртэй иргэн бие даан өгсөж гарах боломжгүй, хэт нарийн, огцом өндөр шаттай зэрэг нөхцөл байдал ажиглагдсан

¹⁰ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн боловсролыг нэмэгдүүлэх замаар оролцоог нэмэгдүүлэх нь төслийн хэрэгжилтийн тайлан, 2012 он

байна. Санал авах байруудын дотоод зохион байгуулалт нь сонгогчдод ойлгомжгүй, ялангуяа сонсголын бэрхшээлтэй сонгогч, тэргэнцэртэй сонгогчдод үйлчилнэ гэсэн тэмдэг, тэмдэглэгээгээр тоноглогдоогүй байна. Зарим санал авах байр хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод зориулсан тусгайлсан санал авах бүхээггүй, тус бүхээгийг байршуулах орчин, зай талбай дутмаг байлаа.¹¹

Санал авах байрыг хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод нийцтэй, хүртээмжтэй зохион байгуулахад дараах асуудлуудад анхаарах шаардлагатай байдаг. Үүнд:

- сонсголын бэрхшээлтэй сонгогч санал авах байранд хүрэлцэн ирэхэд тэдэнд үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээг байршуулах, дохионы хэлээр дохиж чиглүүлэх, сонгууль өгөх явцыг тайлбарласан материалыг дохионы хэлмэрч, орчуулагчаар дохиж хөрвүүлэн дүрст хэлбэрээр гаргаж, тараах;
- хөдөлгөөний бэрхшээлтэй буюу тэргэнцэртэй сонгогч санал авах байранд саадгүй зорчих нөхцөлийг хангасан зөөврийн налуу зам байрлуулах, хаалганы далайц, хаалганы өргөн, бариул болон шат, шатны гишгүүр, бариул, хажуу захын хаалт, хашлага зэргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны хүртээмж, стандартын дагуу бэлтгэх;
- харааны бэрхшээлтэй хүмүүст бүрэн хараагүй болон сул хараатай иргэд хамаарах бөгөөд харааны бэрхшээлтэй сонгогчийн сонгуулийн боловсролд нь дэмжлэг болгож мэдээллийн

хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр брайль болон томруулсан хэлбэрээр хэвлэн түгээх зэрэг болно.

Төрөөс хүний эрхийг хангаж, хамгаалах үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн үйлчилгээг хүн бүрт нийцтэй, бодитой, хүртээмжтэй, чанартай хүргэх гэсэн үндсэн зарчмуудыг баримталдаг. Иймд хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн эрх бүхий иргэний эрхийг бодитой болгохын тулд санал авах байрны дэд бүтэц, орчны хүртээмжийг хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн эрх бүхий иргэн бүрт нийцтэй байх явдлыг хангах, ялангуяа тэд бусдын дэмжлэг туслалцаагүйгээр өөрсдийн биеэр сонгуульд оролцох, гадны нөлөөгүй, өөрийн дотоод итгэл, үнэмшлээр саналаа чөлөөтэй, нууцаар гаргах боломжийг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай юм.

Сонгууль бүх нийтийн байх үндсэн зарчмыг хангахад зөвхөн сонгуулийн төв байгууллага болон аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод дангаар хариуцах бус харин хуулиар чиг үүрэг хүлээсэн бусад холбогдох төрийн байгууллагуудын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн сонгуулийн зохион байгуулалт менежментийг уялдуулан зохион байгуулах, мөн түүнчлэн сонгуулийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэдэд энгийн, ойлгомжтой байх, шудрага сонгуулийг зохион байгуулахад иргэний нийгмийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, зорилтот бүлгийн сонгогчдын боловсролд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудыг чадавхижуулах замаар төр болон иргэний нийгмийн байгууллагууд хамтран хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой билээ.

¹¹ Сонгуулийн санал авах байруудтай танилцсан илтгэх хуудас, Хүний эрхийн Үндэсний Комисс, 2016 он

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

БОЛОВСРОЛ 2030: ИНЧОНЫ ТУНХАГЛАЛ

*Тэгш хамарсан, тэгш боломжийг баталгаажуулсан чанартай боловсрол,
бүх нийтийн насан туршийн суралцахуйн төлөө*



НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (НҮББСШУБ) нь НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн банк, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагуудтай хамтран Дэлхийн боловсролын чуулга уулзалтыг БНСУ-ын Инчон хотноо 2015 оны тавдугаар сард зохион байгуулж, ирэх арван таван жилийн хугацаанд боловсролын талаарх алсын харааг тодорхойлсон “Боловсрол 2030” Инчоны тунхаглалыг баталсан байна.

Боловсролын талаарх Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ), 2000 оноос хойш Бүх нийтийн боловсролын зорилтуудыг хангах талаар гарсан ахиц дэвшил, авсан сургамж, тулгарч буй сорилтуудыг нягтлан хэлэлцэж, Боловсрол 2030 хөтөлбөр болон Үйл ажиллагааны

хүрээ, түүнийг хэрэгжүүлэх цаашдын тэргүүлэх чиглэл, стратегийн талаар энэхүү тунхаглалыг баталжээ.

2030 он хүртэлх Боловсролын талаарх алсын хараа

1. Дэлхий дахинаа Бүх нийтийн боловсролын 6 зорилго, Мянганы хөгжлийн зорилтуудыг баталсан 2000 оноос хойш боловсролын хувьд нэн чухал ахиц дэвшил гаргаад байна. 2015 он буюу тухайн зорилтуудыг дүгнэн хэлэлцэх хугацаа болж буй хэдий ч эдгээр бүрэн биелээгүй зорилтыг хангахын тулд цаашид үргэлжлүүлэн ажиллах шаардлагатай.

Өнөөгийн ертөнцийг өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн¹ Тэгш хамарсан, тэгш боломжийг баталгаажуулсан чанартай боловсрол, бүх нийтийн насан туршийн суралцахуйг хангах (цаашид *Боловсрол 2030 гэх*) хэмээх **Зорилт 4**, түүнд нийцүүлэн боловсруулсан үзүүлэлтүүд нь 2015 - 2030 оны хооронд боловсролын талаар бүх нийтэд хамааралтай алсыг харсан зорилгыг дэвшүүлээд байна. Иймд энэ цаг хугацаанд бидний хүчин чармайлт бүр дээрх зорилго, үзүүлэлт бүрийг ханган баталгаажуулахад чиглэх ёстой.

Боловсрол нь Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030-ийн гол цөм бөгөөд бусад Тогтвортой хөгжлийн зорилтууд амжилттай хэрэгжих үндсэн нөхцөл болно. Тогтвортой

¹ НҮБ. 2015. “Өнөөгийн ертөнцийг өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030” <https://sustainabledevelopment.un.org/post2015/transformingourworld>.

хөгжлийн хөтөлбөр 2030-д боловсролын гүйцэтгэх үүргийг чухалчлан үзэж, бие даасан Тогтвортой хөгжлийн зорилт 4 болон Тогтвортой хөгжлийн бусад зорилтуудыг боловсролын холбогдох шалгуур үзүүлэлтээр тодорхойлон үзжээ. Үүнд эрүүл мэнд, өсөлт ба ажил эрхлэлт, зохистой хэрэглээ ба үйлдвэрлэл, уур амьсгалын өөрчлөлт зэрэг зорилтууд орно. Боловсрол нь бүх Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ололт амжилт, ахиц дэвшлийг хурдасгах тул тэдгээрийг хэрэгжүүлэх стратегийн бүрэлдэхүүн хэсэг байх ёстой. Зорилт 4-д шинэчлэн тодорхойлсон боловсролын зорилт нь хэнийг ч ардаа орхилгүйгээр хувь хүн, хамт олон, нийгмийн амьдралыг өөрчлөн сайжруулах алсын хараа бүхий иж бүрэн, түгээмэл, хэтийн баримжаа бүхий зорилт юм. Уг хөтөлбөр нь өнөө болон ирээдүйн олон улсын болон үндэсний түвшний боловсролын сорилтуудыг үр дүнтэй шийдвэрлэхийн хамт Бүх нийтийн боловсролын болон Мянганы хөгжлийн зорилтуудын “дуусаагүй ажил хэрэг”-ийг гүйцээн хэрэгжүүлэх болно. Энэ нь хүний эрх, эрхэм чанар, нийгмийн зүй ёс, энх тайван, тэгш хамралт, хамгаалал, хэл, соёлын болоод угсаатны ялгаатай байдал, үүрэг хариуцлагаа хамтран хэрэгжүүлэх зэрэг зарчмуудад тулгуурлан боловсрол хийгээд хөгжлийг хүмүүнлэгийн үүднээс авч үзсэн, хүний эрхэд суурилсан хандлага байна.²

Бүх нийтийн боловсролын төлөөх хөдөлгөөнд суурилан, түүнийг үргэлжлүүлж буйн хувьд Боловсрол 2030 хөтөлбөр нь 2000 оноос хойшх сургамжийг анхааралдаа авах шаардлагатай. Боловсрол 2030 хөтөлбөрийн хувьд насан турш

² НҮББСШУБ. 2015. *Боловсролын талаар дахин эргэцүүлэхүй: Нийтлэг сайн сайхны төлөө?* [http://unesdoc.unesco.org/ima-
es/0023/002325/232555e.pdf](http://unesdoc.unesco.org/images/0023/002325/232555e.pdf).

суралцах хандлагын дагуу бүх түвшин дэх боловсролын чанар, үр дүн хийгээд тэгш байдал, тэгш хамралт, хүртгээмжийг илүү нэмэгдүүлэхэд чиглэж буйд шинэлэг тал нь оршино. Өнгөрсөн хугацаанд авсан гол сургамж бол Бүх нийтийн боловсролын зорилтууд ба боловсролын талаарх Мянганы хөгжлийн зорилтууд тус тусдаа бус харин олон улсын хөгжлийн хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн хариу арга хэмжээ бүхий дэлхий нийтийн боловсролын нэгдмэл хөтөлбөр байх явдал юм. Инчоны тунхаглалыг баталснаар боловсролын хамтын нийгэмлэг нь хөгжлийн нийтлэг чиг шугамд нийцсэн, шинэчлэгдсэн хөтөлбөртэй болж буй хэрэг юм. Боловсролын хөтөлбөрийн шинэ зорилго нь тэгш хамралт, тэгш байдалд төвлөрсөн бөгөөд хүн бүрт тэгш боломж олгохын хамт хэнийг ч ардаа үлдээхгүй байх явдал юм. Энэ нь мөн эмзэг буюу тусгаарлагдсан нөхцөлд буй хүмүүст хүрч үйлчлэх хүчин чармайлтыг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн сургамжийг бидэнд өгч байна. Нас хүйс, арьс өнгө, үндэс угсаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэстний ба нийгмийн гарал, өмч зэргээс үл хамааран хүн бүр, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, цагаач ажилчид, уугуул хүмүүс, хүүхэд залуучууд гэх мэт эмзэг байдалд буюу өөр статус³ бүхий хүмүүс бүгд тэгш хамруулсан, шударга, чанартай боловсрол эзэмших, насан туршдаа сурч боловсрох боломжтой байх ёстой. Боловсролын чанар, суралцахуй, чадварт голчлон анхаарах нь суралцагчид сургуульдаа шаардлагатай

³ Цаашид “эмзэг бүлгийн болон тусгаарлагдсан” гэх ойлголт нь энэ жагсаалтад орсон бүх бүлгийг хамааруулах болно. Энэхүү жагсаалт нь “Өнөөгийн ертөнцийг өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030”-ийн 19 болон 25 дахь зүйлийг хослуулсан хэдий ч бүрэн төгс биш болохыг тэмдэглэх нь зүйтэй. Ялангуяа улс орон, бүс нутгууд өөр төрлийн статуст үндэслэн боловсрол дахь гадуурхал, ялгаварлал, тусгаарлалт болон эмзэг байдлыг тодорхойлон хэрэглэж болно.

мэдлэг, чадвар эзэмшиж буй эсэхэд хангалттай анхаарал тавихгүйгээр зөвхөн боловсролын хүртээмжид төвлөрөхийн сөрөг талыг тодруулан гаргасан бас нэг сургамж билээ. Нөгөө талаас Бүх нийтийн боловсролын зорилтууд хараахан биелээгүй байгаа нь чанартай боловсролыг хүн бүрт хүргэж чадаагүй “өмнөхийн адил хандлага” буюу дараагийн сургамжийг бидэнд өгч байна. Хэрвээ ахиц дэвшлийн өнөөгийн хурдцаар жишиж үзвэл олон орнууд 2030 он гэхэд шинэ зорилтуудыг ханган биелүүлэх боломжгүй хэвээр байна. Энэ нь бидний одоогийн хандлагыг өөрчлөх, хүчин чармайлт, нөөцийг өмнө байгаагүй практикийн үндсэн дээр дайчлан төвлөрүүлэх нь нэн чухал болохыг харуулж байна. Боловсрол 2030 хөтөлбөрийн дараагийн нэгэн шинэлэг тал нь хөгжингүй хийгээд хөгжиж буй улс орнуудад адилхан буюу бүх дэлхий нийтэд түгээмэл байх явдал юм.

Боловсрол 2030 хөтөлбөрийг өнөөгийн хөгжлийн өргөн цар хүрээнд авч үзэх ёстой. Боловсролын тогтолцоо нь хурдацтай өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээл, технологийн дэвшлүүд, хотжилт, шилжилт хөдөлгөөн, улс төрийн тогтворгүй байдал, байгаль орчны доройтол, байгалийн гамшиг, аюулт үзэгдлүүд, нөөц баялгийн төлөөх өрсөлдөөн, хүн ам зүйн өмнө тулгарч буй сорилтууд, эзлэх хувь нь нэмэгдсээр буй дэлхий нийтийн ажилгүйдэл, үргэлжлэн буй ядуурал, өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал, энх тайван, аюулгүй байдалд учрах аюул занал нэмэгдсэн зэрэг асуудалд зохих ёсоор хариу өгөх, эсхүл түүнд нийцэн тохирч байх ёстой. 2030 он гэхэд боловсролын тогтолцоо нь суурь боловсролд (сургуулийн өмнөх, бага болон дунд боловсрол)⁴ олон зуун сая хүүхэд,

өсвөр үеийнхнийг хамруулах, үүний зэрэгцээгээр бүрэн дунд болон түүний дараах шатны боловсролыг бүх нийтэд тэгш хүртээмжтэй болох ёстой. Мөн урт хугацаанд хүүхдийн суралцах, хөгжих үйл явц, эрүүл мэндийг хангахуйц сургуулийн өмнөх боловсрол, халамж асаргааг хангах нь нэн чухалд тооцогдож байна. Бүх хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучууд бичиг үсэгт тайлагдах болон өөрт шаардлагатай чадварыг эзэмшихэд боловсролын тогтолцоо анхаарлаа хандуулах ёстой. Өөрөөр хэлбэл хүүхэд, өсвөр үе, залуучуудад мэдлэгт суурилсан, технологийн баримжаа бүхий тогтвортой, аюулгүй, харилцан хамааралтай дэлхий ертөнцөд ажиллаж, амьдрахад шаардлагатай, өөрчлөгдөн хөгжиж байдаг уян хатан чадвар, чадамжийг амьдралынх нь туршид эзэмшүүлэх нь хамгийн чухал юм. Боловсрол 2030 хөтөлбөр нь хүн бүр мэдлэгийн бат суурьтай, бүтээлч шүүмжлэлт сэтгэхүйтэй, хамтран ажиллах чадвартай, итгэлтэй, урам зоригтой, суралцахын төлөө хүсэл тэмүүлэлтэй болон төлөвшихийг дэмжинэ.

Боловсрол 2030 хөтөлбөрийн дараагийн нэгэн онцлог нь хүний хөгжил болон эдийн засгийн, нийгмийн, хүрээлэн буй орчны тогтвортой байдалд боловсролын үүрэг, холбогдох байдлыг өөрөөр авч үзэх явдал юм. Энэ нь хөгжлийн шинэ загварт хувь нэмэр оруулж буй түүний олон талт бөгөөд хүмүүнлэг агуулгыг тодруулж байна. Энэхүү алсын хараа нь боловсролын талаарх утилитар хандлагаас даван гарч хүний оршихуйн олон талт байр суурийг нэгтгэн авч үздэг. (хуудас 10)⁵ Энэ нь боловсрол ардчилал, хүний эрхийг хөхиүлэн дэмжих, дэлхийн иргэншил, хүлцэнгүй чанар, иргэний оролцоо болон тогтвортой

хөрөнгө оруулалтын жишээ., www.unicef.org/publications/files/Investment_Case_for_Education_and_Equity_FINAL.pdf.

⁴ НУБ-ын Хүүхдийн сан. 2015 он, Боловсрол, тэгш боломжийн

⁵ НУББСШУБ. 2015. *Боловсролын талаар дахин эргэцүүлэхүй: Хууд.10.*

хөгжил зэргийг тэгш хамруулахын адил нэн чухал гэж үздэг. Боловсрол нь соёл хоорондын харилцан яриаг хөхиүлэн дэмжиж, соёлын, шашны, хэлний ялгаатай байдлыг хүндэтгэхийг дэмжсэнээр нийгмийн харилцан шүтэлцээ, шударга ёсыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хүн бүхэнд чанартай боловсрол олгохын төлөө ажиллаж буй улс орон, нийгмийн бүлгүүдийн хувьд гарах үр дүн нь харьцангуй их юм. Хүмүүсийн амьдралыг ялангуяа охид, эмэгтэйчүүдийн амьдралыг сайжруулахад боловсролын тэгш бус байдал үргэлжлэн хуримтлагдсаар байна⁶. Боловсрол нь ядуурлыг бууруулах үндсэн түлхүүр юм. Энэ нь хүмүүс боломжийн ажил эрхэлж, орлогоо нэмэгдүүлж улмаар эдийн засгийн хөгжлийн хөдөлгөгч хөшүүрэг болдог бүтээлч байдлыг бий болгодог. Боловсрол нь охид эмэгтэйчүүдийг эдийн засгийн, нийгмийн болон улс төрийн хувьд гэгээрүүлж, тэдгээрт оролцох боломжийг бүрдүүлж өгдгөөрөө жендэрийн тэгш байдлыг хангах хамгийн хүчтэй арга болж өгнө. Мөн боловсрол нь хувь хүний эрүүл мэндийг сахин хамгаалах хамгийн боломжтой аргын нэг тул түүний үр шимийг хойч үеийнхэндээ хүртээхэд анхаарах хэрэгтэй. Боловсролын ачаар олон сая хүүхэд, ээжүүдийн амь аврагдаж, хоол тэжээлийн дутагдлыг бууруулах, өвчнөөс урьдчилан сэргийлж чадна. Үүнээс гадна боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулахыг хөхиүлэн дэмждэг.⁷ Эцэст нь ямар нэгэн хямрал, мөргөлдөөнд нэрвэгдсэн хүүхэд, өсвөр үе, насанд хүрэгчдийн хувьд

өөрсдийн амьдрал, нийгмээ дахин сэргээн босгоход тусалж, хамгаалагч нь болдог билээ.

Боловсролын үр өгөөж, хүч чадлыг бүх хүнд нээлттэй болгох нь газар бүрт, ялангуяа зөрчилдөөн бүхий улс орон, бүс нутгуудад илүү их боломжийг бүрдүүлнэ. Мөргөлдөөн болон онцгой байдлын нөхцөлд боловсролын хувьд хамгийн их тасалдал үүсдэг. Иймд мөргөлдөөн, нийгмийн тогтворгүй байдал, байгалийн гамшгийн үед илүү найдвартай, хариу үйлдэл үзүүлэх чадвар бүхий боловсролын тогтолцоог хөгжүүлэх, онцгой байдал, мөргөлдөөн, мөргөлдөөний дараах нөхцөл байдлуудад ч боловсрол тасралтгүй байх явдлыг хангах ёстой. Аливаа мөргөлдөөнөөс сэргийлэх, хямралыг зохицуулах, энхийг дэмжих зэрэгт чанартай, сайн боловсрол гол тулгуур болж өгнө.

Олон улсын баримт бичиг, гэрээнүүд тухайлбал Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйл⁸, Боловсрол дахь алагчлалын эсрэг конвенц⁹, Хүүхдийн эрхийн тухай конвенц¹⁰, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх олон улсын Пакт¹¹, Хөгжлийн бэрхшээлтэй

⁸ НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 он. www.un.org/en/documents/udhr.

⁹ НҮББСШУБ, Боловсрол дахь алагчлалын эсрэг конвенц 1960. www.unesco.org/education/pdf/DISCR1_E.PDF

¹⁰ НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989. www.ohchr.org/en/professionalinterest/paaes/crc.aspx

¹¹ НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт 1960. www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Paaes/CE-SCR.aspx. Пактын заалтад (Зүйл 13.2.)

2. Энэхүү Пактад оролцогч улсууд энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд:

- (а) хүн бүрт бага боловсролыг заавал, үнэ төлбөргүй олгох;
- (б) үнэ төлбөргүй боловсрол олгохыг дэвшилттэйгээр нэвтрүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээ авах замаар, техник-мэргэжлийн дунд сургуулийн боловсролыг оролцуулан, дунд боловсролын төрөл бүрийн хэлбэрийг бүгдэд боломжтой, хүртээмжтэй болгох;
- (с) үнэ төлбөргүй боловсрол олгохыг дэвшилттэйгээр нэвтрүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээ авах замаар, авьяас чадварыг нь харгалзан, дээд боловсролыг бүгдэд ижил хүртээмжтэй болгох;
- (д) бага боловсролтой бүрэн болоогүй буюу бага сургуулийг бүрэн төгсөөгүй хүн суурь боловсролтой болохыг хөхиүлэн дэмжих буюу эрчимжүүлэх;

⁶ НҮББСШУБ, 2014 он, БНБ-ын Дэлхийн үнэлгээний тайлан 2013/4 - Сурах болон Сургахуй: Бүх нийтэд чанарыг хүргэх нь: <http://unesdoc.unesco.org/imaees/0022/002256/225660e.pdf>.

⁷ Банкс, ЛМ, Полак, С нар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэгш хамруулахын өгөөж ба тусгаарлахын зардал: Бага, дунд орлоготой орнуудын туршлага <http://disabilitycentre.ishtm.ac.uk/files/2014/07/Costs-of-Exclusion-and-Gains-of-Inclusion-Report.pdf>.

хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц¹², Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц¹³, Дүрвэгсдийн эрх зүйн байдлын талаарх конвенц¹⁴ болон Онцгой байдлын нөхцөл дэх сурч боловсрох эрхийн тухай НҮБ-ын Ерөнхий Ассемблейн тогтоол¹⁵ зэрэг нь энэхүү Үйл ажиллагааны төлөвлөгөөний үндсэн зарчмуудыг тодорхойлсон юм. Эдгээр зарчмыг авч үзвэл:

- **Боловсрол нь хүний суурь эрх бөгөөд эрхийг хэрэгжүүлэгч.** Энэ эрхийг хангахын тулд улс орон нь хүн бүрийг тэгш хамруулсан, үнэ төлбөргүй, заавал эзэмшүүлэх чанартай, хүртээмжтэй боловсролын хүртээмжийг бүрэн хангах ёстой. Боловсрол нь харилцан ойлголцол, найрамдал нөхөрлөл, энх тайван, хүлцэн тэвчлийг дэмжин, хүн бүрийг бүрэн хөгжүүлэх зорилгыг өмнөө тавих ёстой.
- **Боловсрол нь нийтийн сайн сайхан байдал юм.** Төр энэ үүргийг хүлээгч байна. Боловсрол нь төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх оролцооны үйл явцын хүрээнд бий болдог нийгмийн хамтын хүчин чармайлт юм. Иргэний нийгэм, хувийн хэвшил, олон нийт, багш, сурган хүмүүжүүлэгчид, гэр бүл, хүүхэд залуучууд бүгд чанартай боловсрол эзэмших эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймд төрийн үүрэг хэм хэмжээ, стандарт тогтоох, зохицуулах явдал юм¹⁶.

¹² НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, 2006 он, www.un.org/disabilities/convention/conventionfull.shtml.

¹³ НҮБ-ын. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, 1979 он. www.un.org/womenwatch/daw/cedaw/text/econvention.htm.

¹⁴ НҮБ-ын. Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц., 1951 он, www.unhcr.org/3b66c2aa10.html

¹⁵ НҮБ. Онцгой байдлын нөхцөл дэх сурч боловсрох эрхийн тухай тогтоол., 2010 он, www.ineesite.org/uploads/files/resources

¹⁶ НҮББСШУБ. 2015. Боловсролын талаар дахин эргэцүүлэхүй:

- **Жендэрийн тэгш байдал нь хүн бүрийн сурч боловсрох эрхтэй шууд холбогддог.** Жендэрийн тэгш байдлыг хангахын тулд охид, хөвгүүд, эрэгтэйчүүд эмэгтэйчүүд сурч боловсрох, сургуулиа дүүргэх боломжтой төдийгүй боловсролоор дамжуулан адил тэгш чадавхижиж чадахуйц хүний эрхэд суурилсан хандлага шаардлагатай.

ЗОРИЛГО, СТРАТЕГИЙН ХАНДЛАГУУД, ЗОРИЛТОТ ТҮВШИН БА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эрхэм зорилго “тэгш хамарсан, тэгш боломжийг баталгаажуулсан чанартай боловсрол, насан туршдаа суралцах боломжоор хангах”

Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030–ийн боловсролын зорилго нь (ТХЗ 4) бүх түвшинд хүртээмжтэй, тэгш чанартай боловсрол олгох явдал бөгөөд Боловсрол 2030 хөтөлбөрийн шинэ онцлог шинж нь Үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд илэрхийлэгдсэн байна.

Бүх хүүхэд, өсвөр үеийнхэнд хүртээмжтэй, наад зах нь 12 жилийн чанартай боловсрол нь төрөөс санхүүждэг, үнэ төлбөргүй, тэгш хамруулсан байх ёстой. Сургуулиас гадуур буй хүүхэд, залуучуудад зориулан төрөл бүрийн арга, хэлбэрээр дамжуулан заавал суралцах анхан болон дунд боловсрол наад зах нь есөн жил байна. Мөн бүх залуучууд, насанд хүрэгчид бичиг үсэг болон тоо тооллын ерөнхий суурь чадвар эзэмшиж, идэвхтэй иргэн болохын хувьд нийгмийн үйл хэрэгт бүрэн оролцож чадахуйц байхаар суралцах боломжийг хангаж өгөх хэрэгтэй. Үүний хамт, сайн чанар бүхий сургуулийн өмнөх боловсролыг наад зах нь нэг жилийн хугацаанд заавал эзэмших боломжоор хангах хэрэгтэй.

номноос сийрүүлэн оруулав.

Боловсролд болон боловсролоор дамжуулан тэгш оролцоо, тэгш байдлыг хангах, боловсролын хүртээмж, оролцоо, боловсрол эзэмших, төгсөх болон сургалтын үр дүнгийн хувьд гадуурхах, тусгаарлах, тэгш бусаар хандах, ялгаварлах зэрэг эмзэг, тэгш бус байдлын бүх хэлбэрийг шийдвэрлэхийг хичээх ёстой. Бүх нийтийг тэгш хамруулах боловсрол нь суралцагчийн олон янз байдал, хэрэгцээ шаардлагад нийцсэн төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, сурч боловсрох эрхийг хангахад саад болж буй алагчлал, ялгаварлан гадуурхалтын олон хэлбэр, онцгой байдлын нөхцөл байдал зэргийг шийдвэрлэх хэрэгтэй. Боловсрол 2030 хөтөлбөрийн өөр нэг чухал онцлог нь жендэрийн тэгш байдлыг хангах явдал бөгөөд эмзэг бүлгийнхэнд чиглэсэн жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтад анхаарах, энэ зорилгын хүрээнд хэнийг ч ардаа орхигдуулахгүй байхад онцгой анхаарал хандуулдаг. Энэ зорилт бүх хүнд биелж чадаагүй бол боловсролын талаарх ямар ч зорилтот түвшинг хангасан гэж үзэхгүй болно.

Сурч боловсрох эрхийн салшгүй нэг хэсэг нь бүх шатны болон бүх хэлбэрийн зохистой, нийцтэй, эрх тэгш, чанартай суралцахуйн үр дүнд хүргэх явдал юм. Чанартай боловсрол гэдэг нь наад зах нь цаашид үргэлжлүүлэн суралцах чадварыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхүйц бичиг үсгийн болон тоо тооллын суурь чадвар, улмаар дээд зэргийн чадвар чадамжийг хөгжүүлэх байдлыг шаардана. Энэ байдал нь бүх суралцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн, сургах болон суралцах арга зүй, агуулгатай байхыг шаардана. Мөн аюулгүй, эрүүл, жендэрийн мэдрэмжтэй, тэгш хамруулсан, хангалттай нөөц бололцоо бүхий сургалтын орчныг бүрдүүлж, зохих

сурган хүмүүжүүлэх арга барил хэрэглэх чадвартай, мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) дэмжлэгтэйгээр сайн бэлтгэгдэж, мэргэшсэн, хангалттай цалин хөлс, хүсэл эрмэлзэл бүхий багш нараар заалгахыг шаарддаг.

Сурч боловсрох эрх нь төрснөөр эхэлж, хүний амьдралын туршид үргэлжилнэ. Тиймээс насан туршийн суралцахуйн үзэл баримтлал¹⁷ нь Боловсрол 2030 хөтөлбөрийг чиглүүлнэ. Албан ёсны сургуулиас гадна түүний нэмэлт хөтөлбөр нь хангалттай нөөц, механизм бүхий албан бус боловсрол, МХХТ-ийг ашиглах зэрэг албан бус сургалтыг дэмжих замаар өргөн цар хүрээ бүхий уян хатан насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлэх ёстой.

Боловсролын талаарх ТХЗ 4 болон бусад ТХЗ-уудад хамаарах боловсролын зорилтот түвшинд хүрэхийн тулд дараахад чиглэсэн үндэсний, бүс нутгийн болон олон улсын хүчин чармайлтыг нэгтгэн дайчлах шаардлагатай байна. Үүнд:

- ✓ Үр өгөөжтэй, тэгш хамруулах түншлэл, хамтын ажиллагааг хангах;
- ✓ Боловсролын бодлого, тэдгээртэй хамтран ажиллах арга замыг сайжруулах;
- ✓ Бүх нийтэд хүртээмжтэй, тэгш боломж, тэгш хамруулсан, чанартай боловсролын тогтолцоог бий болгох;
- ✓ Боловсролд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн дайчлах;

¹⁷ "Мөн чанартаа, насан туршдаа суралцах гэдэг нь бүх насны хүмүүс (хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид, өндөр настан, охид, хөвгүүд, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд) амьдралын бүхий л нөхцөлд (гэр бүл, сургууль, олон нийт, ажлын байр гэх мэт) илүү өргөн хүрээнд амьдрах, сурч боловсрох явдлыг нэгтгэх үйл явц юм. Энэ нь сурч боловсрох, хөгжих олон төрлийн хэрэгцээ, шаардлагыг албан ба албан бус боловсрол, бусад арга хэлбэрээр хангах явдал юм. Насан туршийн суралцахуйг дэмждэг боловсролын тогтолцоо нь бүх хүмүүсийн сурч боловсрох боломжийг хангахын тулд холбогдох бүх салбар, түвшинг хамруулсан салбар дундын цогц хандлагыг хэрэгжүүлнэ. (ЮНЕСКО-ын Насан туршийн боловсролын хүрээлэн, Техникийн тайлбар: Насан туршийн суралцахуй http://uil.unesco.org/fileadmin/keydocuments/LifelongLearning/en/UNESCO_TechNotes_LLL.pdf.)

✓ Бүх зорилтот түвшинг хангахуйц хяналт - шинжилгээ, баталгаажилт тайлагналт, авч хэрэгжүүлэх арга хэмжээг авах зэрэг болно.

Стратегийн эдгээр хандлагууд нь (доор дурдсан) бүх нийтэд хамааралтайгаар өндөр түвшинд тодорхойлсон Боловсрол 2030 хөтөлбөрийг хангах, түүний хэрэгжилтийн явцыг хянахыг зөвлөж байна. Бүх нийтийн боловсролын болон МХЗ-уудын сургамжуудад тулгуурлан улс орон бүр хүн бүр ялангуяа хамгийн хүнд, хэцүү нөхцөлд байдаг хүмүүст онцгойлон анхаарч тэд оролцох, суралцах боломж бүхий чанартай боловсролыг бүрдүүлж, үр өгөөжийг нь өргөжүүлэхийн тулд хөрөнгө оруулалт хийж, шинэлэг, нотолгоонд суурилсан, үр ашигтай хандлагуудыг нэвтрүүлэх ёстой. Үүнээс гадна дэвшүүлсэн зорилт тус бүрийг ханган биелүүлэх тодорхой стратегийг хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр стратегиуд ерөнхий бөгөөд нэн тэргүүнд улс орон, засгийн газрууд өөрийн орны нөхцөл байдалд нийцүүлэн зохих байдлаар өөрчлөн зохицуулах шаардлагатай гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй болон тогтолцоог бэхжүүлэх

Олон улсын хэм хэмжээ тогтоосон олон тооны баримт бичигт сурч боловсрох хүний үндсэн эрхийг баталгаажуулсан байдаг. Эрх зүйн хариуцлага бүхий эдгээр гэрээ, конвенц, хэлэлцээр, протокол болон бусад хууль ёсоор дагаж мөрдвөл зохих тунхаглал, зөвлөмж¹⁸ зэрэг олон улсын баримт бичгүүд нь сурч боловсрох эрхийг ямар нэгэн ялгаварлан гадуурхалт, алагчлалгүйгээр ханган хэрэгжүүлэх олон улсын хэм хэмжээний улс төрийн болон ёс

суртахууны үндэс суурь болж өгдөг. Засгийн газар манлайлан бусад оролцогч талуудыг оролцуулан, чанартай боловсролыг тогтвортой хөгжүүлэх, хүн бүрт хүргэхийн төлөө хууль, эрх зүйн болон бодлогын орчинг хангах, нөхцөлийг бүрдүүлэх, мөн тус тусын үүргээ биелүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарах ёстой.

Шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гол анхаарах зүйл бол боловсролын тогтолцооны үр ашиг, үр өгөөж болон эрх тэгш байдал байх ёстой. Боловсролын тогтолцоо нь одоогийн байдлаар алагчлалд өртөж байгаа, эсхүл эмзэг байдалд орох эрсдэлтэй хүмүүст хүрэх, тэднийг татах, тэднийг авч үлдэхэд чиглэх ёстой. Түүнчлэн, чанартай боловсролоор хангах, боловсролын үр өгөөжтэй байдлыг хангахын тулд Засгийн газар боловсролын тогтолцоог дараах асуудлаар чадавхийг нь бэхжүүлэх хэрэгтэй. Үүнд үр өгөөжтэй, нийцэн тохирсон, тэгш хамруулсан засаглал, хариуцлагын механизмыг сайжруулах; чанарын баталгаажуулалтыг боловсронгуй болгох; боловсролын удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэх; ил тод, үр дүнтэй санхүүжилтийн журам, механизмыг бүрдүүлэх, байгууллагын удирдлага зохион байгуулалтыг цаг хугацаанд нь сайтар хангах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсролын тогтолцоог бэхжүүлэх, мэдлэг түгээх, мэдээлэл олж авах, чанартай, үр дүнтэй суралцах ба сургах арга барил хөгжүүлэх, илүү үр өгөөжтэй, ашигтай үйлчилгээ үзүүлэхэд инноваци ба технологийн дэвшлийг ашиглах зэрэг болно. Тогтолцооны үр өгөөжийг бэхжүүлэх нь Өмнөд-Өмнөдийн буюу нь гурвалсан хамтын ажиллагаа өрнүүлэх, сайн арга туршлагаа солилцох, улс орон, бүс нутгийн нөхцөлд нэвтрүүлэх зэрэг хэлбэрээр явагдана.

¹⁸ НҮБ, НҮБ-ын гэрээний эмхэтгэлд хэрэглэгддэг гол нэр томъёоны тодорхойлолт. http://treaties.un.org/Pages/Overview.aspx?path=overview/definition/page1_en.xml

Тэгш боломж, тэгш хамруулалт, жендерийн тэгш байдлыг чухалчлан үзэх нь

Олон сая хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн сурч боловсрох, чанартай суралцахад саад болж буй нийгэм, соёл, эдийн засгийн саад бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрт нийцсэн, салбар хоорондын бодлого, төлөвлөлтийг хөгжүүлэх, эсвэл сайжруулах хэрэгтэй. Холбогдох бодит жишиг, жишээ загварыг үндэсний хэмжээнд тогтоох ёстой. Энэ нь нийгмээс тусгаарлагдсан хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн нөхцөл байдлыг шийдвэрлэхүйц боловсролын агуулга, хандлага, бүтэц, санхүүжилтийн стратегид хийвэл зохих өөрчлөлтийг өөртөө багтаасан байх ёстой. Нийгмээс тусгаарлагдсан байдлыг шийдвэрлэх нотолгоонд суурилсан дараах бодлого, стратегийг хэрэгжүүлж болно. Тухайлбал, бэлэн мөнгө тараах хөтөлбөр; сургуулийн хоол хүнс, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, сурах болон сургах материал, тээврийн үйлчилгээгээр хангах; хоёр дахь удаа дахин суралцах хөтөлбөр; тэгш хамруулахад зориулан сургуулийн тоног хэрэгслийг шинэчлэх, тэгш хамруулах боловсролоор багш нарыг давтан сургах; тусгай нэмэлт хэлний бодлого зэргээр тусгаарлагдсан байдлыг шийдвэрлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг бууруулж болно. Боловсрол дахь ялгаатай байдлыг бууруулахын тулд тэгш бус байдлыг багасгах зорилт дэвшүүлж, түүнд хүрэх арга хэмжээ, эдгээр зорилтын ахиц дэвшлийг хянах зорилгоор бүх улс орон, тухайн хүн амын бүлгүүдийн онцлог шинж чанарыг тусган нарийвчилсан, ангилсан мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийж, тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн үзүүлэлт, ахиц дэвшил бүрийг хэмжих шаардлагатай.

Жендэрийн тэгш байдлыг хангахын тулд боловсролын систем нь нийгмийн болон соёлын хандлага, эдийн засгийн статусаас хамааран үүсэж буй ялгаварлан гадуурхал, жендэрт суурилсан алагчлалыг арилгахад чиглэсэн тодорхой арга хэмжээ авах ёстой. Засгийн газар болон түүний түншүүд жендэрийн тэгш байдлыг хангах, охид, хөвгүүд, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд адил тэгш үр нөлөө үзүүлэх, жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг арилгахын тулд жендерийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт хийх, үүнд суралцах орчин бүрдүүлэх; багш нарын сургалт, давтан сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах, хөтөлбөрт нь дүн шинжилгээ хийх, боловсролын байгууллагуудад жендэрт суурилсан алагчлал, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг арилгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлбэл зохино. Ялангуяа боловсролын байгууллагуудад болон түүнд ирэх, явах зам зэрэг бүх нөхцөл байдалд нь түүний дотроос зөрчилдөөн, мөргөлдөөний үед охид, эмэгтэйчүүдийн хувийн аюулгүй байдлыг хангах тусгай арга хэмжээг заавал авч хэрэгжүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чанартай боловсрол эзэмшихэд томоохон саад бэрхшээл тулгардаг, нөгөө талаас үр дүнтэй арга хэмжээг дэмжих мэдээлэл дутмаг байдгийг үндэслэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид чанартай боловсрол эзэмших, түүний үр шимийг хүртэхэд чиглэсэн тодорхой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Чанар ба суралцахуйд анхаарлаа хандуулах нь

Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд сургалтын чанар, түүний үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээг мөн хамт авч хэрэгжүүлэх ёстой.

Боловсролын байгууллага, хөтөлбөрүүд нь аюулгүй, байгаль орчинд ээлтэй, хүн бүхэнд хүртээмжтэй тоноглол, төхөөрөмжтэй, хангалттай, хүрэлцээтэй нөөц боломжтой, суралцагч төвтэй, идэвхтэй, хамтран ажилладаг сурган хүмүүжүүлэх арга барилд суралцсан хангалттай тооны багш нартай, ямар нэг хэлбэрээр ялгаварлалгүйгээр, хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид зэрэг бүх суралцагчдад ээлтэй, хүртээмжтэй, үр өгөөжтэй, суралцагч бүрд тохиромжтой боловч зардлын хувьд үр ашигтай сурах бичиг, ном, бусад сургалтын материал болон боловсролын нээлттэй нөөц, технологиор хангагдсан байх ёстой. Багш, сурган хүмүүжүүлэгчид нь сайтар сурч боловсорсон, хүрэлцэхүйц тоогоор бэлтгэгдсэн, цалин, урамшуулал хангалттай, мэргэшсэн чадварлаг, урам зоригтой, нөөц боломжоор хангагдсан, үр дүнтэй, зохистой удирдлагаар удирдуулж, дэмжлэг хүлээсэн байвал зохино. Мөн боловсролын нийт тогтолцоонд үр ашигтай, эрх тэгш ажиллаж байхаар багшийг дэмжих тусгайлсан бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх ёстой. Сургалтын орц, орчин нөхцөл, үйл явц, үр дүнгийн үнэлгээг багтаасан чанартай сургалтын үнэлгээний тогтолцоо, практикийг бүрдүүлж, тогтмол сайжруулж байх шаардлагатай. Сургалтын зохих үр дүнг танин мэдэхүйн болон танин мэдэхүйн бус агуулга, мэдлэгийн тогтолцоогоор дамжуулан сурах болон сургах үйл явцын салшгүй хэсэг болгон тогтмол үнэлж байх ёстой. Чанартай боловсрол нь эрүүл, зөв амьдралын хэв маяг бүхий, орон нутгийн болон олон улсын тулгамдсан асуудалд хариу арга хэмжээ авах чадвартай, мэдээллийн үндсэнд шийдвэр гаргах чадвар бүхий иргэдийн мэдлэг, чадвар, үнэт зүйлс, хандлагыг хөгжүүлж төлөвшүүлэх явдлыг ойлгоно. Чанар, инновацийн талаар

анхаарал хандуулах нь мөн шинжлэх ухаан, технологи, инженерийн болон математикийн боловсролыг (ШУТИМ) илүү бэхжүүлэх шаардлагыг илэрхийлж байна.

Насан туршийн суралцахуйг дэмжих нь

Бүх насны хүмүүс түүний дотор насанд хүрэгчид суралцах, дахин үргэлжлүүлэн суралцах боломжтой байх ёстой. Хүн бүр төрснөөс эхлэн бүх орчинд, боловсролын бүх шатанд насан туршдаа суралцах боломж нь орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын түвшний бат бэх түншлэл, хангалттай нөөц бололцоо бүхий хөтөлбөр, байгууллагын стратеги, бодлого зэргээр дамжуулан боловсролын тогтолцоонд бүрэн суулгагдсан байх ёстой. Энэ нь олон тооны уян хатан сургалтын хувлбаруудыг бий болгох, боловсролын аль ч шатанд аль ч насанд суралцах, дахин элсэх боломжийг бүрдүүлэх, албан ба албан бус боловсролын уялдаа холбоог бүх түвшинд бэхжүүлэх болон албан бус болон бусад боловсролоор дамжуулан олж авсан мэдлэг, чадвар, чадамжийг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, магадлан итгэмжлэх зэрэг нөхцөл шаардана. Насан туршдаа суралцахуй нь мөн холбогдох чанарын баталгаа бүхий техникийн, мэргэжлийн болон чанартай дээд боловсрол эзэмших, судалгаа хийх болон тэдгээрийн тэгш боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг өөртөө агуулсан байна.

Бичиг үсэг мэдэхгүй хэвээр үлдсэн хэдэн арван сая хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн хэрэгцээг шийдвэрлэхийн тулд тусгай арга хэмжээ авч, санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүнээс гадна, бүх залуучууд, насанд хүрэгчид, ялангуяа охид, эмэгтэйчүүдэд зохистой хөдөлмөр эрхлэх, амьдрахад шаардлагатай үр чадварыг эзэмшүүлэх, бичиг үсэг мэдэх,

тоо бодох чадвартай болох боломжийг бүрдүүлж өгөх, нөхцөлийг хангах, тэдний хүрсэн түвшинг хүлээн зөвшөөрөх шаардлагатай байна. Хамгийн чухал нь насанд хүрэгчид сургалт, боловсролд хамрагдах, суралцах боломжийг хангаж өгөх ёстой. Боловсрол, шинжлэх ухаан, технологи, гэр бүл, хөдөлмөр эрхлэлт, аж үйлдвэрийн болон эдийн засгийн хөгжил, шилжилт хөдөлгөөн, иргэн болох, нийгмийн халамжийн ба төрийн санхүүгийн бодлого зэргийн талаар салбар дундын хандлагыг нэвтрүүлэх хэрэгтэй.

Онцгой байдлын нөхцөлд боловсрол олгох нь

Байгалийн гамшиг, цар тахал, зөрчил мөргөлдөөн нь дотоодын болон хил дамнасан шилжилт хөдөлгөөнийг үүсгэж, үр дүнд нь улс орон, бүс нутгийнхаа нийгэм, эдийн засгийн сэргээн босголтод хувь нэмэр оруулах боломжгүй, боловсролгүй, бэлтгэгдээгүй болон цочролд орсон бүхэл бүтэн хүний үе гарч ирдэг. Хямрал бол боловсролын хүргээмжийг хязгаарлаж буй гол саад бэрхшээл бөгөөд сүүлийн арван жилийн хувьд Бүх нийтийн боловсролын зорилтуудад чиглэсэн ахиц дэвшлийг зарим тохиолдолд буцаан бууруулахад хүргэж байна. Онцгой байдлын нөхцөл дэх боловсролын үндсэн чиглэл бол түргэн хугацаанд хамгаалах буюу хямралд өртсөн хүмүүст нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, амь насаа хамгаалах мэдлэг, чадвар суулгах явдал болно. Боловсрол нь хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд гамшиг, мөргөлдөөн, өвчнөөс урьдчилан сэргийлэх чадвар болон улмаар тогтвортой ирээдүйг бүрдүүлж чадна.

Иймд улс орнууд, хямралын нөхцөлд буй хүүхдүүд, залуучууд, насанд хүрэгчид, ялангуяа дотоодын шилжин суурьшигчид, дүрвэгсдийн хэрэгцээг хангахуйц оролцоог

хангасан, хариу үйлдэл үзүүлсэн, уян хатан боловсролын тогтолцоог бий болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах зарчмууд болон Онцгой байдлын нөхцөл дэх боловсролын төлөө агентлаг хоорондын сүлжээ (INEE)-ний боловсруулсан Наад захын жишиг стандарт зэрэг олон улсын удирдамжууд нь тухайн нөхцөлд төлөвлөлт хийх болон хариу арга хэмжээ авах үндсэн чиглэл болно. Боловсролын салбарын төлөвлөгөө, бодлого нь байгалийн гамшиг, мөргөлдөөний эрсдлийг бууруулах, аюулгүй байдал, тогтвортой чанар болон нийгмийн харилцааг дэмжих зорилгоор хямралын нөхцөлд буй хүүхэд, насанд хүрэгчдийн боловсролын хэрэгцээг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, эрсдэлийг урьдчилан харахад чиглэх ёстой. Гамшгийн үеийн яаралтай хариу арга хэмжээнээс нөхөн сэргээх явцад эрсдлийг бууруулж, бүх үе шатанд боловсролын үйлчилгээ үзүүлж болохыг хангахын тулд гамшгийн эрсдлийг бууруулах, энх тайвны боловсрол олгох, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, онцгой байдлын бэлэн байдал хангах, яаралтай хариу арга хэмжээ авах зэрэг асуудлаар Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бүх түвшинд сайжруулах шаардлагатай байна. Онцгой байдлын нөхцөлд бэлтгэгдсэн, хариу үзүүлэх чадвар бүхий илүү аюулгүй, тэгш боломж бүхий боловсролын тогтолцоог бүрдүүлэхийн тулд сайтар зохион байгуулалттай үндэсний, бүс нутгийн болон олон улсын тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай байна.

Боловсролын байгууллагууд нь хүчирхийллээс ангид, энхийг эрхэмлэсэн бүс байх бөгөөд түүний дотор сургуулийн түвшинд жендэрт суурилсан хүчирхийлэлгүй,

хамгаалагдсан орчин болохын тулд бүх оролцогч талууд хүчин чармайлт гаргах шаардлагатай. Ялангуяа мөргөлдөөний бүсэд эмэгтэйчүүд, охидыг хамгаалахад чиглэсэн тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой. Сургууль, боловсролын байгууллага руу хүрэх болон түүнээс буцах зам, маршрут нь аливаа халдлага, албадан элсүүлэх, хулгайлах, бэлгийн хүчирхийлэл зэргээс ангид байх ёстой. Боловсролын байгууллагууд руу довтолсон хүн, зэвсэгт бүлгийнхэн ял шийтгэлгүй үлдэх явдлыг эцэс болгохын тулд шаардлагатай арга хэмжээг авах ёстой.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭЛБЭРҮҮД

Боловсрол 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд засаглал, хариуцлага, зохицуулалт, хяналт, зөвлөгөө, эргэн хянах, мэдээлэх, үнэлэх механизмуудыг үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд боловсруулах шаардлага урган гарч байна. Мөн хамтын ажиллагаа, эдийн засгийн стратегийг нэвтрүүлэх шаардлагатай байна. **Боловсрол 2030 хөтөлбөрийн хэрэгжилтийн механизмын гол зорилго нь тухайн улсаас гүйцэтгэж буй үйл ажиллагааг дэмжих юм.** Эдгээр механизм илүү үр нөлөөтэй байхын тулд тэгш хамруулах, ил тод байдал, оролцоог хангасан байх ёстой. Үүнд буй боломжийг нэмэгдүүлэх үүднээс одоогийн механизм дээр үндэслэн хэрэгжүүлэх болно.

Засаглал, хариуцлага, түншлэл

Боловсрол 2030 хөтөлбөрийн цөм нь үндэсний түвшинд байна. **Засгийн газрууд** сурч боловсрох эрхийг хангах анхдагч үүргийг хүлээдэг ба гол үүрэг нь бүх нийтийн боловсролыг үр дүнтэй, тэгш боломжтой, үр нөлөөтэй менежмент ба санхүүжилтээр хангах явдал юм. Тэд боловсролын салбарт манлайллын үүргийг

хэрэгжүүлж, бусад чухал түншүүдийн хамт ил тод байдал, тэгш хамруулах зарчмыг баримтлан үндэсний туршлага, давуу байдлаа ашиглан Боловсрол 2030 хөтөлбөрийн зорилго, зорилтыг нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжүүлэх болно. Орон нутаг, хүн ам, сургуулиудын ялгаатай байдлыг бууруулах, чанарыг дээшлүүлэх зохицуулалтын стандартад төр онцлох байр суурь эзэлдэг. Засгийн газрын сурч боловсрох эрхийг бүрдүүлэх хамгаалах, хүндэтгэх хуулийн үүргийг тусгасан бодлогын дагуу засгийн газар ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийн бодлого ба хүмүүнлэгийн үйл ажиллагааг дэмжих зохистой цогц боловсролын төлөвлөгөө шаардлагатай байна.

2030 он хүртэл 15 жилийн турш шийдвэр гаргах үйл явцын бүх түвшинд боловсролын бодлогын хэрэгжилт, хөгжилд иргэдийн үзэл бодол, эрх ашгийг тусган илүү ардчилсан болно гэж үзэж байна. Олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх нь төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт тавихад хялбар болгож гол оролцогч хүчнүүд нэгдэн хийж болохуйц үйл ажиллагаа хувь нэмрийг доор харууллаа. Бүх түвшний хамтрагч талууд нь харилцан хариуцлагатай, ил тод, нэгдмэл байдлыг эрхэмлэсэн нээлттэй, тэгш хамруулах, оролцоог хангах бодлогын зарчмыг мөрдөж ажиллах ёстой. Оролцоо нь гэр бүл, хүн амыг хамруулахаас эхлэх ёстой ба ил тод байдлыг нэмэгдүүлэн, боловсролын удирдлагын сайн засаглалыг хангана. Сургуулийн түвшинд хариуцлагыг нэмэгдүүлснээр боловсролын үйлчилгээг илүү үр дүнтэй хүргэх болно.

Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ-ууд)-ын төлөөлөл, олон нийтийг хамарсан холбоо, сүлжээ чухал үүрэг гүйцэтгэнэ. Тэднийг төлөвлөлтөөс эхлээд хяналт, үнэлгээ зэрэг бүх шатанд зохион

байгуулалттай, найдвартай оролцоог ханган хамруулах хэрэгтэй.

- ИНБ-ууд нь нийгмийн хөдөлгөөнийг дэмжих ба олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж бодлого боловсруулахад иргэний (ялангуяа алагчлалд өртдөг хүмүүс) дуу хоолойг хүргэж чадна;
- Бүх хүмүүс, ялангуяа хамгийн эмзэг бүлгийнхний сурч боловсрох эрхийг хэрэгжилтийг хангахад шинэлэг бөгөөд цогц арга хандлагыг нэвтрүүлэх;
- Олж авсан туршлага, иргэний хяналт болон засгийн газрыг хянах үүргийг хариуцуулах, хөгжил дэвшилд хүргэх, нотолгоонд суурилсан нөлөөлөл, оновчтой төсөвлөлт, зарцуулалт, боловсролын засаглал болон ил тод байдлын талаарх засгийн газрын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, бодлогын хэлэлцүүлгийг мэдээлэн түгээх, баталгаажуулах үүргийг гүйцэтгэнэ.

Багш нар ба сургагчид ба тэдгээрийн байгууллагууд нь өөрсдийн эрхийг хамгаалахад шийдвэрлэгч түншүүд байх бөгөөд бодлого боловсруулах, төлөвлөх, гүйцэтгэх, хяналт тавих зэрэг бүх шатанд оролцох ёстой. Багш нар, сургагчид нь дараах арга хэлбэрээр хувь хүнд дэмжлэг үзүүлж чадна. Үүнд:

- Мэргэшсэн байдал, үүрэг хариуцлагадаа тулгуурлан суралцагчдын суралцах эрмэлзлийг хангах,
- Сургалт явагдаж буй бодит байдлыг бодлого боловсруулагчид, төлөвлөгч ба бодлогын хэрэгжилтийг зохицуулагчдад танилцуулан, амьдрал дээрх бодит туршлагаас хуваалцаж, тэдний нэгдсэн ойлголтод нөлөөлөх болон бодлого төлөвлөлтөд өөрсдийн

хамтын болон мэргэжилтний санал дүгнэлтийг хүргүүлэх;

- Тэгш хамруулалт, тэгш боломжийг хангаж чанарыг эрхэмлэх, сургалтын хөтөлбөр, заах аргыг сайжруулах.

Хувийн хэвшил, хүмүүнлэгийн байгууллага, сангууд чухал үүрэг гүйцэтгэж чадна. Тэдний хувьд өөрсдийн туршлага, шинэлэг хандлага, ажлын дадлага, санхүүгийн боломжоо ашиглан бүх нийтийн боловсролыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна. Эдгээр байгууллага нь ил тод байдал, орон нутгийн буюу үндэсний эрх ашгийг дээдлэн, боловсролыг хүний эрх болохын хувьд хүндэтгэж, ялгаатай байдлыг бууруулахад олон талт хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт зэргээр хувь нэмрээ оруулж тусалж чадна. Түүнчлэн, эдгээр нь:

- Татвар төлөх зэргээр бүх нийтийн боловсролд нэмэлт хөрөнгө оруулах боломжтой ба тулгамдсан буюу тэргүүлэх салбарт хөрөнгө оруулахад илүүтэй анхаарах;
- Мэдлэг, дадлага олгох сургалтыг төлөвлөгчдөд хөдөлмөрийн зах зээлийн хандлага, шаардагдах чадвар, туршлагыг ойлгоход туслах, ингэснээр сургуулиас ажилд шилжих боломжийг нэмэгдүүлэх болон бусад талаар боловсролын салбарт тулгамдсан асуудалд шинэлэг арга хандлага нэвтрүүлэх;
- Нэмэлт үйлчилгээ үзүүлэх, төрийн зохицуулалттай стандарт, хэм хэмжээг мөрдүүлэх ажлын хүрээнд эмзэг бүлгийг хамруулах үйл ажиллагаа явуулснаар тэгш хамруулах боловсролын чадамжийг нэмэгдүүлнэ.

Судлаач олон нийт нь боловсролын хөгжилд ерөнхий, бодлогын хэлэлцүүлэгт тодорхой хувь нэмрээ оруулдаг. Үүнд нь:

- Бодлоготой уялдсан судалгаа, үйл ажиллагааны судалгаа хийснээр зорилтуудад хүрэх, боловсролын талаарх мэдлэгийг хэрэглэхэд тохиромжтой хэлбэр, аргын талаар бодлого боловсруулагчдад хүргэх;
- Тоон болон чанарын судалгаа хийх орон нутгийн болон үндэсний тогтвортой чадамжийг бүрдүүлэх;
- Хөгжил дэвшлийн төлөвлөгөө, зорилгын хэсэг, шийдэл ба шинэлэг санаа бүхий, ямар ч хүрээнд хаана ч ашиглаж болохуйц сайн туршлагыг тодорхойлоход туслах зэрэг болно.

Залуучууд, оюутан сурагчид болон тэдний эрх ашгийг хамгаалах байгууллагууд нь өвөрмөц туршлага бүхий үндсэн түнш бөгөөд Боловсрол 2030 хөтөлбөрийн нэгэн чухал зорилгот бүлэг юм. Тэд идэвхтэй, хариуцлагатай суралцагч учраас сургалтын үйл ажиллагааг сайжруулахын тулд тэдний шаардлага хэрэгцээг тодорхойлох нь хамгийн чухал. Тэдгээр бүлгүүд санал байр сууриа илэрхийлэх, идэвхтэй оролцох боломжоор хангагдахад туслалцаа дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Тэд дараах зүйлсийг хийж чадна:

- Залуучуудад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулахад засгийн газар болон бусад түншүүдэд туслалцаа үзүүлэн залуучууд, ялангуяа эмзэг, ядуу бүлэгтэй зөвлөлдөн, тэдний хэрэгцээ, хүсэл тэмүүллийн талаар илүү ойлголт өгөх;
- Бодлого тодорхойлоход тусалснаар зохих нийцтэй боловсролын тогтолцоог бүрдүүлэн суралцах үйлээс зохистой ажлын байр, насанд хүрэгчдийн амьдралд саад бэрхшээлгүй шилжихэд туслана;
- Бүх насныхны яриа хэлэлцүүлэгт оролцох, хүүхдүүд, өсвөр үе,

залуучууд, ялангуяа охид, залуу бүсгүйчүүдийг хариуцлага хүлээх бүрэн эрхт тал гэж үзэн боловсролын бүх шатны бодлого, хэрэгжилтэнд хүлээн зөвшөөрөн тусгана.

Үр дүнтэй зохицуулалт

Боловсрол 2030 хөтөлбөрийн амжилттай хэрэгжилт хамтын хүчин чармайлтаас шууд хамааралтай. Хууль, бодлогын хөтөлбөрүүд нь хариуцлага, ил тод байдлыг дэмждэг ба түүнчлэн бүх түвшинд бүх салбарт оролцооны засаглал, зохицуулалттай хамтын ажиллагаа нь бүх оролцогч талуудын оролцох эрхийг дээдлэхийг эрхэмлэн зорих хэрэгтэй байна. Боловсрол 2030 үйл ажиллагааны хөтөлбөрийн ойлголт нь бүх түншүүдийн хувьд ижил байж хариуцлага хүлээх ёстой: олон талт байгууллагууд нь өөрсдийн оролцогч улс, боловсролын яам ба иргэний хамааралтай бусад яамд, үндэсний засгийн газар, иргэд, сургууль, багш нарын өмнө тухайн хүн амын болон илүү өргөн хүрээнд иргэний боловсролын хувьд хариуцлага хүлээнэ

Боловсролын тогтвортой хөгжлийн зорилго болон тогтвортой хөгжлийн боловсролд хамааралтай бусад зорилтуудын хэрэгжилтийг боловсролын яам удирддаг бол үндэсний хэмжээнд “засгийн газар бүхэлдээ” боловсролд анхаарлаа хандуулахын шаардана. Мэдлэгт тулгуурласан нийгмийг бүтээх болон өсөн нэмэгдэж байгаа тэгш бус байдалд боловсролын үүрэг оролцоо бий, түүнчлэн боловсролын шинэ хөтөлбөрт насан туршид суралцах талаарх ойлголтыг шинэчилж, илүү хүчирхэг манлайлал, зохицуулалт болон засгийн газрын боловсролын хөгжил ба түүнтэй хамт нийгэм эдийн засгийн илүү өргөн хөтөлбөр дээр хамтран ажиллах

шаардлагатай. Хэдийгээр боловсролын талаарх томоохон зорилтууд дан ганц засгийн газрын оролцоотой биелэгдэхгүй байж болох талтай ч улс орныг удирдан залах хандлага өөрчлөгдөнө. Бүх оролцогч талууд, үүнд төрийн бус оролцогчдын дэмжлэг хэрэгтэй. **Засгийн газар** нь НҮБ-ын дэмжлэгтэйгээр бүс нутгийн болон дэлхий нийтийн хяналтын үйл ажиллагаанд зориулан мэдээллийн эх үүсвэрийн шаардлагатай механизмыг бүрдүүлэх, одоогийн механизмыг бэхжүүлэх нь зүйтэй. Засгийн газар мөн боловсролын бодлого, стратегийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтанд бүх оролцогч талуудыг бодитоор оролцуулах замаар бүх салбар, бүх түвшинд боловсролын хөгжлийг дэмжих арга хэмжээг удирдах, зохицуулах, эрчимжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах хэрэгтэй. Түүнчлэн дэмжлэг үзүүлэгч байгууллага, хоёр болон олон талт байгууллагаас үзүүлж буй гадаад туслалцааг улс орон өөрөө эзний ёсоор хандан зөв, зохистой арга хэлбэрээр зохицуулна.

Дүгнэлт

Бид, олон улсын боловсролын хамтын нийгэмлэг бүх хүн насан туршдаа суралцах боломжийг дэмжихийн хамт, тэгш боломж олгосон, тэгш хамруулсан, чанартай боловсролыг хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд хүргэхийн тулд бүхнийг

хамарсан шинэ хандлагын төлөө тууштай нэгдэн зогсож байна. Бид боловсролын бүх зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд хамтдаа ажиллах бөгөөд энэ нь мөнхүү дэлхий даяар боловсролын төлөө олон улсын хамтын ажиллагааг өрнүүлэх болно. Бид их хэмжээний нэмэлт санхүүжилтийн шинэ зорилтуудыг биелүүлэхэд шаардлагатай бөгөөд нөөц Мөн бид боловсролын шинэ зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд их хэмжээний нэмэлт санхүүжилт шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрөхийн хамт Боловсрол 2030 хөтөлбөрийг ахиц дэвшилд хүргэхийн төлөө эдгээр нөөцийг хамгийн үр өгөөжтэй байдлаар ашиглах ёстой. Мөн бид боловсролын салбарт иргэдийн манлайлсан хариуцлагатай байдал, сайн засаглал шаардлагатай болохыг онцлон тэмдэглэж байна. Боловсрол 2030 нь боловсролын тогтолцоонд түүхэн амжилт гаргана гэдэгт итгэн, боловсрол нь дэлхий дээрх хүн бүрийн амьдралыг өөрчлөхийн төлөө эрч хүчтэй, шинэлэг, тогтвортой үйл ажиллагаа өрнүүлэхээ амлаж байна. Боловсрол 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь хүн бүр амжилтаа зарлан тунхаглаж чадсан тэр үед л түүний хэрэгжилт, амжилтыг зарлаж болно гэсэн үг билээ.

Орчуулсан Ч.Алтангэрэл

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ЗОЧНЫ ЯРИА

УУЛ УУРХАЙГААС ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ:
ТАЛУУДЫН БАЙР СУУРЬ

“Оюу Толгой”, “Таван Толгой”, “Эрдэнэс Таван Толгой”, “Энержи ресурс” зэрэг Монгол Улсын уул уурхайн стратегийн орд газрууд ашиглалтад орсноор улс орны болон бүс нутгийн хэмжээнд үлэмж хэмжээний хөрөнгө оруулалтыг татаж чадсан юм.

Эдгээр уурхайн үр нөлөөгөөр Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс зэрэг сумдууд богино хугацаанд үсрэнгүй хөгжиж, дэд бүтэц, зам тээвэр, харилцаа холбоо, гэрэл цахилгааны асуудлуудаа бүрэн шийдвэрлэсний дээр тухайн сумдын иргэдийн орлого, амжиргааны түвшин мэдэгдэхүйц дээшилж чадсан байна.

Дээрх төслүүд нь уул уурхайн салбарт хөдөлмөрийн аюулгүйн байдлын дэлхийн стандартыг нутагшуулж, байгаль орчинд ээлтэй, ард иргэдэд өгөөжтэй, ажилтан албан хаагчдынхаа нийгэм, соёлын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, нийгмийн хариуцлагаа ухамсарласан тэргүүний аж ахуй нэгж болохоор сэтгэл, зүтгэл гаргаж ажиллаж буйг нь цохон тэмдэглэмээр байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын хэсэг Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй дээрх төслүүдийн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрх, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг задлан шинжлэх зорилгоор уул уурхайн компанид ажиллаж буй ажилчид, нөлөөллийн бүсэд амьдарч буй малчин, уул уурхай бүхий орон нутгийн удирдлагууд, төрийн албан хаагчидтай бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагуудыг хийсэн билээ.

“Хүний эрх” сэтгүүлийн зочны ярилцлага буландаа Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн малчин Д.Дорждэрэм, Оюутолгой компанийн жолооч А.Мөнхзолбоо, Х.Отгонбаяр нартай хийсэн ярилцлагыг толилуулж байна. Та бүхэн доорх ярилцлагуудыг уншаад өөрсдийн дүгнэлтээ хийх биз ээ.

“ӨСӨХ ЗООС” КОМПАНИЙН ЖОЛООЧ А.МӨНХЗОЛБОО:
БИД НАР МАШ ЖАРГАЛТАЙ АЖИЛЛАДАГ

Оюутолгой компанийн гэрээт тээвэрлэгч “Өсөх Зоос” компанийн жолооч А.Мөнхзолбоо, “Өмнийн говь” компанийн жолооч Х.Отгонбаяр нартай уул уурхайн тээвэрлэлтийн нөхцөл байдлын талаар ярилцлаа.

Та хоёр Оюутолгой ХК-д хэдэн жил ажиллаж байгаа вэ?

Х.Отгонбаяр: Би 3 жил гаруй хугацаанд ажилласан.

А.Мөнхзолбоо: Би энд ирээд жил орчим болж байна.

Тээвэрлэлтийн явцад үзэгдэх орчныг

хязгаарлахуйц тоос шороо босдог уу?

Х.Отгонбаяр: Зэсийн баяжмалыг Оюутолгой компанийн хатуу хучилттай замаар тээвэрлэдэг учраас тоос босдоггүй байсан. Харин саяхнаас нүүрсний тээвэр идэвхэжсэнээс үүдээд хэсэг газар шороо тоос босч байгаа.

Уурхайгаас баяжмалаа ачаад хил давах хүртэл хэдий хугацаа зарцуулдаг вэ?

Х.Отгонбаяр: Уурхайгаас хил давах хүртэл 110 орчим км зайтай. Нэг талдаа 2 цаг явдаг. Бид бүхэн өөрсдийнхөө /Оюутолгой компанийн тавьсан зам/ замаар тээвэрлэдэг учраас түгжрэл удаашралд орох асуудал байдаггүй. Хурд сааруулагч, зогс гэсэн тэмдэг тэмдэглэгээн дээр зогсоод явахад л 2 цаг болдог. Бидний дээд хурд 75 км цаг. Үүнээс хэтрүүлж болохгүй. Бидний машин GPS-тэй учраас төвөөс давхар хянаж байдаг.

Нүүрс тээвэрлэдэг жолооч нартай ярилцаж байхад сүүлийн үед осол аваар их болсон. 7 хоногт 9 осол гарч 3 хүн нас барсан харамсалтай хэрэг гарсан тухай ярьж байсан. Та бүхэн тэр осолтой тааралдсан уу?

Х.Отгонбаяр: Үгүй. Бид нар баяжмалаа аваачих цэгт очих хүртлээ яг өөрсдийнхөө замаар явдаг. Харин буцаж ирэхдээ 19 км газарт шороон замаар явдаг. Нүүрсний очерын хажуугаар явдаг. Ямар нэгэн осол авартай таараагүй.

Та бүхэн хэд хоног ажиллаад хэд хоног амардаг вэ?

Х.Отгонбаяр: 28 хоног энд ажиллаад, 14 хоног амардаг.

Гэр бүлээсээ удаан хугацаанд хол байх хэцүү биш үү?

Х.Отгонбаяр: Одоо тэгээд сурчих юм өө.

Хүмүүс бие холдохоор сэтгэл холдоно гээд ярьдаг ш дээ. Энд ажиллаж байгаа хүмүүсийн хувьд гэр бүл салалт хэр их байдаг вэ?

Х.Отгонбаяр: Гайгүй байхаа. Гэр бүл салалт гэдэг тухайн хүнээсээ их шалтгаалдаг байх. Ямар ч л гэсэн манай хамт олны дундаас хэн нэгэн нь саллаа гэсэн зүйл сонсож байгаагүй.

Гэр бүлээсээ хол сар гаруй хугацаанд байх хэцүү байдаг уу?

Х.Отгонбаяр: Би өмнө нь Солонгост гурван жил ажиллаад ирсэн. Тиймээс 28 хоногт огт ажирдаггүй. 3 жил тусдаа амьдрахдаа салаагүй юм чинь 28 хоногт салаад явчихгүй биз. /Инээв/

А.Мөнхзолбоо: Манай гэр бүлд ямар нэгэн асуудал гардаггүй. Залуу хүний хувьд гэр бүлээсээ хол 28 хоног байна гэдэг асуудал л даа. Гэхдээ яваандаа сурчихдаг юм байна.

Дам яриа сонсож байхад тээврийн жолооч нар машиныхаа кабинд жаахан охин суулгаад явдаг гэх юм?

А.Мөнхзолбоо: Би 2009-2013 онд нүүрсний тээвэрт явж байлаа. Тэгэхэд тийм зүйл байдаг л байсан. Тэр бүү хэл сольркаар биеэ үнэлдэг охид хүүхнүүд ч байдаг байсан. Гэхдээ би бол авч үзээгүй л дээ. 60 л сольркаар 1 рессэнд цуг явдаг хүүхнүүд байдаг талаар жолооч нар ярьдаг байсан. Гэхдээ сүүлийн үед огт харагдахаа байсан гэсэн.

Х.Отгонбаяр: Нүүрсний тээврийнхэнд тийм зүйл байдаг юм шиг байна лээ. Бид нарт бол ямар ч тийм зүйл байхгүй. Байх ч боломжгүй. Яагаад гэвэл бид нар байнгын хяналттайгаар ажилладаг. Камерын хяналттай. Ямар нэгэн зогсох асуудал гарсан тохиолдолд цуваан даргаасаа зөвшөөрөл авдаг.

А.Мөнхзолбоо: Эндээс хөдөлсөн цувааны 16 машин хил давж ачаагаа буулгах газартаа хүртлээ яг зэрэг явсаар байгаад л очдог. Нэг хэсэг нь түрүүлж очоод хүлээнэ барина гэсэн зүйл байдаггүй. Цувааны машинууд хоорондоо 200 метрийн зайтайгаар зорчдог.

Бидний хувьд Хятадад яг энэ Оюутолгой шиг кемптэй. Кемпийнхээ хашаанаас гарахыг хатуу хориглодог. Тиймээс зэсийн баяжмалаа аваачиж буулгаж хоночхоод маргааш нь гааль

онгойхоос өмнө цуваагаараа давхиад л гараад явчихдаг учраас биеэ үнэлэгчтэй таарч байсангүй.

Та бүхний барьдаг машин 75 км/цагийн хурдтай явж байгаад огцом зогсох шаардлагатай боллоо гэж бодье. Хэдэн метрт бүрэн зогсолт хийх үү?

А.Мөнхзолбоо: Асар их инерцтэй учраас 100 орчим метр зам туулна. Гэхдээ баяжмал чинь харьцангуй хөнгөн нэг машин 36 тн баяжмал ачиж явдаг. Машиньхаа жинг оролцуулаад тооцоход нийтдээ 50 гаруй тн болдог. Тэгэхэд нүүрсний машинууд 80-аас дээш тн ачаатай явна ш дээ.

Нүүрсний үнэ дэлхийн зах зээлд өссөнтэй холбоотойгоор тээвэрлэлт эрс сэргэсэн гэж хүмүүс ярьж байна. Саяны өдрүүдэд хил дээр 90 км урт очер үүссэн тухай нэг сайд жиргэсэн байсан?

Х.Отгонбаяр: 90 бол худлаа. Гэхдээ 30 гаруй км урт очер бол байсан. Тийм урт очер чинь 2-3 хоног үргэлжилнэ. Нүүрснийхэн чинь 7 хоногтоо гүрийгээд хоёр удаа явдаг. Надад нэг бодол байдаг юм. Цагаан хадан дээр нүүрсний жолооч нар 4 постыг гаталдаг. Тэр постуудынх нь хооронд жолооч нар амрах ямар ч талбай, зогсоол гэж байдаггүй. Хэрвээ талбай гаргаад өгчих юм бол жолооч нар машинаа зогсоолд тавьчихаад тэр хавийнхаа гуанзаар орж хоол унд идчихээд унтаж амраад явна шүү дээ. Одоо яаж байна гэхээр учиргүй олон машинууд цувж зогсчихоод ачаалал үүсгээд байж байна. Жолооч нарт амрах, зогсох боломж огт байдаггүй. Тэнд жаахан менежмент хэрэгтэй байгаа. Тэгчих л юм бол түгжрэл ч үүсэхгүй, осол аваар ч гарахгүй. Монгол хүн хөдөлмөр эрхлэхдээ яагаад өөрсдөдөө ая тухтай байдлаар хийж болдоггүй юм. Нүүрс ачаад ирсэн жолооч Цагаан хадан дээр яагаад сайхан амарч

болохгүй гэж. Нүүрс олборлодог уурхайн компаниуд жаахан сэтгэл гаргачхад л энэ асуудлыг бүрэн шийдвэрлэж болно. Гэтэл тэгдэггүй. Тэгэхэд Хятадад ямар гэж санана. Хилийн давангуут л жолооч нарын амрах талбай байж байгаа. Хятадууд чинь хачин тухтайгаар ажилладаг ш дээ. Гэтэл манай жолооч нар хил дээр шөнөжин очерлож урагшилсаар байгаад л өглөө нь эргээд харахад 200 метр л ахисан байдаг гэсэн. Үүнээсээ болоод маш их ядарч аваар осол их гаргадаг байх.

Та хоёрт мэргэжлээс шалтгаалах өвчин байдаг уу?

Х.Отгонбаяр: Байхгүй. Бид нар жил болгон эмчийн бүрэн шинжилгээнд хамрагддаг. Ямар ч өвчин хууч илрээгүй.

А.Мөнхзолбоо: Байхгүй. Ер нь Оюутолгойн баяжмал зөөдөг жолооч, нүүрсний жолооч хоёр өдөр шөнө шиг ялгаатай. Бид нар их жаргалтайгаар ажилладаг. Бидний амьдардаг орчныг ямар тухтай гэж санана. Өглөө ажилдаа яваад л орой буцаад ирэхэд хувцсыг маань угаагаад эвхээд тавьчихсан байдаг. Үл үзэгдэгч эхнэртэй хүн шүү дээ бид. /Инээв/

Уул уурхайн түүхий эдийн тээвэртэй холбоотойгоор малчдаас гомдол эсэргүүцэл гардаг уу?

Х.Отгонбаяр: Түүхий эдээ засмалаар тээвэрлэдэг болсноос хойш тийм асуудал гарахаа больсон. Шороон замтай байхад нүүрсэн дээр хэл ам их гардаг байсан. Манай Оюутолгой компани эндээс Цагаан хад хүртэл 80 гаруй км замд засмал замаа тавьчихсан. Одоо үлдсэн 19 км замд засмал замаа тавьж байгаа. Энэ жилдээ багтаад ашиглалтад орчих байх. Тэгэхээр хэл ам бүр ч гарахгүй байх.

Оюутолгой компани зөрчил гаргасан жолоочтой ямар хариуцлага тооцдог вэ?

Х.Отгонбаяр: Манай компани Оюутолгойтой гэрээ байгуулсан гэрээт компани. Зөрчил гаргасан тохиолдолд зөрчлийн хуудас бичнэ. Үнэмлэх цоолно. 3 цоолуулсан жолоочид та Оюутолгойд жолоочоор ажиллах боломжгүй гэж хэлээд гэрээг цуцалдаг.

Таны цалин хэд вэ?

Х.Отгонбаяр: 1500000 төгрөгөөс нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг нь хасаж суутгаад өгдөг. Гар дээр 1300000 орчмыг л авдаг.

Орон сууцтай болоход дэмжлэг үзүүлдэг үү?

А.Мөнхзолбоо: Тийм зүйл байхгүй байгаа. 2 жил тогтвор суурьшилтай ажилласан хүнд жижиг зээл өгдөг гэж дуулдсан. Гэхдээ би авч байгаагүй.

Явдаг нүүрс, ачдаг нүүрс гэх хэллэг одоо байгаа юу?

А.Мөнхзолбоо: Нүүрсэн дээр бол байгаа байгаа. Оюутолгойд бол байхгүй.

Нүүрсний тээвэрчид л хэл ам таталдаг байх нь ээ?

Х.Отгонбаяр: Нүүрсний тээвэрчид дундаа Хятадууд бүр онцгой аюултай. Яагаад гэхээр Хятадад ямар ч дүрэм гэж байдаггүй учраас ч тэр үү буруу зөв гэхгүй шууд л дайрцгаадаг. Хятадууд тэр дүрэмгүй жолоодлогоороо өөрсдөө бол болоод байдаг юм билээ. Харин тэр сурцаараа Монголд ирэхээрээ осол аваарын эх үндэс болдог. Одоо Хятадаас 300 гаруй жолооч орж ирэх гээд байгаа дуулдсан. Тэгвэл бөөн асуудал үүснэ дээ.

Ярилцсанд баярлалаа.

Д.ДОРЖДЭРЭМ: МАЛЫН ДОТОР ЭРХТНҮҮДИЙГ ХҮНСЭНД ХЭРЭГЛЭХИЙН АРГАГҮЙ БОЛСОН

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн малчин Д.Дорждэрэмтэй ярилцлаа.

Сайн байна уу? Танайх хаагуур нутагладаг вэ?

Манайх Оюутолгойн хажууханд хаваржиж, намарждаг. Харин өвөлжөө бууц маань Жавхлант багийн хажууханд нүүрсний замаас километр хүрэхгүй зайтай байдаг.

Уул уурхай бүтээгдэхүүний тээвэрлэлтээс үүдэлтэй бэрхшээлүүд малчдад тулгарч байна уу?

Малын эрүүл мэнд ихээр хохирох болсон. Бид өөрсдийгөө тэр болгон эмчид үзүүлж, рентген зургаа авахуулж чаддаггүй учраас чухам яаж хохирсноо мэдэхгүй байна. Мал төхөөрөхөд дотор эрхтнүүд нь хүнсэнд хэрэглэхийн аргагүйгээр хордсон байдалтай байх боллоо. Элэг, уушги хатууралтай, усжилттай. Эрүүл ахуйн

шаардлага хангахааргүй болсон байна. Тоосжилтоос ч болдог юм уу, малын нүд их өвдөж, туурай нь хагарах нь энгийн үзэгдэл болоод байна.

Уул уурхайнууд компаниуд нөлөөллийн бүсдээ байгаа айлуудаас хүнсэнд хэрэглэх мал, махаа худалдан авч дэмжлэг үзүүлдэг үү?

Оюутолгой компани уг нь мал, мах авъя л гэдэг юм. Гэвч манайх худалдаад зараад байхаар тийм олон малтай биш. Өөрийнхөө болон хүүхдүүдийнхээ хэрэглээг хангаад байхуйц цөөн тооны малтай. Ганц нэгийг нь яах вэ сум уруугаа оруулж ирж, цайны газартаа нийлүүлдэг.

Таны болон танай гэр бүлийнхний эрүүл мэндэд өөрчлөлт, өвчлөлтийн шинж тэмдэг илэрсэн үү?

Би урьд нь ханиад томуу хүрдэггүй хүн байсан. Сүүлийн жилүүдэд ханиаданд өртөмтгий болсон.

Танай мал сүргийг тээврийн жолооч нар дайрч гэмтээсэн тохиолдол гарсан уу?

Нүүрсний зам тавигдахаас өмнө манайх 3 тэмээгээ дайруулсан. Нэг хөхүүл ингэ маань орой задгай усанд очихоор явж байхад нь хувиараа тээвэр хийдэг жолооч дайрч алсан байсан. Биднийг очиход ингэ маань дээшээ харчихсан, дэлэн нь сэрийж, сүү нь савирсан байдалтай байсан. Тэр жолооч өөрийнхөө буруугаа хүлээгээд хохирлыг нэн даруй барагдуулж өгсөн. Харин хээлтэй гунжийг минь дайрсан хэрэг огт илрээгүй. Эзэн холбогдогч нь олдохгүй байна гэсээр байгаад хэрэг хаагдсан. Өөр нэг хээлтэй ингэ маань нүүрсний зам дээр дайрагдсан. Гэмт буруутай этгээд нь явж явж Энержи Ресурсын жолооч болж таарсан. Тус компаниас орон нутаг хариуцсан Доржсүрэн гэдэг хүн ирж уулзаад эзэн холбогдогч нь эцэслэн тогтоогдсон ч бай, үгүй бай манай компани хохирлыг бүрэн барагдуулна. Та нэг сар хүлээх хэрэгтэй. Сарын дараа хурлаар хэлэлцэж, дүгнэлтийг гаргаад хохирлыг барагдуулна гэж хэлээд хэдэн сарын турш ор сураггүй болсон. Би хэдэн сарын дараагаас тэр хүн рүү ойр ойрхон залгаж учрыг лавлахаар 7 хоногийн дараа хариу өгнө тэсэж бай гэдэг болсон. 7 хоног нь өнгөрөхөөр 2 хоног л тэсчих гэдэг байсан. Би Доржсүрэнд “Танай жолоочид дайрагдсан ингэ минь залуухан хээлтэй ингэ байсан. Хэрвээ тэрнээс охин ботго гарсан бол ямар олон болох байсан гэж санана. Та нар манай хохирлыг барагдуулж 3 сая төгрөг өгөөрэй” гэж хэлэхэд за гэж тохирсон мөртлөө утсаа авахаа байсан. Уг хэрэг 2011 онд гарсан шүү дээ. Өнөөг хүртэл 5 жилийн турш энэ асуудал шийдэгдээгүй.

Та энэ асуудлаар цагдаагийн байгууллагад хандсан уу?

Хамгийн анх цагдаагийн байгууллага уруу хүүхдүүдээ явуулахад завгүй байна гээд очоогүй. Харин манай сумын малын эмч н.Сайнхүү хэргийн газарт очиж тодорхойлолт гаргаж өгч байсан. Хүүхдүүд маань хэргийн газарт очиж зургийг нь олон талаас нь дараад түүнийгээ олон хувь угааж холбогдох газруудад өгсөн. (Зургуудыг үзүүлэв)

Уул уурхайн олборлолт эхэлснээс хойш байгаль орчинд ямар нөлөө үзүүлж байна?

Нөлөө үзүүлэлгүй яах вэ. Тухайлбал Ундайн голын гольдрилыг өөрчилнө, малчдаас зөвшөөрөл авна гэж хэсэг хүн явдаг байсан. Тэрийг нь нэг ч малчин зөвшөөрөөгүй. Тэгтэл сүүлдээ төрөөс зөвшөөрөл өгсөн. Та нарын зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй ажлаа хийнэ гээд өөрчилсөн. Барваагийн задгайг мөн өөрчилсөн. Үүнээс үүдээд Ундайн голын гольдрил дагуу ургасан хайлааснууд унах болсон. Саяхан намайг Байшинт гэдэг газарт очих үед хоёр сайхан Хайлаас ногооноороо ойчсон байна лээ. Говь нутагт модыг тэнгэр ниргэх тохиолдол их гардаг. Гэхдээ тэр бол тэнгэр ниргэснээс болоогүй байсан. Аянгад ниргүүлсэн мод хар өнгөтэй болоод задарсан байдаг бол тэр хайлаас зүгээр л унасан байсан.

Уул уурхайн бохир агуулдаг далан нь Будаа гэдэг газрын хавьд шүүрч байна гэж малчид ярьж байсан. Манай сумын төрийн бус байгууллагын ажилтан Батцэнгэл гэдэг хүн тийшээ очоод зураг хөргийг нь дараад ирсэн байна лээ. Би гэрт нь очиж тэр зургийг нь харсан.

Бид Оюутолгой компанийнхан уулзахад манай компани цэвэр усны хамгийн олон цэгийг шинээр би болгосон.

Улсын хэмжээнд хамгийн олон уст цэгтэй сум бол Ханбогд гэж ярьж байсан?

Малчдад худаг гаргаж өгөөгүй биш, өгсөн. Тэрийгээ ярьж байгаа байх. Хийсэн юм чинь ярилгүй ч яах вэ? Гэтэл малчдад гаргаж өгсөн худаг нь ундарга муутай. Хэд ховоодохоор л дуус чхаад байгаа. Урьд цагт худаг цөөн ч гэлээ ундарга сайтай байлаа. Одоо тийм биш болсон. Жишээлбэл Гавилууд багийн малчин Пүрэвдоржийнд худаг гаргаж өглөө л гэсэн тэр нь ширгэсэн. Жавхлант багийн ард Тохой гэдэг газарт Энержи Ресурсаас манайд гаргаж өгсөн худаг ширгэж байгаа. Мөн манай багийн Намсрайн худаг ширгэж байгаа гэж байна лээ. Энд тэндэхийн худгууд ширгэлээ гэж дуулдаад л байгаа. Уул нь малчин айл болгоны өвөлжөөн дээр худаг гаргаж өгсөн. Тэр нь ингээд ширгээд байгаа.

Уул уурхайтай холбоотой өөр ямар бэрхшээлүүд малчдад нүүрлэж байгаа вэ?

Намаржих, өвөлжих газар хомстой болсон. Урагшаа говь уруугаа алс нүүе гэхээр сургууль соёлын хүүхэдтэй учраас болохгүй юм. Дээрээс нь хол нүүе гэхээр унаа цуцаа, машин тэрэг, бензин шатахуунаас аваад асуудал мундахгүй шүү дээ.

Та бүхний өвөлжөө, намаржааг талхалсан уул уурхайн компаниудын зүгээс та бүхэнд нөхөн олговор болон бусад дэмжлэг туслалцаа үзүүлдэг үү?

Оюутолгой компани Ундайн голын гольдрил өөрчилсний учир 59 айлд нөхөн олговор өгнө гэж байсан. Тэтгэлэгт хамруулна гэх боловч өнөөг хүртэл өгсөн барьсан зүйл байхгүй. Манайх нүүрсний зам дагуу байрлалтай мөртлөө тэтгэлэг авч чадаагүй.

Уул уурхайн компаниуд бид нүүрсийг шороон замаар тээвэрлэхээ больсон.**Тиймээс тоос шороо босохоо больсон. Малчдад түвэг чирэгдэл учруулдаггүй гэж байсан?**

Тоос шороо байг ээ гэхэд тэр олон машины утаа угаарууд амьтан, ургамал ногоонд нөлөөлж байгаа шүү дээ. Зам дагуух ургамлууд тасралтгүй цувж байгаа машины утаа угааранд хордсон л байж таарна. Тэгэхээр хортой өвс идсэн малаар хооллосон хүн яах вэ? Хордож л таарна биз дээ.

Уурхайнуудын зүгээс өөрсдийн нөлөөллийн бүсэд байгаа айлуудын хүүхдүүдэд сургалтын төлбөрийн тэтгэлэг, дэмжлэг үзүүлдэг гэж байсан? Төгсөөд ирсэн залуусыг ажилд авах зэргээр амьдрал ахуйд тань хэр нэмэр болж байна?

Сургалтын тэтгэлэг өгч байна гэж ярьж л байдаг юм. Манайх хоёр оюутантай байсан. Нэг охин маань өнгөрсөн жил Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг Уул уурхайн менежмент мэргэжлээр дүүргэсэн. Нэг хүү маань БНХАУ-ын Ордосын анагаах ухааны сургуулийг бариа засаглалын чиглэлээр төгссөн. Энержи ресурс компани охины минь 1 жилийн сургалтын төлбөрийг дааж байсан. Мөн тус компанийн зүгээс хоёр жилийн хугацаанд сарын зуу гаруй мянган төгрөгийн цалинтай замын аюулгүй байдлын харгалзагч гэдэг улирлын чанартай ажил хийлгэж байсан. Тэр ажил нь жилдээ 6-7 сар үргэлжилдэг. Нүүрсний замаар гарч байгаа мал хуйг зохицуулах ажил байдаг юм. Одоо гэрээ дууссан гэдэг үндэслэлээр тэр ажил хэрэгжихээ байсан.

Ярилцсанд баярлалаа.

*Хүний эрхийн Үндэсний Комиссын
хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан
С.Будрагчаа*



UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, Ү давхар
Утас: 266506, 262902, Факс: 976-11-320284
Цахим хаяг: www.mn-nhrc.org, Цахим шуудан: info@mn-nhrc.org
Иргэдээс гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх утас: 70000222

